


GOBI
MONGOLIAN CASHMERE

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2021

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

## МАНАЙ КОМПАНИ

07 Компанийн ерөнхий танилцуулга
10 Түүхэн замнал
12 ТУЗ-ийн даргын мэндчилгээ
14 Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

## 2021 ОНД БИД

18 Тэргүүн дэд захирлын мэндчилгээ
20 Бидний амжилт, онцлох үйл явдлууд
22 Санхүү хариуцсан дэд захирлын мэндчилгээ
24 2021 оны санхүүгийн үр дүн

## БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

38 Борлуулалт, дизайн, үйлдвэрлэл хариуцсан дэд захирлын мэндчилгээ
40 Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, шинэ технологи
41 Коллекцууд
42 Дотоод зах зээл
44 Гадаад зах зээл
46 Онлайн хариуцсан дэд захирлын мэндчилгээ
48 Онлайн худалдаа

## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ (БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ)

58 Ноолуурын салбар
59 Тогтвортой хөгжлийн удирдлага
63 Байгаль орчин
67 Нийгэм
73 Засаглал
- Засаглалын бүтэц, үйл ажиллагаа
- Хувьцаа эзэмшигчид
- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Дотоод хяналтын тогтолцоо
- Компанийн бүтэц
- Компанийн эрх бүхий албан тушаалтнууд
- Хөрөнгийн зах зээл ба компанийн хувьцаа
- Ногдол ашиг

## ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

110 Хараат бус аудиторын тухай мэдээлэл
111 Говь ХК болон түүний охин компаниудын аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан





# МАНАЙ КОМПАНИ







# КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| **Компанийн оноосон нэр** | ГОВЬ хувьцаат компани |
| **Үйл ажиллагааны чиглэл** | Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах |
| **Компанийн албан ёсны хаяг** | Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК<br>Шуудангийн хаяг: Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг 36/434, Говь ХК<br>Утас: (976)-70139977<br>Факс: (976)-70143081<br>И-мэйл: info@gobi.mn<br>Веб сайт: info.gobi.mn<br>Фэйсбүүк: GobiCashmere<br>Онлайн дэлгүүр:<br>Монгол: gobi.mn<br>Европ: gobicashmere.com<br>Америк: gobicashmere.com/us<br>Хятад: gobicashmere.cn |
| **Компанийн удирдлага** | ТУЗ-ийн дарга: Дамбын ГЭРЭЛМАА<br>Гүйцэтгэх захирал: Цагаачийн БААТАРСАЙХАН |
| **Үүсгэн байгуулагдсан огноо** | 1981 оны 9 сарын 5-ны өдөр |
| **Ажилтнуудын тоо** | 1,527 |
| **Үйлдвэрийн хүчин чадал** | 1,150 тонн түүхий ноолуур боловсруулах<br>1,050 тонн ээрмэл утас, 30 тонн нарийн ээрмэл утас хийх<br>1,500,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх<br>1,100,000 метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх<br>162,000 ширхэг ноолууран пальто болон пиджак үйлдвэрлэх |

| **Дэлгүүрийн тоо** | Дотоод | Гадаад |
|---|---|---|
| | Улаанбаатар хот 2 | Охин компани 3 |
| | Дархан хот 1 | Салбар дэлгүүр 1 |
| | | Франчайз дэлгүүр 27 |
| | | Онлайн дэлгүүр 12 |

# БИЗНЕС ЗАГВАР/БИДНИЙ ҮНЭ ЦЭН

## ХҮНИЙ НӨӨЦ

Говь ХК-ийн гол нөөц болох хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах замаар өндөр гүйцэтгэлд суурилсан бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хамт олныг бий болгон байгууллагын тогтвортой хөгжлийг хангана.

## ОЮУНЫ НӨӨЦ

Говь ХК-ийн ирээдүйн үнэ цэнийн баталгаа бол бидний оюуны өмч, брэндүүд, зах зээлд эзлэх байр суурь, технологийн ноу-хау юм.

## БАЙГАЛИЙН НӨӨЦ

Бидний үнэ цэн бүтээх үйл явцад ашиглагддаг шавхагддаг болон шавхагдашгүй нөөцүүд болох түүхий ноолуур, бэлчээр, ус, агаар, хөрс зэргийг бид тогтвортойгоор, зохистойгоор ашиглах нь ирээдүйн сайн сайхны үр үндэс юм.

## САНХҮҮГИЙН НӨӨЦ

Өөрсдийн үйл ажиллагааны болон дотоод гадаадын банк санхүүгийн байгууллагын эх үүсвэрийн оновчтой менежментээр бид санхүүгийн нөөцөө бүрдүүлнэ.

## ҮЙЛДВЭРИЙН НӨӨЦ

Түүхий ноолуураас бэлэн бүтээгдэхүүн хүртэлх цогц боловсруулалт, үйлдвэрлэлийн явцад хэрэглэгдэх байгальд ээлтэй дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмжүүд, техник технологи болон аюулгүй ажиллагаа бол бидний чухал нөөцүүдийн нэг юм.

## НИЙГЭМ, ХАРИЛЦААНЫ НӨӨЦ

Говь ХК-ийн бусад бүх оролцогч талуудтай үүсгэх тогтвортой, харилцан хүндэтгэсэн харилцаа нь компанийн үйл ажиллагааны тогтвортой байдал, тасралтгүй хөгжлийн суурь юм.

## БИДНИЙ ЗОРИЛТ

Говь ХК нь хүний хөгжил, технологиор тэргүүлэн, хэрэглэгч, харилцагчдын сэтгэл ханамжийг хамгийн өндөрт хүргэж, хөрөнгө оруулагч, ажилтнуудын үнэ цэнэтэй байгууллага байна

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- Шударга, ил тод, нээлттэй
- Хууль, дүрмийг чандлан сахиулна
- Хүний эрхийг дээдэлнэ
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулна










## УРИА ҮГ

НООЛУУРАН ХУВЦСЫГ ХҮН БҮРТ

## АЛСЫН ХАРАА

Амьдралын алхам бүрийг ноолууртай хамт

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Загварлаг, чанартай, нийцэмжит үнэтэй ноолууран хувцсаа дэлхийд таниулж, хүн бүрийг гоёно

МАНАЙ КОМПАНИ
2021 ОНД БИД
БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# ТҮҮХЭН ЗАМНАЛ

**1976**

UNIDO-ийн төслийн хүрээнд ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах туршилтын үйлдвэр ашиглалтад оров.

**1977**

Япон улсын Засгийн газраас БНМАУ-ын Засгийн газарт 5.0 тэрбум иений буцалтгүй тусламж олгож, Улаанбаатар хотноо ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэр байгуулах тухай Монгол-Японы Засгийн газрын хэлэлцээр байгуулав.

**1981**

Ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэрийн машин тоног төхөөрөмжийн угсралт, тохируулгын ажлыг гүйцэтгэн, технологийн шугамыг ашиглалтад хүлээн авч, Монгол-Японы хамтын ажиллагааны хүрээн дэх анхны байгууламж Говь үйлдвэр үүд хаалгаа нээлээ.

**1987**

Компьютерын автомат удирдлага бүхий Япон улсын SET-092сүлжих машиныг үйлдвэрт суурилуулав

**1991**

Олон улсын ISO-9000 стандартыг үе шаттайгаар нэвтрүүлж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 98 хувийг экспортлон Олон улсын чанарын цом,гэрчилгээг авсан Монгол улсын анхны үйлдвэр боллоо

**1993**

Монгол Улсын Засгийн газрын Өмч Хувьчлалын Комиссын тогтоолоор Говь УҮГ-ыг Говь ХК болгон зохион байгуулж, МХБ-д бүртгүүлэн, нийт дүрмийн сангийн 25.1% буюу 1,919,061 ширхэг хувьцаа нь хөрөнгийн биржээр арилжаалагдсан.

**1997**

Монголд анх удаа ноос ноолууран хөнжил, ноолууран давуу, драп, нарийн номерын ээрмэл утас үйлдвэрлэх "Говь-2" үйлдвэрийг ашиглалтад хүлээн авав.

**1998**

Гадаад зах зээлээ өргөжүүлэн Япон улсад "Алтай", Бельги улсад "Gobi Europe", АНУ-д "Gobi-USA" зэрэг охин компаниуд байгуулж, дэлхийн 30 гаруй оронтой түншийн харилцаа тогтоов.

**2000**

Утас будах технологи нэвтрүүлэв. Орчин үеийн компьютерын системд холбогдсон STOLL-330 сүлжих машиныг суурилуулав.

**2007**

Говь компанийн төрийн өмчлөлд байсан 73.45%-н хувьцааг"ЭФ СИ АЙ" ХХК Олон улсын нээлттэй дуудлага худалдаагаар худалдан авснаар Говь ХК хувийн эзэмшилд бүрэн шилжлээ.

**2008**

Үйлдвэрийн дэргэдэх Төв дэлгүүрийн барилгын дизайныг Японы алдарт архитектурч Сако Кейчиро хийж, шинэ дэлгүүр 6 сард нээлтээ хийлээ.

**2009**

Японы Токио хотод салбар дэлгүүрээ нээлээ. Италийн "VVA Consulting Company"-тай хамтран ажиллах гэрээг байгууллаа.Говь Үйлдвэрт техник, технологийн шинэчлэлтүүдийг үе шаттайгаар хийсэн.

**2010**

Говь үйлдвэр байгуулагдсаны 30 жилийн түүхт ойн хүрээнд Италийн алдарт загвар зохион бүтээгч Саверио Палателлатай хамтран ажиллах гэрээг байгууллаа. Монголын ноолуурын салбарт анх удаагаа Принт технологийг нэвтрүүлэв.

**2011**

Үйлдвэрлэлийн хүчин чадлаа 2 дахин нэмэгдүүлэв. Италийн алдарт хувцас загвар зохион бүтээгч Саверио Палателлатай хамтарсан анхны коллекци "Gobi by Saverio Palatel-la" коллекци худалдаанд гарлаа."Говь" ХК-ийн 30 жилийн ойг тэмдэглэв.

**2012**

Улаанбаатар хотын төвд Төв шуудангийн урд шинэ салбар дэлгүүрээ нээж хэрэглэгчдэдээ улам ойртлоо. Gobi by Saverio Palatella 2012 оны Намар, Өвлийн шинэ коллекцио гаргав.

**2013**

Үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж Whole Garment буюу оёдолгүй сүлжмэл бүтээгдэхүүний шинэ технологийг нэвтрүүлэв.

**2014**

Монгол ямааны ноолуурын үндсэн 4 өнгө болох цагаан, цайвар шаргал, бор, хөх саарал өнгийн ноолуурыг цайруулж будахгүйгээр байгалийн өнгөөр нь бэлэн бүтээгдэхүүн болгон гаргасан "Gobi-Mongolian Organic Cash-mere "брэндийг худалдаанд гаргалаа.

**2015**

Японы алдарт Киосера компанийн үндэслэсэн АМЁБ менежментийг бие даан нэвтрүүлж эхэллээ.

**2016**

100% ноолууран пальтоны үйлдвэрлэлээрээ дэлхийд №1 болно гэдгээ олон нийтэд зарлалаа. ХБНГУ-д анхны албан ёсны салбар дэлгүүрээ нээлээ.

**2017**

Оёмлын шинэ үйлдвэрийг ашиглалтад оруулан 100,000 ширхэг ноолууран пальто, пиджак үйлдвэрлэх хүчин чадалтай боллоо. Интернэт худалдааг эхлүүлж, өөрийн онлайн худалдааны www.gobicash-mere.com гэсэн сайттай болсон.

**2018**

Ээрмэлийн үйлдвэрт Италийн Bigagli мөлхөө ээрэх машиныг шинээр нэвтрүүлж, сүлжмэлийн бүх утсыг мөлхөө ээрэхэд шилжүүлж, утасны чанарыг сайжрууллаа. Мөн ноолууран пиджакийн масс үйлдвэрлэлийг эхлүүлж, дэлхийд ноолууран пиджак үйлдвэрлэлээрээ тэргүүллээ.

**2019**

Говь ХК нь Гоёо ХХК-г нэгтгэн авч, салбарын хамгийн том нэгдлийг амжилттай гүйцэтгэлээ.

**2020**

Говь ХК нь Төрийн дээд шагнал Сүхбаатарын Одонгоор шагнуулав. Онлайн сувгуудыг шинээр Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Норвегийн Вант Улс, Шведийн Вант Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын зах зээлд тус тус нээлээ.

**2021**

Говь ХК-ийн 1,500 ажилтан компанийнхаа хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч ажилтан боллоо.

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



ГОВЬ ХК-ИЙН ХУВЬД АЖИЛТНУУДЫНХАА ЭРҮҮЛ МЭНДИЙГ НЭН ТЭРГҮҮНД ЧУХАЛЧИЛЖ УОК, НОК-ИЙН ЗӨВЛӨМЖ, ЧИГЛҮҮЛГИЙГ ЧАНД МӨРДӨН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫНХАА ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАСРАЛТГҮЙ ЯВУУЛЖ АЖИЛЛАСАН ХЭДИЙ Ч МАНАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЭХ ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ БАЙСААР БАЙНА.







Хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэ онд Говь ХК маань 40 жилийн ойгоо тэмдэглэлээ. Анх 1981 онд байгуулагдсанаасаа хойш хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгч, харилцагчид болон компанийн удирдлага, ажилтнуудынхаа хичээл зүтгэл, хүч хөдөлмөрийн үр дүнд үйл ажиллагаагаа улам бүр өргөжүүлэн тэлсээр байна.

2021 оны хувьд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал үргэлжилсэн жил болж өнгөрлөө. Гэсэн хэдий ч улс орон бүр вакцинжуулалтыг эрчтэй хийж, дэлхий дахинд хүмүүс энэ өвчний талаар илүү их мэдээлэлтэй болж дасан зохицох, даван туулах чадвар нэмэгдсэн нь эргээд хэвийн ажил амьдралын байдалдаа шилжихэд дөхөм болж байна. Манай улсын хувьд ч мөн адил бизнесийн байгууллагууд болон хувь хүмүүсийн хариуцлагатай байдал, урьдчилан сэргийлэх зохион байгуулалт сайжран, улс орон даяар бизнесийн орчин сэргэн, харьцангуй идэвхтэй болж эхэллээ.

Говь ХК-ийн хувьд ажилтнуудынхаа эрүүл мэндийг нэн тэргүүнд чухалчилж УОК, НОК-ийн зөвлөмж, чиглүүлгийг чанд мөрдөн үйлдвэрлэл, борлуулалтынхаа үйл ажиллагааг тасралтгүй явуулж ажилласан хэдий ч манай үйл ажиллагаанд үзүүлэх цар тахлын нөлөө байсаар байна. Бид ирээдүйн урт хугацааны хөгжил дэвшлийг том зургаар харан, олон улсын зах зээлд илүү танигдах, өрсөлдөх, дэлхийн брэнд болох зорилгоор сүүлийн гурван жилийн хугацаанд стратегийн томоохон хөрөнгө оруулалтуудыг хийлээ. Үүгээрээ бид ирээдүйн өсөлт дэвшлийнхээ суурийг сайн бэлтгэж чадсан гэж дүгнэж байна.

Манай компани 2021 онд 144.3 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан бөгөөд борлуулалтын орлого өмнөх онтой харьцуулахад 23 хувь өссөн үзүүлэлттэй байна.

Дэлхийн зах зээлийг чиглэн борлуулалтын сувгаа нэмэгдүүлэх зорилгоор 2019 оны 2 дугаар хагас жилээс эхлүүлсэн онлайн борлуулалт маань өдгөө 4.2 дахин өсөлтийг үзүүлсэн нь сүүлийн жилүүдэд хийсэн томоохон хөрөнгө оруулалтынхаа өгөөжийг хүртэх цаг ойртсоор байгааг илтгэж байна.

Мөн бид компанийн хэмжээнд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтыг хурдан хугацаанд оновчтой хийдэг болоход чиглэн үйл ажиллагааныхаа шат бүрд программчлал болон автоматжуулалтыг нэвтрүүлэн хөгжүүлж цахим шилжилтийг хийж байна. Үүний зэрэгцээ олон улсын нэр хүндтэй, тэргүүлэх компаниудтай хамтран ажилласнаар бидний нэр хүнд, олон улсад эзлэх байр суурь, Говь брэндийн танигдалт, хэрэглэгчид эрчимтэй нэмэгдэж чадлаа. Цахим шилжилтэд ажиллаж буй ажилтнууд маань олон улсын туршлагаас суралцсаар байгаа бөгөөд мэдлэг чадвар хуримтлуулж сайн бэлтгэгдэж чадсан.

2022 оноос эхлэн бид хөгжил дэвшлийнхээ дараагийн том шат руугаа орж, дэлхийн өнцөг булан бүрд Говь брэндийг хүмүүс өмсдөг болох, хөрөнгө оруулалтаа нөхөж эхлэх, борлуулалтаа нэмэгдүүлэх, ашигтай ажиллах, хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийг өсгөхөд бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллана.

Энэ цаг үед биднийг үргэлж дэмжин ажиллаж буй хувьцаа эзэмшигчид, бүхий л хамтрагч, оролцогч талууд, үнэнч хэрэглэгч нартаа баярлалаа. Та бүхэнд ажлын өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Д.ГЭРЭЛМАА



# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



КОМПАНИЙН 40 ЖИЛИЙН ОЙТОЙ ДАВХЦУУЛАН "ГОВЬ" ХК-ИЙН ТҮҮХЭНД БИЧИГДЭХ НЭГЭН ҮЙЛ ЯВДАЛ ТОХИОСОН НЬ АЖИЛТАН БҮР КОМПАНИЙНХАА ХУВЬЦААГ ЭЗЭМШИЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ АЖИЛТАН БОЛСОН ҮЙЛ ЯВДАЛ БАЙЛАА.



Говь ХК | Жилийн тайлан 2021

Хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түнш, хамтран ажиллагсад та бүхэндээ чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

2021 онд ковидын нөхцөл байдал үргэлжилсэн жил болж өнгөрсөн ч бид үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад онцгойлон анхаарч ажиллалаа. Компани ажлын байрыг хадгалах, ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарах, цалинг тогтмол хугацаанд нь олгох, татвараа цаг хугацаандаа төлөх, зээлийн эргэн төлөлтүүдээ хариуцлагатай хийх зэргээр зогсолтгүй урагшилсаар байна.

Гэнэтийн сорил бэрхшээл тулгарсан энэ үед бидний баримтлан ажилласан гол зарчим бол нөхцөл байдлыг эергээр харж илүү их боломж шинэчлэлийг эрэлхийлэн, хурдан хариу арга хэмжээ авч дасан зохицож ажиллах байсан юм. Манай компанийн үйл ажиллагаанд цар тахлын нөлөөлөл харьцангуй их байсан хэдий ч бид энэхүү үеийг дэлхийн зах зээл рүү чиглэсэн онлайн сувгийн борлуулалтыг нэмэгдүүлэх, Говь брэндийг дэлхийн өнцөг бүрт таниулахад зориулан бэлтгэлээ хангаж сууриа бат бөх тавих боломж хэмээн харж, зоригтой шийдвэрүүдийг гарган ажилласан.

Аливаа шинэчлэл, хөгжилд хөрөнгө оруулалтууд, хүч хөдөлмөр, хичээл зүтгэл асар их шаардлагатай байдагчлан бид өнгөрсөн жилүүдэд томоохон хөрөнгө оруулалтуудыг хийсэн нь алсыг харсан стратегийн чухал шийдвэрүүд байсан юм. Бид энэ хугацаанд гадны нэр хүндтэй компаниудтай хамтарч ажилласнаар нэлээдгүй шинэчлэлүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн туршлага хуримтлуулаад байна.

2019 оноос хойш онцгой анхаарал хандуулж ажилласан онлайн борлуулалтын суваг 2021 онд 40.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 29%, 2019 оноос 4.2 дахин өссөн амжилттай үзүүлэлт байлаа. Говь брэнд дэлхийн зах зээлд гарахад чиглэсэн ажлууд амжилттай биеллээ олсоор байгааг АНУ-ын Нью-Йорк хотын "Times Square" талбай, Англи улсын Лондон хотын автобус, таксин дээрх манай сурталчилгаа, алдарт VOGUE сэтгүүлээс харж болохоор боллоо.

Мөн компанийн 40 жилийн ойтой давхцуулан "Говь" ХК-ийн түүхэнд бичигдэх нэгэн үйл явдал тохиосон нь ажилтан бүр компанийнхаа хувьцааг эзэмшиж, хөрөнгө оруулагч ажилтан болсон үйл явдал байлаа. Ажилтнуудаа дэмжих, хөгжүүлэх, сайн сайхан амьдрахад хувь нэмэр оруулах нь гүйцэтгэх захирал миний туйлын зорилгуудын нэг билээ. Бид дэлхийд өрсөлдөхүйц компани болж, компанийн нэр хүнд, үнэлгээ өсөхийн хэрээр ажилтнуудын маань эзэмшиж буй хувьцааны үнэ цэнэ өсөж, үр өгөөжөө зайлшгүй өгнө гэдэгт итгэж байна.

Бид 2022 ондоо зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа хадгалж, олон улсад үйл ажиллагаагаа улам тэлж, улс орныхоо эдийн засгийн сэргэлтэд хувь нэмрээ оруулахад бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллахын сацуу нийгэм болоод байгаль орчиндоо ээлтэй, тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэгч хариуцлагатай компани байхын төлөө ажиллах болно. Та бүхэнд эрүүл энхийг хүсэж, цаашдын ажил үйлст тань өндрөөс өндөр амжилт хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.БААТАРСАЙХАН









# 2021 ОНД БИД

Говь ХК | Жилийн тайлан 2021

Тэргүүн дэд захирал

**Ч.СОЛОНГО**

Хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, хамтрагчид, ажилтнууд та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Говь ХК нь байгуулагдсан цагаасаа өнөөдрийг хүртэл үе үеийн удирдлагууд, чадварлаг хамт олны хамтын хүчээр үйл ажиллагаагаа амжилттай өргөжүүлэн тэлсээр ирсэн билээ. Бид олон улсын тавцанд гарч, монгол ноолуурыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэх, хүн бүрийн бүрийн хэрэглээ болгох шийдвэрийг гарган 2019 оны хоёрдугаар хагас жилээс эхлэн онлайн худалдааг хөгжүүлээд байна. Энэ хугацаанд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал гарснаар бид бүгдийн хувьд амаргүй, олон олон сорилтуудтай тулгарсан жилүүд байсан хэдий ч үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа доголдуулахгүй, ажилтнуудынхаа цалин, хангамжийг тасалдуулахгүй, онлайн борлуулалтаа улам нэмэгдүүлэхийг зорин ажилласаар байна.

Цаашид бид тоонд бус чанарт анхаарч, байгаа хүн хүчээрээ илүү бүтээмжтэй ажиллахыг зорилгоо болгон программ хангамжуудыг хөгжүүлэн, цахим шилжилтийг үйл ажиллагаандаа эрчимтэй нэвтрүүлж байна. Үүний зэрэгцээ дэлхийн чиг хандлагыг даган байгальд ээлтэй, тогтвортой, эко үйл ажиллагааг дэмжсэн бодлого баримтлан, олон улсад танигдсан хүчирхэг брэндийг бий болгохоор хичээн ажиллаж байна.

Туршлагатай, чадварлаг хамт олон, сүүлийн үеийн дэвшилтэд техник тоног төхөөрөмж, технологийн ноу-хау зэрэг олон улсад танигдсан брэнд болоход шаардлагатай бүхий л нөхцөл боломжийг бид бүрдүүлсээр ирсэн тул ийнхүү хийсэн хөрөнгө оруулалтынхаа үр шимийг тун удахгүй хэд дахин өсгөн хүртэж эхэлнэ гэдэгт итгэлтэй байна.

Ингээд өнөөдрийг хүртэл бидэнд итгэж, үргэлж дэмжиж, хамтдаа байсан оролцогч талууддаа мөн бидний амин зүрх болсон ажилтнууд болон тэдгээрийн гэр бүлд талархал илэрхийлж, эрүүл энх, аз хийморьтой байхын ерөөлийг чин сэтгэлээсээ өргөн дэвшүүлье.



# БИДНИЙ АМЖИЛТ, ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

### 3-Р САР

Дэлхийн загварын хамгийн том сэтгүүл болох Английн VOGUE сэтгүүлийн 2021 оны 3-р сарын дугаар дижитал болон хэвлэмэл байдлаар худалдаанд гарсан бөгөөд, хувцас загварын буланд Говь брэндийн ноолууран пальто, хоёр талт пальто болон бусад бүтээгдэхүүнийг онцоллоо.






### 5-Р САРЫН 28

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулсан хувь нэмрийг төр засаг өндрөөр үнэлж Говь ХК-ийн ийн гүйцэтгэх захирал Ц.Баатарсайханыг Хөдөлмөрийн баатар цолоор шагналаа.

### 6-Р САРЫН 27

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "ТОП-100" ААН-ийг шалгаруулах ёслол цахимаар зохион байгуулагдаж, Говь ХК 31 дүгээр байранд шалгарлаа.






### 10-Р САРЫН 25

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Монголын ноос, ноолуурын холбоо хамтран жил бүр зохион байгуулдаг "Арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн-2021" үзэсгэлэн худалдаанд Говь ХК-ийн "60s mod" коллекци бүтээгдэхүүн хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүнээр шалгарсан тул "ГРАН ПРИ" шагнал хүртэв.








### 4-Р САРЫН 24

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4-р сарын 24-ний 11:00 цагт Говь ХК-ийн оффис дээрээс зохион байгуулагдав. Дэлхий даяар үүссэн COVID 19 цар тахалтай холбоотой хөл хорионы улмаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хоёр дахь жилдээ цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулж "Gobi Cashmere" албан ёсны фейсбүүк хуудсаар дамжуулан шууд дамжуулалтыг хүрсэн бөгөөд 88.42 хувийн саналын эрхтэй нийт 136 хувьцаа эзэмшигчид оролцлоо.

### 6-Р САРЫН 29

Монголын Хөрөнгийн Бирж дээр "Цан Цохих" арга хэмжээг зохион байгуулж Говь ХК 1,500 ажилтнаа хувьцаагаар урамшуулах хөтөлбөрийг албан ёсоор зарлаж, Таван Богд Капитал ҮЦК-тай хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. Ийнхүү "Говь" ХК-ийн 1,500 ажилтан хөрөнгө оруулагч ажилтан боллоо.







### 11-Р САРЫН 24

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 11-р сарын 24-ний өдрийн шийдвэрээр Говь ХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй нэг бүр нь 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 10,000 ширхэг буюу 10 тэрбум төгрөгийн хаалттай өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн. "Говь" ХК нь уг "бүрэн хөрвөх чадвартай" хаалттай өрийн хэрэгслийг биржийн бус зах зээлээр дамжуулан амжилттай арилжлаа.

### 9-Р САРЫН 5

Говь ХК-ийн "40 жилийн ойн баяр" ёслол төгөлдөр болж өнгөрлөө.



Санхүү хариуцсан дэд захирал
**Г.СЭЛЭНГЭ**

Говь ХК нь цар тахлын сорилт үргэлжилсэн 2021 онд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, боломжит өсөлтийг бүрдүүлэх зорилгын хүрээнд бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлж ажилласан жил байлаа. Тодорхой бус нөхцөл байдал, хүндрэлийг даван туулж, дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхах зорилгоор дижитал шилжилтийг эрчимжүүлж, цахим борлуулалт, үйл ажиллагааны менежментийг сайжруулж 2021 оны борлуулалтын орлогыг 144.3 тэрбум төгрөгт (2020 онд 117.1 тэрбум төгрөг) хүргэсэн нь өмнөх оноос 23% өсөлт гаргасан.

Дотоодын зах зээлд нийт 403 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулж 66.6 тэрбум төгрөгийн борлуулалтыг (2020 онд 313 мянган ширхэг, 49.5 тэрбум төгрөг) хийн 35%-ийн өсөлт, гадаадын бөөний худалдааны сувгаар харилцагчдаасаа өмнөх онтой адил хэмжээтэй захиалга авч, нийлүүлснээр борлуулалтын дүн, тоо ширхэг харьцангуй тогтвортой байж 311 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулж 36.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн.

Нийт охин компани нь 177 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулж, 40.9 тэрбум төгрөгийн борлуулалтыг (2020 онд 127 мянган ширхэг, 31.6 тэрбум төгрөг) хийж 29%-ийн өсөлтийг үзүүлсэн байна. Дэлхийн зах зээлд Говь брэндийг таниулж, олон жилийн туршлагатай брэндүүдтэй өрсөлдөхөд маркетинг идэвхжүүлэлт, урамшууллын арга хэмжээг үр дүнтэй, улам оновчтой хийсэн нь үүнд нөлөөллөө. Түүхий ноолуур бэлтгэхээс эхлэн нэмүү өртөг шингээн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, борлуулдаг хамгийн өндөр үнэ цэнийг бий болгодог борлуулалтын суваг нь онлайн борлуулалтын суваг юм. Иймд бид онлайн борлуулалтын сувагт өндөр ач холбогдол өгч,хөрөнгө оруулалтыг хийн, өргөжүүлэн ажиллаж байна.

Бид зорилтот зах зээлийг илүү оновчтой сонгох, тэдэнд хэрэгтэй контент, мэдээлэл хүргэх замаар хэрэглэгчийг татан авчирч мөн “Говь 1 сая ширхэг бэлэг”, “Говь дэлхий даяар” гэх уламжлалт маркетингийн аян, төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлснээр дэлхийн зах зээлд Европ тив, АНУ дахь манай бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо 198 мянга, 52 мянгад тус тус хүрч нийт 250 мянган харилцагчтай болсон нь өмнөх жилээс 3.1 дахин өсөж, зорилтот зах зээлүүдэд хурдацтайгаар танигдаж байна. Харилцагчийг бий болгоход зарцуулсан хөрөнгө оруулалтын өгөөжийг ирэх жилүүдэд илүү их хүртэнэ гэсэн хүлээлттэй байна.

Бидний 2020 онд бэлтгэсэн түүхий эд нь ковидын нөхцөл байдлаас хамаарч 2021 онд хүрэлцээтэй байсан ба сүүлийн жилүүдэд байгаагүй хамгийн хямд өртөгтэй байсан тул бэлэн бүтээгдэхүүний өртгийг бага түвшинд, бохир ашгийн харьцааг зохистой түвшинд барин ажилласан.

Хэдийгээр алдагдалтай ажилласан ч 2021 онд бид 1,500 гаран ажилчдын цалинд 29.9 тэрбум төгрөгийг олгож, 21.0 тэрбум төгрөгийн шимтгэл,татвар хураамжийг улсын төсөвт цаг хугацаанд нь төвлөрүүлж ажилласан.

Зээлийн үлдэгдэл болон хүүгийн зардлыг өмнөх оноос тус тус 13% бууруулж, үр ашгийг боломжит түвшинд барих үүднээс олон улсын зах зээлд хийсэн маркетингаас бусад зардлыг боломжит хэмжээнд бууруулж, дотоод нөөц боломжоо бүрэн ашиглаж ажилласан менежментийн ололт амжилттай жил байлаа.

# БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР

/тэрбум төгрөг, %/




# БОРЛУУЛАЛТ. ЦЭВЭР АШИГ

/тэрбум төгрөг/








# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

### 2007 ОНООС ХОЙШ НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 148.3 ТЭРБУМ ТӨГРӨГ




2007 оны хувьчлалаас хойш өссөн дүнгээрээ нийт 148.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2019 онд 60 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 23 тэрбум нь Говь ХК-ийн барилга байгууламж, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгө оруулалтад зарцуулагдсан бол үлдсэн 37 тэрбум төгрөг нь Гоёо ХХК-г нэгтгэсний дүнд үүссэн өсөлт байв.

### 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ




2021 онд нийт 644 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 40 сая төгрөг буюу 6% нь барилга байгууламж, 116 сая төгрөг буюу 18% нь тоног төхөөрөмж, 211 сая төгрөг буюу 33% нь тавилга эд хогшил болон бусад биет хөрөнгө оруулалтад, 277 сая төгрөг буюу 43% нь биет бус хөрөнгө оруулалтад зарцуулагдсан байна.

МАНАЙ КОМПАНИ
2021 ОНД БИД
БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ, ШИМТГЭЛ

Говь ХК нь 2007 оноос хойш зөвхөн Монголын татварын албанд нийт 177.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнийг нэр төрөл болон он цагалбараар дэлгэрүүлэн доор харуулав.








# ГОВЬ ХК 2021 ОНД

*/2020 оны гүйцэтгэлтэй харьцуулав/*

↑ 23%
144.3 ТЭРБУМ ТӨГРӨГ
Борлуулалтын орлого

↑ 18%
(37.9) ТЭРБУМ ТӨГРӨГ
Цэвэр ашиг (Алдагдал)

↑ 35%
66.6 ТЭРБУМ ТӨГРӨГ
Дотоод борлуулалт

↑ 2%
36.8 ТЭРБУМ ТӨГРӨГ
Гадаад борлуулалт

↑ 29%
40.9 ТЭРБУМ ТӨГРӨГ
Онлайн борлуулалт

↓ 53%
576.0 МЯНГАН ШИРХЭГ
Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн

↑ 21%
891.4 МЯНГАН ШИРХЭГ
Борлуулсан бүтээгдэхүүн

↑ 58%
39.9 ТЭРБУМ ТӨГРӨГ
Маркетингийн зардал

↑ 69%
254.0 ТЭРБУМ ТӨГРӨГ
Компанийн үнэлгээ

↑ 67%
21.0 ТЭРБУМ ТӨГРӨГ
Төсөвт төлсөн татвар, шимтгэл

↓ 30%
644.0 САЯ ТӨГРӨГ
Хөрөнгө оруулалт

↓ 13%
234.2 ТЭРБУМ ТӨГРӨГ
Зээлийн үлдэгдэл

МАНАЙ КОМПАНИ
2021 ОНД БИД
БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН

| ҮЗҮҮЛЭЛТ | Хэмжих нэгж | 2020 он | 2021 он | | |
|---|---|---|---|---|---|
| | | Гүйцэтгэл 2020 | Гүйцэтгэл 2021 | Өмнөх оноос өсөлт | |
| | | | | тоо | хувь |
| **БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО** | **сая.төг** | **117,093** | **144,344** | **27,252** | **23%** |
| Үүнээс: Дотоод борлуулалт | сая.төг | 49,471 | 66,660 | 17,188 | 35% |
| Гадаад борлуулалт | сая.төг | 36,021 | 36,822 | 801 | 2% |
| Онлайн борлуулалт | сая.төг | 31,600 | 40,862 | 9,262 | 29% |
| Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхэг | мян.шир | 735 | 891 | 156 | 21% |
| **БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ** | **сая.төг** | **71,536** | **85,543** | **14,007** | **20%** |
| **НИЙТ АШИГ** | **сая.төг** | **45,556** | **58,801** | **13,245** | **29%** |
| Бохир ашгийн хувь | хувь | 39% | 41% | - | 2% |
| Үйл ажиллагааны зардал | сая.төг | 86,082 | 100,189 | 14,107 | 16% |
| Үүнээс: Маркетингийн зардал | сая.төг | 25,203 | 39,884 | 14,681 | 58% |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ** | **сая.төг** | **(40,526)** | **(41,388)** | **(862)** | **2%** |
| Үйл ажиллагааны ашгийн хувь | хувь | -35% | -29% | - | 6% |
| Үйл ажиллагааны бус зардал | сая.төг | 6,957 | (3,276) | (10,233) | -147% |
| Татварын өмнөх ашиг | сая.төг | (47,483) | (38,112) | 9,371 | 20% |
| **ЦЭВЭР АШИГ / АЛДАГДАЛ** | **сая.төг** | **(46,155)** | **(37,946)** | **8,209** | **18%** |
| Цэвэр ашгийн хувь | хувь | -39% | -26% | - | 13% |
| Нийт үйл ажиллагааны зардал | сая.төг | 157,618 | 185,732 | 28,114 | 18% |
| Орлогын 1 төгрөгт ногдох зардал | төгрөг | 1.35 | 1.29 | (0.06) | -4% |
| **ҮЙЛДВЭРЛЭЛ** | | | | | |
| Сүлжмэл бүтээгдэхүүн | мян.шир | 954 | 474 | (480) | -50% |
| Нэхмэл бүтээгдэхүүн | мян.шир | 220 | 72 | (148) | -67% |
| Оёмол бүтээгдэхүүн | мян.шир | 49 | 30 | (19) | -39% |
| Пальто | мян.шир | 29 | 15 | (14) | -48% |
| Пиджак | мян.шир | 10 | 4 | (6) | -62% |
| Ээрмэл утас | тонн | 226 | 174 | (52) | -23% |
| **АЖИЛТНУУДЫН ТОО** | **хүн** | **1,939** | **1,527** | **(412)** | **-21%** |
| Нэг ажилтанд ногдох орлого | мян.төг | 60,388 | 94,528 | 34,140 | 57% |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | **сая.төг** | **916** | **644** | **(272)** | **-30%** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **сая.төг** | **314,562** | **270,733** | **(43,829)** | **-14%** |
| Үүнээс: Банкны зээл | сая.төг | 269,904 | 234,159 | (35,745) | -13% |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **сая.төг** | **379,814** | **299,858** | **(79,955)** | **-21%** |
| Үүнээс: Бараа материал | сая.төг | 193,854 | 138,030 | (55,823) | -29% |



Говь ХК | Жилийн тайлан 2021

**БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО**
/тэрбум төгрөг/




**БОХИР АШГИЙН ХУВЬ**




2021 оны ашигт ажиллагааны гүйцэтгэлийг 2020 онтой харьцуулахад борлуулалтын орлого 144.3 тэрбум төгрөгт хүрч 23% өсөлттэй байсан бол бохир ашгийн хувь 2 пунктээр өсч 41% болж сайжирсан.

**МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ**
/тэрбум төгрөг/




**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШГИЙН ХУВЬ**




Үйл ажиллагааны хувьд онлайн зах зээлийг идэвхжүүлэх маркетингийн зардал 58% өсч 39.9 тэрбум төгрөгийг зарцуулж, үйл ажиллагааны ашгийн хувь 6 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

**ҮЙЛДВЭРЛЭСЭН ТОО**
/мянган ширхэг/




**БОРЛУУЛСАН ТОО**
/мянган ширхэг/




2021 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо 53% буурсан бол борлуулсан бүтээгдэхүүний тоо 21% өссөн үзүүлэлттэй байна. Бүтээгдэхүүний нэр төрлөөр нь аваад үзвэл сүлжмэл бүтээгдэхүүн нь үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний 80 орчим хувийг эзэлж байна. Нэхмэл бүтээгдэхүүний хувьд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 13%, борлуулсан бүтээгдэхүүний 4% эзэлж байна. Харин оёмол бүтээгдэхүүн нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 5%, борлуулсан бүтээгдэхүүний 15%-ийг эзэлж байна.

### ЦЭВЭР АШИГ, АЛДАГДАЛ
/тэрбум төгрөг/




### НИЙТ ХӨРӨНГӨ
/тэрбум төгрөг/




Компанийн 2021 оны цэвэр ашиг (алдагдал) -37.9 тэрбум төгрөг ба тайлант үеийн алдагдал нь тайлант үеийн эцэс дэх өөрийн хөрөнгийн дүнгийн 30 хувиас хэтэрсэн байна.

### БАРАА МАТЕРИАЛЫН ЭРГЭЦ
/хоног/




### АВЛАГЫН ЭРГЭЦ
/хоног/




2021 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг 2020 онтой харьцуулахад түүхий эд татан авалт хийгдээгүй, нөөцөө бууруулах арга хэмжээг авч бараа материал үлдэгдлийг 55.8 тэрбум төгрөгөөр буюу 29% бууруулсан. Мөн зээлийн борлуулалтын хэмжээг бууруулах үе шаттай арга хэмжээнүүдийг авснаар борлуулалтын авлагын эргэцийг 7 хоног болгож 60% богиносгосон бөгөөд авлагын үлдэгдэл 62.3% буурсан нь нийт хөрөнгө буурахад нөлөөлсөн.





# МӨНГӨН УРСГАЛ

/тэрбум төгрөг/




2021 онд үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний хүрээнд орох мөнгөн гүйлгээ 158.6 тэрбум төгрөг байгаагаас борлуулалтын орлого 157.8 тэрбум төгрөг байна.

Харин гарах мөнгө гүйлгээнд нийт 127.4 тэрбум төгрөг зарцуулснаас 81.4 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 21.0 тэрбум төгрөгийг татварын зардалд, санхүүжилтийн зардалд 25.0 тэрбум төгрөг тус тус төлж цэвэр үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ сайжирсан үзүүлэлттэй байна.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны хүрээнд 0.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

Санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд 39.0 тэрбум төгрөгөөр зээлийн дүнг бууруулсан үзүүлэлттэй байна.

# ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлант үеийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй болно.

# СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

/мянган төгрөг/

1. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл

1.1 Холбоотой талуудын үлдэгдэл

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Холбоотой талаас авах дансны авлага | 30,222 | 215,053 |
| Толгой компанид өгөх дансны өглөг /Богино хугацаат/ | 185,933 | 12,477,541 |
| Толгой компанид өгөх дансны өглөг /Урт хугацаат/ | 25,622,107 | 14,230,453 |

Холбоотой талд өгөх урт хугацаат өглөг нь Таван Богд Трейд ХХК-иас Гоёо ХХК-ийн хувьцааг зээлээр худалдан авсантай холбоотой. Худалдан авалтын өдрөөр уг өглөгийг 2020 оны 8 сард төлж дуусгахаар тохиролцсон. Анхны гэрээнд нийт 3 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ байгуулсан бөгөөд 2021 оны 09 сард байгуулсан "нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ"-ний дагуу төлбөр төлж барагдуулах хугацааг 2024 оны 05 сар болгон өөрчилсөн.

Холбоотой талуудын дансны үлдэгдэл нь барьцаагүй ба найдваргүй авлагын сан байгуулаагүй.

1.2 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Дараах ажил гүйлгээг Таван Богд Группийн толгой компанитай хийсэн:

| Таван Богд Трейд ХХК | 2021 | 2020 |
|---|---|---|
| Толгой компаниас авсан санхүүжилт | - | 12,459,400 |
| Толгой компаниас авсан санхүүжилтээс төлсөн дүн | - | 12,459,400 |
| Толгой компаниас авсан худалдан авалт | 1,256,062 | 1,463,505 |
| Толгой компанид төлсөн хүүгийн зардал | 2,032,887 | 2,418,383 |
| Толгой компанид хийсэн борлуулалт | 39,134 | 4,392 |

Дараах ажил гүйлгээнүүдийг нэгдсэн хяналтад байдаг бусад холбоотой талуудтай хийсэн:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Холбоотой талаас авсан санхүүжилт | 41,483,084 | - |
| Холбоотой талаас авсан санхүүжилтээс төлсөн дүн | 41,483,084 | - |
| Холбоотой талаас авсан худалдан авалт | 454,406 | 645,589 |
| Холбоотой талд хийсэн борлуулалт | 343,699 | 341,646 |
| Холбоотой талд төлсөн хүүгийн зардал | 272,418 | - |

Таван Богд Трейд ХХК-ийн хамаарал бүхий байгууллага болох ХААН банктай дараах гүйлгээг хийсэн:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Хаан банкнаас авсан санхүүжилт | 39,237,105 | 69,270,000 |
| Хаан банкнаас авсан санхүүжилтээс төлсөн дүн | 47,237,105 | 89,000,000 |
| Холбоотой талд хийсэн борлуулалт | 1,115,012 | 10,500 |
| Хаан банкинд төлсөн хүүгийн зардал | 207,648 | 3,308,145 |

Бүх холбоотой талын гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцөлөөр, зах зээлийн үнээр хийгдсэн болно.





2. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний харьцуулалт

• Санхүүжилтийн зардал

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Нийт санхүүжилт зардал | 25,474,286 | 29,542,260 |
| Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардал | 2,305,305 | 2,418,383 |
| Эзлэх хувь /холбоотой тал/ | 9.0% | 8.2% |




### НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ЗАРДАЛ

Говь ХК нь 2021 онд холбоотой талын санхүүжилтийн зардалд 2,305,305 төгрөг төлсөн нь нийт санхүүжилтийн зардлын 9.0 хувийг эзэлж байна. Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардлын дундаж төгрөгийн хүү нь 7.3 хувь байна. Холбоотой тал нь олгосон санхүүжилтэд санхүүгийн харьцаа болон барьцаа хөрөнгө шаардаагүй.

• Худалдан авалт

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Нийт худалдан авалт | 8,293,815 | 17,818,750 |
| Гадаадын худалдан авалт | 4,957,126 | 12,490,308 |
| Дотоодын худалдан авалт | 3,336,689 | 5,328,442 |
| Холбоотой талаас авсан худалдан авалт | 454,406 | 645,589 |
| Эзлэх хувь/нийт худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/ | 5.5% | 3.6% |
| Эзлэх хувь/дотоодын худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/ | 13.6% | 12.1% |

### НИЙТ ХУДАЛДАН АВАЛТ




### ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ




Говь ХК нь 2021 онд холбоотой талаас авсан худалдан авалтын дүн 454,406 мянган төгрөг буюу нийт худалдан авалтын 5.5 хувь, дотоодын худалдан авалтын 13.6 хувийг эзэлж байна. Холбоотой талаас авсан худалдан авалт нь зах зээлийн үнээр хийгдсэн болно.

# САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

/мянган төгрөг/

| № | Санхүүжүүлэгчийн нэр | Санхүүжилтийн хэлбэр | Жилийн хүүгийн хувь | Валют | Зээлийн үлдэгдэл 2021.12.31 | Зээлийн үлдэгдэл 2021.01.01 |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хаан Банк | Зээлийн шугам | 12.60% | MNT | - | 8,000,000 |
| 2 | Голомт Банк | Зээлийн шугам | 13.50% | MNT | - | 26,000,000 |
| 3 | Голомт Банк | Зээлийн шугам | 7.20% | USD | 9,685,920 | - |
| 4 | Хас Банк | Зээлийн шугам | 13.20% | MNT | 10,000,000 | 5,000,000 |
| 5 | Монгол Улсын Хөгжлийн Банк | Богино хугацаат зээл | 11.50% | MNT | 33,333,333 | 40,000,000 |
| 6 | Худалдаа Хөгжлийн Банк (Азийн Хөгжлийн Банк) | Богино хугацаат зээл | 8.00% | MNT | 990,000 | 3,960,000 |
| 7 | Монгол Улсын Хөгжлийн Банк | Урт хугацаат зээл | 12.00% | MNT | 42,900,000 | 42,900,000 |
| 8 | Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк | Урт хугацаат зээл | 5.25% | EUR | 45,121,860 | 48,940,920 |
| 9 | Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк | Богино хугацаат зээл | 4.25% | EUR | 51,567,840 | 55,932,480 |
| 10 | Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 1А) | Урт хугацаат зээл | 5.3% + LIBOR | USD | 7,251,491 | 8,289,484 |
| 11 | Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 1Б) | Урт хугацаат зээл | 6.0% + LIBOR | USD | 10,877,236 | 12,434,225 |
| 12 | Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 2) | Урт хугацаат зээл | 5.3% + LIBOR | USD | 12,431,128 | 13,988,504 |
| 13 | Худалдаа Хөгжлийн Банк | Урт хугацаат зээл | 13.60% | MNT | - | 4,458,498 |
| | Нийт зээлийн дүн | | | | 224,158,809 | 269,904,111 |

Монгол банкны ханш /төг/:

| | 2021-12-31 | 2021-01-01 |
|---|---|---|
| USD | 2,848.80 | 2,849.51 |
| EUR | 3,222.99 | 3,495.78 |

| № | Санхүүжүүлэгчийн нэр | Санхүүжилтийн хэлбэр | Жилийн хүүгийн хувь | Валют | Зээлийн үлдэгдэл 2021.12.31 | Зээлийн үлдэгдэл 2021.01.01 |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хаалттай Бонд | Богино хугацаат зээл | 9.00% | MNT | 10,000,000 | - |
| | Нийт зээлийн дүн | | | | 10,000,000 | - |

# КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

/мянган төгрөг/

| ЗАРДЛЫН ТӨРӨЛ | 2021.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| ТУЗ-ийн цалин урамшуулал | 178,666 | 167,797 |
| Удирдлагын цалин урамшуулал | 1,367,487 | 1,155,302 |
| Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал | 16,478 | 13,966 |













# БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Говь ХК | Жилийн тайлан 2021



Борлуулалт, дизайн, үйлдвэрлэл хариуцсан дэд захирал
**Б.БОЛОРМАА**

Дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахал загварын салбарт ч нөлөө үзүүлж, загвар зохион бүтээгчид хүндхэн сорилттой тулгарсан хэдий ч сүүлийн үед хэрэглэгчид хэвийн амьдрал руу шилжин загварын брэндүүдийн үйл ажиллагаа дахин сэргэх чиг хандлага ажиглагдаж байна.

Говь ХК нь дэлхийн зах зээлд GOBI брэндээ таниулан хүн бүрт хүргэхийг зорин ажиллаж байгаа бөгөөд зорилгодоо хүрэхэд загвар дизайн болон бүтээгдэхүүн хөгжүүлэлт нь чухал ач холбогдолтой. 2021 оны хувьд манай компанийн дизайн хөгжүүлэлтийн багийнхан дэлхийн хувцас загварын чиг хандлага, хүмүүсийн зайнаас болон оффисоос ажиллаж буй амьдралын хэв маягт нийцүүлэн энгийн, өдөр тутмын загварын шинэ коллекцио хэрэглэгчдэдээ санал болгосон. Бид Говь-Намар/Өвөл 2021-22 60'S MOD коллекцид зориулан урт давалттай, хосолсон нэхээстэй үүсмэл хээ бүхий шинэ төрлийн даавуу драпыг үйлдвэрлэн, шинэ загварын пальто гаргасан нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээт бүтээгдэхүүн болж чадсан явдал байлаа. Энэ загвар нь Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Монголын ноос, ноолуурын холбоонoос жил бүр зохион байгуулдаг "Арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн-2021" үзэсгэлэн худалдаанд манай 60's Mod коллекци бүтээгдэхүүн хэрэглэгчийн таашаалд нийцсэн, өндөр чанар, загвар дизайнтай бүтээгдэхүүнээр шалгарч, 2021 оны салбарын ШИЛДГИЙН ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН-ий шагнал "ГРАН ПРИ" цом, өргөмжлөл хүртсэн.

Мөн синтефон доторлогоотой пальтог үйлдвэрлэн худалдаанд гаргасан нь хэрэглэгчдийн таашаалд хүрч чадсан бөгөөд цаашид энэ бүтээгдэхүүнийг сайжруулж хөгжүүлснээр эрэлттэй бүтээгдэхүүн болно гэж харж байна.

Цаашид бид өдөр тутмын амьдралын хэв маягаа дагасан, хэрэглэгчдэд нийцэмжтэй бүтээгдэхүүнийг худалдаанд гаргахаас гадна WHOLE GARMENT буюу оёдолгүй сүлжмэл бүтээгдэхүүний хөгжүүлэлтэд анхааран, хэрэглээнд нэвтрүүлэхээр төлөвлөөд байна. Мөн Органик брэндийн бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд илүүтэй таниулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Говь брэнд ногоон үйлдвэрлэлийг эрхэмлэн, хүрээлэн буй байгаль орчиндоо сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг тооцож байгальд ээлтэй техник технологийг тасралтгүй эрэлхийлэн үйлдвэрлэлдээ нэвтрүүлж загвар дизайнаа хөгжүүлж байна. 2021 онд байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай тогтвортой үйлдвэрлэл явуулахаа илэрхийлэн Текстилийн салбарын тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг төсөл /STeP EcoLAB/, Монголын ноос ноолуурын холбоо хамтран гаргасан "Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн сайн дурын үйл ажиллагааны дүрэм"-ийн нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч, тус үйл ажиллагаанд нэгдсэн.

Говь ХК-ийн анхан шатны үйлдвэр нь Англи улсад төвтэй Тогтвортой ноос ноолуурын эвсэл/SFA байгууллагын "Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал"-ын тохирлын үнэлгээнд хамрагдаж "Алтан батламжлал", ээрмэлийн үйлдвэрийн үйлдвэрлэсэн утас нь Швейцарь улсад төвтэй OE-KO-ТЕКС байгуулагын "STANDARD 100 by OEKO-TEX" стандартын шаардлагыг хангаж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын гэрчилгээг 2 дахь жилдээ гардан авлаа. Энэхүү гэрчилгээ нь хэрэглэгчдэд Говь ХК-ийн үйлдвэрлэсэн ээрмэл утас нь ямар нэг химийн хортой бодисгүй, хүний эрүүл мэндэд ээлтэй, найдвартай гэдгийг нотлон харуулж байгаа юм.

2021 онд бид үйлдвэрийн ажилтнуудынхаа ур чадвар, хандлага хариуцлагыг сайжруулахад онцгой анхаарч, чанар технологийн олон оновчтой шийдэл, сайжруулалтуудыг хийснээр 5 үйлдвэр тус бүр өмнөө тавьсан зорилгоо амжилттай биелүүлж бүтээгдэхүүний чанараа 3-аас дээш хувиар өсгөж чадсан. Мөн үйлдвэр тус бүр үл тохирлын шалтгааныг зөв оношилж, түүнийг арилгах, бууруулахад төвлөрч ажилласан бөгөөд дамжлага бүрийн технологийн заавар, чанар технологийн журам, арга аргачлал, ажлын заавар зэргийг шинэчлэн сайжруулж мөрдөн ажиллаж байна.

Бид анхан шатны үйлдвэртээ Итали улсад үйлдвэрлэсэн утас үйлдвэрлэлийн хамгийн дэвшилтэт технологи бүхий Autefa самнах машинуудыг Итали мэргэжилтнүүдтэй хамтран суурилуулж ашиглалтад оруулсан. Мөн ээрмэлийн үйлдвэр хяналтын үе шатыг оновчтой болгож чанарын хяналтаа сайжруулахын зэрэгцээ техник, технологийн холбогдох сайжруулалтуудыг хийснээр утасны чанар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7 хувиар өссөн.

Дотоод борлуулалтын хувьд Говь ХК нь Улаанбаатар хотод 2, Дархан хотод 1 буюу нийт 3 салбар дэлгүүрээр дотоодын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. 2021 онд цар тахлын нөлөөгөөр гадны жуулчид ирээгүйгээс гадна удаа дараагийн хөл хорионы улмаас салбар дэлгүүрүүд 59 өдөр хаалттай байсан хүндхэн жил байсан ч бид бүх нөөц бололцоогоо дайчлан ажилласан.

Онлайн худалдаа хөгжиж байгаа энэ үед хэрэглэгчдийнхээ цаг завыг хэмнэх үүднээс Говь брэндийн албан ёсны онлайн дэлгүүр www.gobi.mn–г 2021 оны 8 сард нээн ажиллуулсан ба 2022 оны 3 сарын байдлаар 15,400 гаруй хэрэглэгч худалдан авалт хийжээ. Мөн 2021 онд "Gobi Cashmere" Facebook хуудас маань 100,000 дагагчаар нэмэгдлээ. Бид хэрэглэгчдийнхээ тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүрт засвар шинэчлэлийн ажлыг 2022 оны 2 сард хийж энэ онд борлуулалт, ашигт ажиллагаагаа дэмжих, хэрэглэгчдэдээ шинэлэг бүтээгдэхүүнээр бэлэг барих зорилгоор сар бүр шинэ коллекци гаргаж, маркетингийн шинэлэг хэлбэрүүдийг ашиглах зорилт тавин ажиллаж байна.

Харин гадаад борлуулалтын хувьд 2021 онд хил хаалттай, барааны ачилт тээвэрлэлт хийхэд багагүй бэрхшээлтэй тулгарч байсан ч 26 улсын 86 харилцагчдад борлуулалт хийж амжилттай ажилласан. 2022 онд гадаад зах зээлд Говь брэндийн борлуулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч чанартай, итгэлтэй харилцагчдыг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Манай хамт олон малчдынхаа бэлтгэсэн түүхий ноолуурыг боловсруулж, нэмүү өртөг шингээн эцсийн бүтээгдэхүүн болгож НООЛУУРАН ХУВЦСЫГ ХҮН БҮРТ уриатайгаар дэлхийн өнцөг булан бүрт байгаа өөр өөрийн онцлогтой хүмүүст зориулан загвараа урлаж, дотоодын төдийгүй гадаад улс оронд бүтээгдэхүүнээ сурталчлан хүргэхийн төлөө илүү их хичээнгүйлэн шинийг санаачлан ажиллах болно.

МАНАЙ КОМПАНИ
2021 ОНД БИД
БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ, ШИНЭ ТЕХНОЛОГИ







Манай дизайн хөгжүүлэлтийн баг өөр өөрийн онцлог бүхий брэндүүдийг хөгжүүлж, байгальд ээлтэй туслах материалыг түлхүү хэрэглэн, хэрэглэгчдийн хүсэл сонирхолд нийцсэн өнгө загвар, тренд бүхий бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ хүргэж байна. Өвлийн хүйтэнд ч загварлаг байдлаа хадгалахыг хүсдэг хэрэглэгчдэдээ зориулан 100% ноолууран драпыг сайн чанарын синтефонтой хослуулан органик дотортой хавсарч оёсон шинэ загварын курткыг худалдаанд гаргав. Энэхүү куртка нь хөнгөн, нимгэн, дулаан, тансаг мэдрэмжийг нэг дор бүрдүүлснээрээ хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн болж чадсан юм.



Говь ХК-ийн Дизайн хөгжүүлэлтийн газар Говь брэндийн Намар/Өвөл 21-22 "60's MOD" коллекцынхоо материалын хээг гаргахын тулд өнгө хоршил, утасны давалт өндөр хийгдсэн тул материалын боловсруулалтад илүү анхаарч ажилласан. Тагнай хээ нь хээзээд загварын салбарын гол хээний төлөөлөл болдог. Энэхүү хээг бид энэ удаагийн коллекцидоо олон улсын загварын чиг хандлагыг дагасан том хэмжээст хээгээр нэхэн боловсруулаа.

Ийнхүү шинэ загварын хээ болон өнгөний хослолыг онцлон сул загвартай эрэгтэй куртка, эмэгтэй пальтоны шинэлэг загваруудыг санал болгосон нь хэрэглэгчидийн эрэлт хэрэгцээт бүтээгдэхүүн болж чадсан юм.

### ОНЦЛОХ ЗАХИАЛГА

Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолд зориулсан малгайн эмжээрийн хатгамалын загвар дизайныг гарган хийж гүйцэтгэв.





Buro 24/7 шинэ жилийн захиалганд нэхмэл бүтээгдэхүүний шинэ технологийг хөгжүүлэн 2 талт нөмрөгийн дизайныг гарган хийж гүйцэтгэв.







# КОЛЛЕКЦУУД




YAMA LIMITED EDITION КОЛЛЕКЦИ




ГОВЬ ХАВАР/ЗУН 2021 ICE CREAM КОЛЛЕКЦИ



ЭРЭГТЭЙ ПАЛЬТО КОЛЛЕКЦИ




ГОВЬ ХАВАР/ЗУН 2021 RIVIERA CHIC КОЛЛЕКЦИ




ГОВЬ ХАВАР/ЗУН 2021 TERRACOTTA КОЛЛЕКЦИ




TRENCH COAT КОЛЛЕКЦИ




ГОВЬ ХАВАР/ЗУН 2021 PALM LEAF КОЛЛЕКЦИ



COAT КОЛЛЕКЦИ



ГОВЬ НАМАР/ӨВӨЛ 21-22 60'S MOD КОЛЛЕКЦИ



НАМАР/ӨВӨЛ COAT КОЛЛЕКЦИ



ТОРОМ КОЛЛЕКЦИ



ГОВЬ НАМАР/ӨВӨЛ 21-22 EXPRESSIONIST КОЛЛЕКЦИ




ГОВЬ НАМАР/ӨВӨЛ 21-22 CHALKED КОЛЛЕКЦИ




ГОВЬ НАМАР/ӨВӨЛ 21-22 DRESSAGE КОЛЛЕКЦИ



ОРГАНИК НАМАР/ӨВӨЛ 21-22 КОЛЛЕКЦИ



ШИНЭ ЖИЛ КАПСУЛ КОЛЛЕКЦИ

# ДОТООД ЗАХ ЗЭЭЛ

2021 онд дотоод зах зээл 66.6 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж өмнөх оноос 35%-ийн өсөлт үзүүлэв.

Нийт 403 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 29%-ийн өсөлттэй байв.

Говь ХК нь Монгол Улсын ноолууран бэлэн бүтээгдэхүүний зах зээлийн 69%-ийг эзэлж байна.




*/Эх сурвалж: Говь ХК-ийн зах зээлийн дотоод судалгаанд үндэслэв/*

**БОРЛУУЛАЛТ**
/тэрбум төгрөг/




**БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН**
/мянган ширхэг/




# ХУДАЛДАН АВАГЧИД

2021 онд Ковид-19 цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгтэй холбоотой хатуу хөл хорио тогтоосны улмаас жилийн 308 хоногт буюу 84 хувьд нь л салбар дэлгүүрүүд ажиллаж зөвхөн дотоодын хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ борлуулсан онцлогтой жил байлаа.

Оны эхний 4 сард худалдан авагчдын тоо өмнөх онтой харьцуулахад бууралттай байсан ч улс орон даяар цар тахлын нөхцөл байдалд дасан зохицож, халдвар хамгааллын дэглэмээ сайн сахиж, хувийн зохион байгуулалтаа сайжруулан хэвийн амьдрал руугаа шилжиж эхэлсэнтэй холбоотой оны сүүлийн хагаст худалдан авагчдын тоо эрс нэмэгдсэн бөгөөд нийт 178,851 хүн худалдан авалт хийсэн байна. Энэ нь 2020 онтой харьцуулахад 25% өссөн үзүүлэлттэй байна.








# АЛБАН ЁСНЫ ОНЛАЙН ДЭЛГҮҮР

2021 оны 8-р сарын 4-ний өдөр дотоодын худалдан авагчдад зориулан хэрэглэгчдийнхээ цаг завыг хэмнэх зорилгоор Говь брэндийн албан ёсны онлайн дэлгүүрийг (www.gobi.mn) нээв. Онлайн дэлгүүртээ загвар, хэмжээний өргөн сонголттойгоор бүтээгдэхүүнээ байршуулж байгаа бөгөөд шинэ коллекцуудыг цаг алдалгүй оруулан, хэрэглэгчдэд захиалсан бүтээгдэхүүнийг нь түргэн шуурхай хүргэж өгөх дээр анхаарч ажиллаж байна.

Онлайн дэлгүүр нээлтээ хийснээс хойш 4 сар гаруйн хугацаанд бүртгэлтэй хэрэглэгчийн тоо 14,235 болов.

**100K** FOLLOWERS ↑ 2021 онд “GOBI Cashmere” facebook хуудас 100,000 дагагчаар нэмэгдсэн.



Дотоод зах зээлийн хувьд 2021 онд бүтээгдэхүүний нөөцөө бууруулахад онцгойлон анхаарч ажилласан бол 2022 онд дараах үндсэн зорилготой ажиллахаар төлөвлөж байна.

- Борлуулалт болон ашгийн түвшинг нэмэгдүүлэх
- Үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүрт засварлаж, шинэчлэх
- Маркетингийн шинэлэг хэлбэрүүдийг ашиглах
- Үндсэн коллекцоос гадна капсул жижиг коллекцуудыг тогтмол гаргах

# ГАДААД ЗАХ ЗЭЭЛ

2021 онд гадаад зах зээл 36.8 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж өмнөх оноос 2%-ийн өсөлт үзүүлэв. Тус зах зээлд нийт 311 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 6%-ийн өсөлттэй байв.







## БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ




2020 онд нийт 133 харилцагчид бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн бол 2021 онд 84 харилцагчид бүтээгдэхүүнээ нийлүүлэн, харилцагчдын тоог бууруулж, бүтээмж ашгийг нэмэгдүүлж, хөл хорионы улмаас учирч болох эрсдэлээс сэргийлж ажилласан.

БНСУ-н зах зээлд Hyundai, CJ ENM homeshopping дамжуулан борлуулалт хийдэг бөгөөд 2021 оноос эхлэн Япон улсад Haneda-Tokyo television, Shopchannel гэсэн 2 шинэ борлуулалтын сувгаар дамжуулан борлуулалт хийж эхэлсэн.

2021 оны сүүлийн байдлаар 9 улсын 23 хотод 27 франчайз дэлгүүртэй үйл ажиллагаа явуулж байна.

### ФРАЙНЧАЙЗ ДЭЛГҮҮРҮҮД:

| | | | |
|---|---|---|---|
| Токио | Манжуур | Иркутск | Прага (2) |
| Улаан хот | Ши Янь (2) | Новосибирск | Анкара |
| Фужоу | Хонконг (3) | Омск | Истанбул |
| Хайлаар | Сөүл | Хабаровск | Киев |
| Хөх хот | Пусан | Кызыл | Щецин |
| Бээжин | Улан-Удэ | Алматы | |

2022 онд харилцагчдын тоог дахин багасгаж масс захиалга өгдөг найдвартай цөөн хэрэглэгчидтэй ажиллаж, үйлдвэрлэлийн бүтээмж болон ашгийг нэмэгдүүлэх зорилт тавьсан.







Говь ХК | Жилийн тайлан 2021

Миний Говь ХК-тай холбогдсон түүх анх 2017 онд Гадаад худалдааны менежерээр ажилд орсноор эхэлсэн. 2019 онд Америкийн нэгдсэн улсад Говь Кашмер Америк ХХК охин компанийг байгуулж, агуулахын үйл ажиллагааг эхлүүлж байсан ажил маань одоог хүртэл амжилттай үргэлжилж байна. 2020 оноос эхлэн Гадаад худалдаа хариуцсан захирлаар дэвшин ажиллах болсон бөгөөд 2020 оны хувьд дэлхий даяар цар тахалтай холбоотой эдийн засгийн хүндхэн үеийг даван туулах шаардлага бүхий л компаниудад тулгарч эхэлсэн. Энэ цаг үед гадаад худалдааны газрын хувьд харилцагчидтайгаа нягт холбоотой ажиллаж авлагуудаа тэглэх зорилтыг тавин амжилттай ажиллаж чадсан.

2021 оны 5-р сараас эхлэн би Онлайн хариуцсан дэд захирлын албан тушаалд томилогдон ажиллаж байна. Онлайн борлуулалтын хувьд манай компани 2019 оноос илүү ач холбогдол өгч ажиллаж эхэлсэн бөгөөд бид бүгдийн хувьд энэ нь цоо шинэ зүйл байсан. Тухайн үед манай компани онлайн зах зээл рүү илүү ач холбогдол өгч эхэлсэн явдал нь эргээд харахад цагаа олсон зөв шийдвэр байсан юм.

Онлайн борлуулалттай холбоотой хангалттай туршлага бидэнд байгаагүй ч 2019 оноос өнөөдрийг хүртэл дэлхийн томоохон компаниудтай хамтран ажиллаж тэднээс суралцан туршлага хуримтлуулан дэлхийн номер 1 ноолууран бүтээгдэхүүний брэнд болж чадна гэдэгтэй итгэлтэйгээр ажиллаж байна.

Дотоодын зах зээл дээр Говь брэнд хэдийнээ танигдсан бол дэлхийн улс орнуудын хэрэглэгчдийн хувьд бид танигдаагүй цоо шинэ брэнд юм. Иймд дэлхийн зах зээлд Говь брэндээ таниулахын тулд маркетингийн өндөр зардал гаргах шаардлага бидний өмнө гарч ирсэн. Брэндээ таниулахын хэрээр маркетингийн зардлууд буурч илүү бага зардлаар их борлуулалт авчрахыг зорин ажиллаж байна. Жишээ нь бид 1 харилцагч татахад 88 ам.доллар зарцуулдаг байсан бол энэ зардал жил ирэх тусам буурч 2021 онд 44 ам.доллар болгон бууруулж чадсан. Цаашид ч энэ зардлыг улам бууруулан илүү их борлуулалт хийх зорилтыг тавин алхам алхмаар зорилгодоо хүрэхийн тулд урагшилж байна.

Манай багийн хувьд мэдлэг, ур чадвартай хийж бүтээх хүсэл эрмэлзэл дүүрэн залуучуудаас бүрдсэн. Сүүлийн 2 жилийн хугацаанд энэ баг бүрэлдэхүүнээрээ дэлхийн компаниудтай хамтран ажиллаж түүнээс туршлага хуримтлуулан борлуулалтын зорилго, зорилтод хүрэхийн төлөө нэгэн сэтгэлээр хамтран ажиллаж улам бүр чадваржиж байна. Багийн гишүүн бүрийн ур чадвар, хүчин чармайлт, хамтын ажиллагааны үр дүнд бид зорьсон зорилгодоо хүрч чадна гэдэгт итгэлтэй байна.

2022 оны хувьд Ковид-19 цар тахлын нөлөөлөл буурч дэлхийн эдийн засаг сэргэх таатай нөхцөл бүрдэх болов уу гэж таамаглаж байгаа бөгөөд бид цаашид Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад өөрийн охин компанийг байгуулан зах зээлээ улам тэлж шинэ харилцагч татах зардлыг бууруулж бага зардлаар харилцагчийн тоогоо нэмэгдүүлж борлуулалтаа өсгөхийн тулд бүхий л нөөц бололцоогоо дайчлах бодлогыг баримтлан ажиллана.




Онлайн хариуцсан дэд захирал
**О.МИШЭЭЛ**

МАНАЙ КОМПАНИ

2021 ОНД БИД

БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# ОНЛАЙН ХУДАЛДАА

Говь ХК нь онлайн борлуулалтын сувгаа илүү хөгжүүлэн Европын Холбоо, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс гэсэн 3 бүсэд төвлөрөн дэлхийн өнцөг булан бүр лүү борлуулалтаа хийж байна. 2021 оны хувьд дэлхийн томоохон компаниудтай хамтран ажиллаж олон улсын зах зээлд Говь брэндийг таниулан сурталчлах замаар харилцагчийн тоог нэмэгдүүлж чадсанаар борлуулалтаа 2019 оноос 4.2 дахин өсгөж чадсан үр дүнтэй ажиллалаа.

Бид онлайн борлуулалтаа дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцэхүйц болгохын тулд бүтээгдэхүүний загвар дизайн, хэмжээний өргөн сонголттой байлгахаас гадна агуулах болон түгээлтийн системээ тогтмол сайжруулж, худалдан авагчдад захиалгыг нь түргэн шуурхай баталгаатай хүргэх дээр анхаарч ажиллаж байна.








**1-Р САР**

8 Онлайн дэлгүүр нээв. Gobi North America, Gobi International, Gobi Germany, Gobi Uk, Gobi France, Gobi Poland, Gobi Sweden, Gobi Norway

**5-Р САР**

“Ogilvy” Дэлхийн #1 Маркетингийн компанитай Дижитал Стратегийн төлөвлөгөө гарган хамтралыг эхлүүлсэн.

**6-Р САР**

Америк, Европ, Дотоодын зах зээлүүдэд ашиглагддаг байсан 7 пэйж хуудсыг нэгтгэсэн бөгөөд Facebook-ээс баталгаат тэмдэг авсан.

**7-Р САР**

Австрали улсад салбараа байгуулав.

**7-Р САР**

Берлиний агуулахыг FINE-COM агуулахын системд нэвтрүүлж, шилжүүлснээр агуулахын үйл ажиллагаа сайжирсан. Худалдан авагчийн захиалгыг бүртгэгдсэн өдрөө 75%, дараагийн 2 дахь өдрөө 100% бэлдэж гаргах гэрээт нөхцөлөөр ажиллаж байна.

**10-Р САР**

АНУ-ын Нью Йорк хотын алдарт Times Square-т видео сурталчилгаа байршуулж хэрэглэгчдэд хүргэн брэнд танигдалтаа нэмэгдүүлсэн.

**11-Р САР**

Европын томоохон Market Place болох Zalando Market Place-т бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн.

# ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ 2021/2020

| Хайлтын систем | |
|---|---|
| Impression | 1,641 сая |
| Sessions | x 1.6 |
| CR % | x 2.0 |
| CPA | + 3% |

| Сошиал медиа | |
|---|---|
| Impression | 238 сая |
| Sessions | x 1.8 |
| CR % | x 1.6 |
| CPA | -37% |

(тайлбар: "x"-дахин)

**IMPRESSION**

Нийт дижитал маркетингийн сурталчилгаа хэрэглэгчдэд хүрсэн

**SESSION**

Онлайн дэлгүүрийн нийт зочлолтын тоо

**CR%**

Conversion rate-нийт веб рүү зочилсон зочлолтын хэдэн хувь нь худалдан авалт хийж буйг илэрхийлэх хувь

**CPA**

Cost per Acquisition-нэг захиалга хийлгэхэд гаргаж буй маркетингийн зардал

| Захиалга | | |
|---|---|---|
| | Тоо /ширхэг/ | Өсөлт /%/ |
| Нийт | 99,316 | + 47% |
| EU | 62,300 | + 31% |
| US | 22,884 | + 93% |
| CN | 14,132 | + 75% |

| Борлуулалт | | |
|---|---|---|
| | Дүн /тэрбум төгрөг/ | Өсөлт /%/ |
| Нийт | 40.9 | + 29% |
| EU | 27.1 | + 19% |
| US | 9.4 | + 65% |
| CN | 4.4 | + 42% |

**ЗАХИАЛГА**




**БОРЛУУЛАЛТ**








| | EU | | US | | CN | |
|---|---|---|---|---|---|---|
| Худалдаалж буй загварын тоо | 462 | + 20% | 401 | + 20% | 280 | +10% |
| Өдөрт сурталчилгаа хүрсэн тоо | 3.2 сая | - 20% | 510 мянга | - 57% | 362 мянга | - 32% |
| Өдөрт дэлгүүрээр зочилсон хүний тоо | 26,000 гаруй | + 24% | 6,700 гаруй | + 39% | 9,600 гаруй | + 174% |
| Ашигласан хэрэгсэл | | гар утас-74% компьютер-21% таблет-5% | | гар утас-67% компьютер-27% таблет-6% | | гар утас-99% компьютер-1% |





# GOBICASHMERE.COM

Европын холбооны зах зээлд 2021 онд 27.1 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж 19%-ийн өсөлттэй ажилласан. Үүнээс Герман улс дахь салбар дэлгүүрийн борлуулалт 3.1 тэрбум төгрөг буюу 50% өсөлттэй байв.

Онлайн борлуулалтын хувьд 2021 онд 24.0 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж өнгөрсөн оноос 15% өсөлтийг үзүүлэв.

Мөн нийт 106 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оноос 13% өссөн үзүүлэлттэй байлаа.




**БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ /УЛС, СУВГААР/**

| WEBSITE, суваг | Улс | Борлуулалт /сая төгрөг/ | | Өсөлт /%/ | Борлуулалтад эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | 2020 | 2021 | | |
| www.gobicashmere.com/de | Герман | 12,157 | 12,620 | + 3.8% | 52.6% |
| www.gobicashmere.com | Европын бусад улс | 3,681 | 4,616 | + 25.4% | 19.2% |
| www.gobicashmere.com/uk | Их Британи | 2,381 | 1,898 | - 20.3% | 7.9% |
| www.gobicashmere.com/ru | Орос | 869.5 | 1,744 | + 100.6% | 7.3% |
| www.gobicashmere.com/fr | Франц | 855.5 | 1,497 | + 75.0% | 6.2% |
| www.gobicashmere.com/pl | Польш | 578.9 | 823 | + 42.2% | 3.4% |
| www.gobicashmere.com/se | Швед | 198.5 | 36 | - 81.8% | 0.1% |
| www.gobicashmere.com/no | Норвеги | 67 | 9 | - 86.6% | 0.0% |
| www.gobicashmere.com/ch | Швейцар | - | 1 | | 0.0% |
| Zalando | Герман | - | 765 | | 3.2% |
| НИЙТ | | 20,788 | 24,008 | + 15.5% | 100.0% |

Герман улс дахь салбар дэлгүүрийн борлуулалт 3.1 тэрбум төгрөг байв.

### БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ /САРААР/




## 2021 ОНЫ ОНЦЛОХ АЖИЛ

2021 оны 5-р сараас Дэлхийн No1 маркетингийн агентлаг Ogilvy компанитай хамтран ажиллаж туршлага судалсан.

8-р сард Salesforce харилцагчийн идэвхжүүлэлтийн компанитай хамтын ажиллагаа эхлүүлж харилцагчийн дата баазыг тэлж хэрэглэгч, худалдан авагчдын тоог нэмсэн.

Хэрэглэгчдэд бүтээгдэхүүн хүргэлтийг түргэн шуурхай болгох зорилгоор FINECOM логистикийн компанитай гэрээ байгуулж Европ дахь хүргэлтийг 1-2 өдөрт агуулахаас гаргадаг болсон.

Маркетингийн ажлын хүрээнд брэндийн танигдсан байдлыг тэлэх зорилгоор Герман, Их Британи, Ирланд, ОХУ, Польш зэрэг улсуудад сурталчилгаа гаргаж идэвхжүүлэлтийн ажлыг эрчимтэй явуулсан.









## GOBICASHMERE.COM/US

Америкийн зах зээлд 2021 онд 9.4 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан нь өнгөрсөн оноос 65% өссөн үзүүлэлттэй байна. Мөн нийт 54 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулж 146% өсөлтийг үзүүлэв.




### БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ /САРААР/




## 2021 ОНЫ ОНЦЛОХ АЖИЛ

2021 оны 8-р сараас эхлэн Mannfolk PR Агентлагтай хамтран ажиллаж брэндийн танигдсан байдал нэмэгдүүлэх, дижитал болон хэвлэмэл мэдээллийн хэрэгслээр гарч органик хайлтын системд нөлөөлж хэрэглэгчдийг татах ажил эхлүүлсэн.

10-р сард Нью Йорк хотын алдарт Times Square Billboard самбарт (алдарт Кока Кола самбарын доор) 4 долоо хоногийн турш 100 секунд тутамд гарч брэндээ сурталчилсан. Мөн Нью Йорк хотын бүх метронд хэвлэмэл байдлаар сурталчилгаагаа байршуулан хэрэглэгчдэд хүргэсэн.





# GOBICASHMERE.CN

БНХАУ-ын зах зээлд 2021 онд ба 4.4 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан нь өнгөрсөн оноос 43% өссөн үзүүлэлттэй байна. Мөн нийт 17 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулж 48% өсөлтийг үзүүлэв.







### БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ /ДЭЛГҮҮРЭЭР/

| Онлайн дэлгүүр | Борлуулалт /сая төгрөг/ 2020 | Борлуулалт /сая төгрөг/ 2021 | Өсөлт /%/ | Борлуулалтад эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Tmall | 1,668 | 2,131 | + 28% | 48.2% |
| Taobao | 1,069 | 877 | - 18% | 19.8% |
| JD | 254 | 637 | + 151% | 14.4% |
| B2B | 57 | 636 | + 1,008% | 14.4% |
| Wechat | 44 | 21 | - 53% | 0.5% |
| Tiktok | - | 124 | - | 2.8% |
| НИЙТ | 3,093 | 4,426 | + 43% | 100.0% |

### БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ /САРААР/




* 2021 оны 11-р сард Ковид 19-ийн нөлөөнөөс үүдэн агуулах хэсэг хугацаанд ажиллаагүй. Тухайн хугацааны борлуулалтын буцаалт зэрэг асуудал 12-р сарын борлуулалтын гүйцэтгэлд нөлөөлсөн.





# 2021 ОНЫ ОНЦЛОХ АЖИЛ

Хятадын зах зээлд Онлайн худалдааны хамгийн голлох том Платформууд дээр Говь брэндийн албан ёсны дэлгүүрүүдээ нээн ажиллуулж байна.



GOBICASHMERE.CN гэсэн үндсэн корпорэйт вэб хуудаснаас Хятад дахь Говь-н онлайн TMALL | TAOBAO | JD | TIKTOK | WECHAT гэсэн платформууд руу сонголтоор нэвтрэн орох боломжтой болгосон.






Хятад хүмүүсийн сонирхол, гоо зүйн мэдрэмжид нийцэх зураг авалт, контентыг аутсорсингоор хийлгэн брэндээ сурталчилдаг боллоо.

Сүүлийн жилүүдэд Хятадын Онлайн худалдааны зах зээлд Influencer-үүд Livestream хэрэглэгчийн худалдан авалтанд ихээр нөлөөлөх болсон тул Tmall, Tiktok платформууд дээр Хятадын influencer-үүдтэй амжилттай хамтран ажиллаж эхэллээ.







# ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Байгаль орчин | Нийгэм | Засаглал

# НООЛУУРЫН САЛБАР

Монгол Улсад 2021 онд 26.5 сая тоо толгой ямаан сүрэг тоологдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 сая буюу 4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Манай улс 2021 онд 9.4 мянга орчим тонн ноолуур бэлтгэсэн нь өмнөх оноос 2.4 мянган тонн буюу 21 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд дэлхийн түүхий ноолуурын 48 хувийг хангаж байна. Мөн ноолуурын дундаж үнэ 127.5 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 90 хувиар өссөн байна.




### СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН МОНГОЛ УЛСЫН НООЛУУРЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ:

**МОНГОЛ УЛСЫН ЯМААНЫ ТОО ТОЛГОЙ**
/сая/




*Эх сурвалж: ҮСХороо*

**МОНГОЛ УЛСЫН ТҮҮХИЙ НООЛУУРЫН БЭЛТГЭЛ** /мян.тн/




*Эх сурвалж: ҮСХороо /тооцооллын аргаар/*

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДУНДАЖ ҮНЭ**
/мян.төг/




*Эх сурвалж: Монголын ноос ноолуурын холбоо*

**НООЛУУРЫН ЗАХ ЗЭЭЛ**
/тэрбум.төг/




*/Түүхий ноолуурын дундаж ханшаар тооцоолов/*





# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА

Говь ХК нь улс эх орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулан, бизнесийн ёс зүйг эрхэмлэн дээдэлж, холбогдох хууль тогтоомжуудыг сахин биелүүлж, шударга нээлттэй өрсөлдөөнийг дэмжиж, байгаль орчин болон нийгэмд сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулдаг баялаг бүтээгч байхыг зорилгоо болгодог.

Бид тогтвортой хөгжлийг ханган ажиллах зорилгын хүрээнд дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримталдаг. Үүнд:

1. Хүний эрхийг дээдэлж, хууль дүрмийг чандлан сахиулах, хэн бүхэнд эрх тэгш, шударгаар хандах
2. Ажлын байрыг нэмэгдүүлэх, нийгмийн халамж, тусламжийг үзүүлэх
3. Боловсролын салбартай хамтран ажиллах
4. Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах
5. Малчид болон бэлтгэн нийлүүлэгчдээ дэмжин ажиллах
6. Үндсэн баялаг болох ажилтнуудынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, ажлын байрны таатай орчныг бүрдүүлж, тэдгээрийг тасралтгүй сургаж хөгжүүлэх

Говь ХК нь ноос ноолуурын салбарын тэргүүлэгч компанийн хувьд хүрээлэн буй байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлж, нийгмийн хариуцлагыг ухамсарлан, малчид болон орон нутгийн байгууллагуудтай хамтран бэлчээрийн зөв зохистой ашиглалтыг дэмжин ажиллаж, байгальд ээлтэй техник технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, нөөцийн зүй зохистой хэрэглээг хэвшүүлэхийг зорьдог.

Бид үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн түлхүүр үзүүлэлтүүдийг уялдуулан, хэрэгжүүлснээр эрүүл эргэх холбоог цогцлоох бөгөөд манай компанийн бизнесийн үйл ажиллагаа урт хугацаандаа тасралтгүй өсөн, улс орны ирээдүй, хойч үед өвлүүлэх баялаг бүтээгч болно. Энэхүү зорилгын хүрээнд манай компани нь 2021 оны 11-р сард Гүйцэтгэх удирдлагын болон үйл ажиллагааны түвшинд ажиллах Тогтвортой хөгжлийн газрыг байгуулсан.

Цаашид тогтвортой хөгжлийн хүрээнд бид дараах ажлыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:

1. ТУЗ-ийн хэмжээнд байгаль орчин, нийгэм, засаглалын асуудалд илүү анхаарал хандуулан тогтвортой хөгжлийн засаглалыг бүрдүүлэн ажиллана.
2. Компанийн тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17-н зорилго болон олон улсын GRI стандартад тулгуурлан тодорхойлсон ба байгууллагын бүхий л үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээг хийн компанийн Тогтвортой хөгжлийн бодлого, компанийн дээд удирдлагын үүрэг амлалтыг тодорхойлон тэрхүү үүрэг амлалтыг биелүүлэхээр зорин ажиллана.
3. 2022 онд тогтвортой хөгжлийн хүрээнд 14,648 хүн/цагийн сургалтыг дотооддоо зохион байгуулахаар төлөвлөөд байна. Цаашид байгууллагын нийт ажилтны болон сонирхогч талуудын тогтвортой хөгжлийн мэдлэг, ойлголтыг сайжруулах зорилгоор сургалт, контентыг тасралтгүй хөгжүүлэн ажиллана.
4. 2022 онд тогтвортой байдлын тайланг хувьцаа эзэмшигч, оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлон түүний хүрээнд боловсруулан тайлагнахаас гадна цаашид тогтмол тайлагнан ажиллахаар зорьж байна.

# 2021 ОНД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

## “МАЛЧНЫ ХОТНООС ДЭЛХИЙН БРЭНД” ТӨСЛИЙГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭВ.

Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл ОУБ /Sustainable Fibre Alliance/ болон Европын сэргээн босголт хөгжлийн банк, Говь ХК нар хамтран “Малчны хотноос Дэлхийн брэнд” төслийг 2019-2021 оны хооронд хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд Монгол улсын нутаг дэвсгэрийн бэлчээрийн доройтлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, зэрлэг амьтныг хамгаалах, ноолуурын тогтвортой аж ахуйг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулаад зогсохгүй зохистой дадлыг батламжлах тогтолцоог Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын “Дэлгэрэхийн Улаан Ямаа” хоршоо, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын “Залаа Жинст Торгон Сүрэг” хоршоодуудад нэвтрүүлж, хоршоодыг чанартай ноолуур бэлтгэн нийлүүлэх чадвар, чадамжтай болоход дэмжлэг үзүүлэн ажилласан.

### “ТОГТВОРТОЙ АРГА АРГАЧЛАЛААР ЦЭВЭР НООЛУУР БОЛОВСРУУЛАХ ЗОХИСТОЙ ДАДАЛ” БУЮУ C003 СТАНДАРТЫГ ХАНГАЖ АЖИЛЛАВ.




Тогтвортой ноос ноолуурын олон улсын эвслээс олгодог “Тогтвортой арга аргачлалаар цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал” буюу C003 стандартыг хангаж 2020 онд “МӨНГӨН БАТЛАМЖ”, 2021 онд “АЛТАН БАТЛАМЖ” гардан авсан. C003 стандарт нь түүхий эд ангилах, угаах, самнах явцдаа хүний нөөцийн менежмент, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны олон улсын шалгуурт нийцүүлэн тогтвортой арга зарчмыг баримтлан үйл ажиллагаа эрхлэхийг баталгаажуулан гэрчилж байгаа юм.



### “ТЕКСТИЛИЙН ТОГТВОРТОЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ “-Д НЭГДЭВ.




Текстилийн салбарын тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг төсөл /STE-PECOLAB/, Монголын ноос ноолуурын холбоо хамтран “Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн сайн дурын үйл ажиллагааны дүрэм”-ийг боловсруулан 2021 онд гаргасан.

Говь ХК нь Монголын текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн дүрмийн нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч, байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай тогтвортой үйлдвэрлэл явуулахаа илэрхийлэн уг дүрэмд нэгдсэн.

STeP EcoLab







## “ТОГТВОРТОЙ НООЛУУР, ГУРВАН ТАЛТ ХАМТАРСАН ТӨСӨЛ”-ИЙГ 2 ДАХЬ ЖИЛДЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭВ.






Хөдөө аж ахуйн их сургууль, малчид болон Говь ХК хамтран “Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл”-ийг 2 дахь жилдээ хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь Үйлдвэрлэл-Малчин-Шинжлэх ухаан хоорондын уялдаа холбоог бэхжүүлж малын эрүүл мэнд, арчилгаа, маллагаа, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж гүйцэтгэх, малчдад ямааны ноолуур бэлтгэлийн технологийн зөв дадал эзэмшүүлэх замаар ноолууран түүхий эдийн чанарыг сайжруулах, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилготой юм.

Говь ХК 2021 онд Хөвсгөл болон Баянхонгор аймгуудад ХААИС-ийн эрдэмтэн багш нар болон малчидтай хамтран “Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл”–ийн ажлыг 91.7%-ийн гүйцэтгэлтэй амжилттай хэрэгжүүлсэн. Тус хоёр аймгийн ямааны үржил, селекцийн ажлыг нэмэгдүүлэх зорилгоор шилмэл үүлдрийн нийт 51 ухна хүлээлгэн өгсөн. Малын тоо толгойноос илүү бэлчээрийн тогтвортой байдал, малын эрүүл мэнд болон түүхий ноолуурын чанарт анхаарч малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвөлжилтийн бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Хөвсгөл болон Баянхонгор аймгуудын гэрээт малчдын ямаан сүргийн удмын санг сайжруулах ажил үр дүнтэй хийгдэж, нийт 1,129 толгой төл хүлээн авсан.

Энэхүү төслийн хүрээнд мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дотоодын ханган нийлүүлэгчдийг дэмжин ажиллаж, олон улсын стандартын дагуу үйлдвэрлэгдсэн малын эмийг Хөвсгөл болон Баянхонгор аймгуудад нийт 1,500 ширхгийг ханган нийлүүлсэн.



Төсөл хэрэгжиж буй хоёр аймгийн гэрээт малчдад Говь ХК-ийн зүгээс ямаан аж ахуйн менежмент, ноолуурын чанарын тухай малчдын боловсролыг дээшлүүлэх, үйлдвэртэй танилцах сургалтын аяллыг компани дээрээ зохион байгуулсан.

Бид цаашид төслийн цар хүрээг улам өргөжүүлэх зорилгоор хамтын ажиллагааны гэрээг үзэглэж, төслийн 2-р үеийн ажлыг эхлүүлээд байна.







# БАЙГАЛЬ ОРЧИН

Говь ХК нь үйл ажиллагаандаа Олон улсын Байгал орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 стандартыг нэвтрүүлэн хэрэгжүүлж, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх бодлого баримтлан ажилладаг.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Нийслэлийн байгаль орчны газраар дүгнүүлж 97.3%-тай хэрэгжсэн үнэлгээг авсан.

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд 7 дэд төлөвлөгөө, 2 хөтөлбөрийг Байгаль орчин аялал жуулчлалын яамаар батлуулан хэрэгжилтийг хангаж байна.

## ЭРЧИМ ХҮЧ

2021 онд 8,775,781 кВт.ц цахилгаан эрчим хүч хэрэглэсэн. Үүнээс эрчим хүч хэмнэлтийн төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлснээр 497,440 кВт.ц цахилгаан эрчим хүч хэмнэж нийт эрчим хүчний хэрэглээг 5.6%-иар бууруулсан. Цаашид эрчим хүчний нийт хэрэглээг бууруулж, хүлэмжийн хий (CO2)-ийг багасгах зорилт тавин ажиллаж байна.

## УС

2021 онд байгууллагын хэмжээнд нийт 109,158 тн ус ашигласан бөгөөд үүнээс 14.5% буюу 15,867 тн усыг ариутгах татуургын стандартад нийцүүлсэн. Цаашид бид 2022 онд компанийн цэвэрлэх байгууламжийг бүрэн хүчин чадлаар ажиллуулан 250 м3 усыг MNS 6162 стандартын дагуу мембрам шүүлтүүрээр шүүж саарал усны 10%-ийг дахин ашиглан ариун цэврийн өрөөний суултуур, писсуарт хэрэглэхээр төлөвлөж байна.

## ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ

Байгууллагын хэмжээнд аюултай хог хаягдлын нэгдсэн цэгийг бий болгосон. Мөн баттерейны хаягдал цуглуулах хайрцгийг 12 цэгт байршуулж 1,020 ширхэг баттерейг төвлөрүүлэн мэргэжлийн байгууллагад тушааснаар 8,160,000 литр цэвэр ус, 1,020 м3 хөрс бохирдохоос сэргийлсэн.

Хог хаягдлын менежментийн хүрээнд 114 тн энгийн хог хаягдал гарснаас 22.8 тн буюу нийт хог хаягдлын 20%-ийг дахин боловсруулах цэгт тушаасан. Цаашид нийт хог хаягдлын 30%-г дахин боловсруулах, хог хаягдлыг бууруулахаар зорин ажиллаж байна.

## НОГООН БАЙГУУЛАМЖ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Байгууллагын нийт талбайн 6%-д хайлаас, нохойн хошуу, голт бор зэрэг 3 төрлийн 790 ширхэг модлог ургамал тарьж агаарын бохирдол болон орчны тоосжилтыг бууруулж, ажилчдын амрах ая тухтай орчныг бүрдүүлсэн. Цаашид нийт талбайн ногоон байгууламжийг 10%-д хүргэхээр зорин ажиллаж байна.



Говь ХК | Жилийн тайлан 2021









# НИЙГЭМ

Говь ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд үйл ажиллагаандаа эрх тэгш, хүртээмжтэй, ил тод байдлыг эрхэмлэн, тогтвортой өртгийн сүлжээний менежментийг хэрэгжүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг алхам тутамдаа мөрдөн ажилладаг.

### ЭРХ ТЭГШ БАЙДАЛ

Байгууллагын хэмжээнд тэгш боломж, тэгш оролцоо, тэгш цалин хангамжийг олгох бодлогыг баримтлан ажилладаг. Манай байгууллагын удирдлагын багийн 56%-ийг эмэгтэйчүүд эзэлдэг.

### ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангахыг үргэлж эрмэлзэж ирсэн бөгөөд 2021 оны байдлаар 18 хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд ажилладаг.

### НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ИЛ ТОД БАЙДАЛ

- Оролцогч, сонирхогч талуудаас ирсэн гомдол саналыг хүлээн авч, бүрэн шийдвэрлэдэг бөгөөд 2021 онд ирсэн санал, гомдлын 99%-ийг шийдвэрлэсэн.
- Эх үрсийн баярын өдөр Ид шидийн орон төвийн түр хамгаалах байранд байрлаж буй хүүхдүүд болон Говь ХК-ийн ажилтнуудын нийт 3,100 хүүхдийг баярлуулсан.
- Цар тахалтай холбоотойгоор онцгой нөхцөлд ажиллаж буй цагдаагийн албан хаагчид болон эмнэлэг, мэргэжлийн хяналтын ажилтнуудыг халуун аарц, хоолоор дайлан ард иргэдийнхээ төлөө ажиллаж байгаад нь талархсанаа илэрхийлсэн.
- Манай компанийн өрх толгойлсон 179 ажилтанд хүнс, түлшний тусламж үзүүлэв. Ковидын үед ажилтнуудыг дархлаажуулан 10 хоногийн витаминжуулалтын аяныг зохион байгуулсан.

### ТОГТВОРТОЙ ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ МЕНЕЖМЕНТ

- Говь ХК нь дэлхийн зах зээл болон дотоодын ханган нийлүүлэгчдээс худалдан авалтыг хийдэг. Бид дотоодын жижиг дунд бизнес эрхлэгчдээс эхлээд үндэсний томоохон үйлдвэрлэгчид болох 160 гаруй ханган нийлүүлэгчидтэй хамтран ажилладаг. Энэ нь нийт хамтрагч байгууллагуудын 70%-ийг эзэлдэг.
- Говь ХК нь "Ногоон Говь, Ногоон Дэлхий" зорилтын хүрээнд Ногоон худалдан авалтыг дэмжин ажилладаг бөгөөд Компанийн худалдан авалтын бодлого, журмын дагуу ханган нийлүүлэгчдийг шалгаруулан гэрээ, хэлцэл байгуулан хамтран ажилладаг.
- Бид дотоодын ханган нийлүүлэгчдийг чадавхжуулах ажлын хүрээнд олон улсад тавигддаг стандарт шаардлага, шинэ технологийн талаарх мэдээ мэдээллээр ханган ажиллахаас гадна бараа нийлүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл дээр уян хатан хандаж үндэсний үйлдвэрлэлийг дэмжин ажилласаар ирсэн.
- 2022 оноос "Тогтвортой, мөшгөлттэй түүхий эд" хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зорьж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд бид 2023 он гэхэд 100% тогтвортой, мөшгөлттэй түүхий эдээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд нийлүүлэх болно.

### ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ

- Бид үйл ажиллагаандаа "Нэгдүгээрт аюулгүй байдал" зарчмыг баримтлан хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг удирдаж, зөв зохистой нөөцөөр ханган, ажлын орчин нөхцөлийг сайжруулан, нийт ажилтнуудын оролцоог хангах замаар ХЭМАБ-ын мэдлэг, чадамжийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажилладаг.
- Компанийн хэмжээнд 304 ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийж газар үйлдвэр тус бүр дээр ажлын байрны эрсдэлийн удирдлага хэрэгжүүлсэн нь Осолгүй ажиллах үндсэн суурь болсон.
- 2021 онд Үйлдвэрлэлийн осол, хугацаа алдсан гэмтлийг "0" байлгах зорилтыг бүрэн хангаж 3,407,040 хүн/цаг осолгүй ажилласан. Давхардсан тоогоор 7,339 ажилтанд 27,887 хүн/цагийн сургалт, зааварчилгаа өгсөн. Бид цаашид "Нэгдүгээрт аюулгүй байдал" зарчмыг баримтлан нийт ажилтнуудын эрүүл мэндийг хэвээр хадгалж "Осолгүй" ажиллах зорилтын төлөө ажиллана.





### ЭРҮҮЛ МЭНД

- Бид Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Хан-Уул дүүргийн Улаан Загалмайн хороотой хамтран Цусны донорын өдөрлөгийг 2021 оны 3-р сарын 15-ны өдөр зохион байгуулж нийт 12 литр 950 мл цусыг хандивласан.
- Эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд ажилтнуудынхаа эрүүл мэндийг хэвээр хадгалах, ажлын байран дээр мэргэжлээс шалтгаалах өвчин үүсгэхгүй байх, эмчлэх, сувилах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлдэг. Нийт ажилтнуудын эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт үед илрүүлж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах зорилгоор 2021 онд компанийн 1,322 ажилтны эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулснаар ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчлөл үүсээгүй байна.

### КОВИД 19

Говь ХК нь ковид 19 цар тахлын үеэр дотооддоо дараах арга хэмжээнүүдийг авч, ажилтнуудынхаа эрүүл мэнд аюулгүй байдалд анхааран ажиллалаа.

1. Вакцинжуулалтыг 3 үе шаттай зохион байгуулсан бөгөөд компанийн нийт ажилтнуудын 95% нь вакцины 1-р тун, 94% нь 2-р тун, 48% нь 3-р тунд тус тус хамрагдав.
2. 2021.01.25-ны өдрөөс эхлэн компанийн эмнэлэг дээр коронавирусын шинжилгээг авч, эерэг тохиолдлуудыг эрт илрүүлж шуурхай арга хэмжээ авч ажилласан.
3. Ажилтнуудын дархлааг дэмжих зорилгоор витаминаар хангаж, хоол хүнсний орц найрлага болон чанарт онцгой анхаарч витаминжуулсан шүүс, дархлаа дэмжих хоол хүнсээр хангасан.
4. Компанийн орох, гарах цэгт ариутгах хаалга байршуулж, ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэсэн.
5. Ажилтнуудыг ээлжээр болон зайнаас ажиллуулах зохицуулалт хийж үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангасан.

Улсын онцгой комисс болон, Нийслэлийн онцгой комиссын 6 удаагийн хяналт шалгалтаар зөрчилгүй ажиллав.

### БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫН СУДАЛГАА

Байгууллагын дотоод нийгмийн ажлын хүрээнд Говь ХК нь жил бүр сэтгэл ханамжийн судалгааг авч, шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг. Бид 2021 онд тус судалгааг байгууллагын соёлын судалгаа болгон шинэчилж, хагас жил болон жилийн эцэст 2 удаа судалгааг хийсэн. Судалгааны үр дүн болоод байгууллагын хэмжээнд сайжруулах, шинэчлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн, ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны хурлаар хэлэлцэж, гишүүдийн санал зөвлөмжийг тусган ажиллалаа. 2022 онд цалин, хангамж, урамшууллын системийг шинэчлэх, хүний хөгжил, шинэ бүтээл санаачилгын тал дээр илүү анхааран ажиллахаар төлөвлөж байна.

**НИЙТ АЖИЛТНУУДЫН ТОО**

1,527

| ЗАХИРГАА | ҮЙЛДВЭР | БОРЛУУЛАЛТ | ОХИН КОМПАНИ |
|---|---|---|---|
| 235 | 1,029 | 237 | 26 |

**АЖИЛТНУУДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА**

29% 71%

**БОЛОВСРОЛЫН ТҮВШИН**

725 477 325

ХҮҮХЭД АСРАХ ЧӨЛӨӨТЭЙ

438

ГАДААД, ДОТООД СУРГАЛТАД ДАВХАРДСАН ТООГООР ХАМРАГДСАН

10,654

ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛЬ, КОМПАНИЙН ШАГНАЛААР ШАГНУУЛСАН

299













# ЗАСАГЛАЛ

# ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.




Бид 2021 онд компанийн сайн засаглалыг бэхжүүлэн сайжруулах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийсэн.

1. ТУЗ-ийн дэргэдэх хороод чиг үүргийнхээ хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд:
   - ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж, дүгнэсэн.
   - Компанийн засаглалын өөрийн үнэлгээг хийж Монголын хөрөнгийн бирж болон Компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд тайлагнасан.
   - Дотоод хяналтын бодлогын баримт бичиг, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам, Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны журам, Хөндлөнгийн аудит томилох тухай журам, Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг тус тус боловсруулан баталж, мөрдөн ажиллаж байна.
2. Хувьцаа эзэмшигч нарынхаа эрх ашгийг хангах зорилгоор дараах ажлыг гүйцэтгэлээ. Үүнд:
   - Жилийн үйл ажиллагааны тайлангийн мэдээллийн агуулгыг сайжруулсан.
   - Веб хуудсаа шинэчлэн агуулга, мэдээллээ улам өргөжүүлсэн /info.gobi.mn/
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ТУЗ-ийн ажлын албыг байгуулж, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон ТУЗ-ийн мэргэжилтэн гэсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.





# ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Манай компани Монголын хөрөнгийн биржээс батлан гаргасан Хувьцаат компаниудад зориулсан "Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний асуулга" буюу компани өөрийгөө үнэлэх асуулгыг ашиглан Засаглалын өөрийн үнэлгээг 5 дахь жилдээ хийж гүйцэтгэлээ.

## ГОВЬ ХК-ИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

| № | Үндсэн зарчмууд | Асуултын тоо | Авбал зохих оноо | Бодит үр дүн /2021 он/ | | | | Хэрэгжилтийн хувь /Сүүлийн 3 жил/ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бичиг баримт | | Хэрэгжилт | | 2019 | 2020 | 2021 |
| | | | | Авсан оноо | Хувь | Авсан оноо | Хувь | | | |
| А | Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал | 20 | 40 | 38 | 95.0% | 34 | 85.0% | 83.8% | 86.3% | 90.0% |
| Б | Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал | 10 | 20 | 20 | 100.0% | 19 | 95.0% | 95.0% | 95.0% | 97.5% |
| В | Оролцогч талууд | 10 | 20 | 19 | 95.0% | 17 | 85.0% | 80.0% | 87.5% | 90.0% |
| Г | Ил тод нээлттэй байдал | 20 | 40 | 39 | 97.5% | 34 | 85.0% | 88.8% | 91.2% | 91.2% |
| Д | Төлөөлөн удирдах зөвлөл | 30 | 60 | 59 | 98.3% | 54 | 90.0% | 85.9% | 87.5% | 94.2% |
| Е | Гүйцэтгэх удирдлага | 10 | 20 | 19 | 95.0% | 17 | 85.0% | 82.5% | 87.5% | 90.0% |
| | **Нийт** | **100** | **200** | **194** | **97.0%** | **175** | **87.5%** | **86.0%** | **89.2%** | **92.2%** |

Нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн 2021 оны засаглалын нэгдсэн үнэлгээ 92.2% -тай гарсан нь сайн засаглалтай буюу компанийн удирдлагын үйл ажиллагаа хэвийн гэсэн түвшинд үнэлэгдэж байна.

Бид засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайлангаа Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигч, олон нийтэд тайлагнан ажилладаг.

# ЦААШИД КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХАД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Бидний хувьд жил бүр засаглалын өөрийн үнэлгээг хийснээр цаашид сайжруулах шаардлагатай арга хэмжээгээ тодорхойлдог нь компанийн засаглалаа улам илүү сайжруулахад түлхэц болж өгсөөр байна. 2021 оны засаглалын үнэлгээний үр дүнд үндэслэн бид дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох үйл ажиллагааг нээлттэй зарлах замаар ил тод явуулдаг болох;
- Компанийн удирдах албаны хүмүүст олгосон шагнал урамшуулал, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, хөндлөнгийн аудиторын талаарх мэдээллийг талаар ХЭХ-д танилцуулдаг болох;
- Хувьцаа эзэмшигчдийн цахим шуудангийн хаягийн албан ёсны бүртгэлийг тогтмол хийж, бүртгэлийн сантай болон, ХЭХ-ын зар болон материалыг хувьцаа эзэмшигчдэд аль болох цахим хаягаар хүргэдэг болох, цахим харилцааны боломжит хувилбаруудыг улам сайжруулах;
- Компанийн хэмжээнд гарч буй хууль бус болон ёс зүйгүй ажиллагааны талаар ТУЗ-тэй шууд холбоо барих механизмын талаар компанийн ёс зүйн дүрэм дэх агуулгыг улам сайжруулан нарийвчлан тусгах, хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг шинэчлэх;
- Мэдээллийн үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангаж мэдээллийн агуулга, цар хүрээгээ улам бүр сайжруулах;
- Олон улсын сайн туршлагыг судалж, гадаад хөрөнгө оруулагч нарынхаа эрх ашгийг хангаж цахим хуудас дахь мэдээллээ англи хэлээр давхар хүргэдэг болох;
- Дотоод мэдээллийн аюулгүй байдлыг хангах тал дээр тавих хяналтын тогтолцоог илүү сайжруулах;





# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

### НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

| | | |
|---|---|---|
| ХИДЕ ИНТЕР ХХК | 34.00% | 265,238,300 ширхэг |
| ТАВАН БОГД ТРЕЙД ХХК | 50.25% | 392,028,206 ширхэг |

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО /2021.12.31-н ний байдлаар/

21,616




**ХИДЕ ИНТЕР ХХК** нь Япон улсын хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани юм.

**ТАВАН БОГД ТРЕЙД ХХК** нь Таван Богд Группийн толгой компани ба 1997 онд Группийн хэмжээнд бодлого стратегийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан.

Таван Богд Групп нь 21 охин компани, 4 хөрөнгө оруулалттай компани, нийт 11,000 гаруй ажилтантайгаар бизнесийн салбар бүртээ манлайлан ажилладаг Монгол улсын манлайлагч групп компани юм.

### ТАВАН БОГД ГРУППИЙН БИЗНЕСИЙН САЛБАРУУД

Банк, санхүү

Аялал, жуулчлал

Нийтийн хоол, үйлчилгээ

Үйлдвэрлэл

Худалдаа, үйлчилгээ

Албан ёсны эрхтэй төлөөлөн борлуулагч

# НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

| Д/д | Компанийн нэрс | Д/д | Компанийн нэрс | Д/д | Компанийн нэрс |
|---|---|---|---|---|---|
| 1 | Таван Богд Трейд ХХК | 13 | Жуулчин Дюти Фрий ХК | 25 | Таван Богд Капитал ҮЦК ХХК |
| 2 | Таван Богд Интернейшнл ХХК | 14 | Таван Богд ХХК | 26 | Таван Богд Билдинг Саплай ХХК |
| 3 | Улаанбаатар Гурил ХХК | 15 | Таван Богд Хот Пот ХХК | 27 | Таван Богд Инвест ХХК |
| 4 | Улаанбаатар Принт ХХК | 16 | Таван Богд Солюшнс ХХК | 28 | Таван Богд Мон Мийт ХХК |
| 5 | Таван Богд Фүүдс ХХК | 17 | Таван Богд Тайер ХХК | 29 | Сэргэлэн Резорт ХХК |
| 6 | Таван Богд Фүүдс Пицца ХХК | 18 | Файв Старс ин Хархорин ХХК | 30 | Хаан Банк ХХК |
| 7 | Хаан Палас ХХК | 19 | Фүүд Сервис Солюшнс ХХК | 31 | Ток Ток ХХК /Дижитал Аггрегатор ХХК/ |
| 8 | Таван Богд Смарт Электроникс ХХК | 20 | Таван Богд Проперти ХХК | 32 | Саппорт Сервис Монголиа ХХК |
| 9 | Жуулчин ХХК | 21 | Таван Богд Хаус ХХК | 33 | Си Эн Ти Телестар ХХК |
| 10 | Эйрлинк Монголиа ХХК | 22 | Таван Богд Резиденс ХХК | 34 | ЗАМайн Сервисиз ХХК |
| 11 | Таван Богд Вашёку ХХК | 23 | Мон Бийф ХХК | | |
| 12 | Монгол Машин Концерн ХХК | 24 | Таван Богд Финанс ХХК | | |

## ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

| Д/д | Овог, нэр | Иргэний харьяалал | Компанийн нэрс | |
|---|---|---|---|---|
| | | | Дангаараа | Нэгдмэл сонирхолтой этгээд |
| 1 | Цагаач БААТАРСАЙХАН | Монгол | 0.006% | Таван Богд Трейд ХХК 50.25% |
| 2 | Хидэо САВАДА | Япон | - | Хиде Интер ХХК 34.00% |





# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага байна. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

## ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4-р сарын 24-ний өдөр 11:00 цагт Говь ХК-ийн оффис дээрээс зохион байгуулагдав. Дэлхий даяар үүссэн нөхцөл байдал буюу Ковид 19-тэй холбоотой хөл хорионы улмаас Говь ХК хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хоёр дахь жилдээ цахим хэлбэрээр амжилттай зохион байгууллаа. Бид “Gobi Cashmere” албан ёсны фейсбүүк хуудсаар дамжуулан шууд дамжуулалтыг хүргэж ажилласан. Хуралд 88.42 хувийн саналын эрхтэй нийт 136 хувьцаа эзэмшигчид оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр явагдсан бөгөөд дараах асуудлыг хэлэлцэж батлав.

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн “Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2020 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 100%-ийн саналаар батлав.





# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагаар ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлдэг. ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна. Мөн дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг байгуулж, компанийн засаглалыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, Эрсдэл аудитын хорооны удирдлага дор Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

### ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдалд хяналт тавих, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавин чиглүүлэх, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

### НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

### ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томьёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

### БҮРЭЛДЭХҮҮН

Эрсдэл, аудитын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Нандин-Эрдэнэ

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмаа

ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хулан

### БҮРЭЛДЭХҮҮН

Нэр дэвшүүлэх хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа

ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Баатарсайхан

### БҮРЭЛДЭХҮҮН

Цалин урамшууллын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Такэши Камбэ

ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Оюунчимэг





# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



**Дамбын ГЭРЭЛМАА**

ТУЗ-ийн дарга

Хараат бус гишүүн

/Цалин урамшууллын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн/

СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор



**Цагаачийн БААТАРСАЙХАН**

ТУЗ-ийн ердийн гишүүн

/Нэр дэвшүүлэх хорооны гишүүн/

Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал



**Дашдаваагийн ХУЛАН**

ТУЗ-ийн ердийн гишүүн

/Эрсдэл, аудитын хорооны гишүүн/

Таван Богд Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч



**Такэши КАМБЭ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

/Цалин урамшууллын хорооны гишүүн/

Япон улсын Asahi Life Insurance компанийн Менежер



**Банзрагчийн НАНДИН-ЭРДЭНЭ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

/Эрсдэл, аудитын хорооны дарга/

СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн ахлах багш



**Хидэо САВАДА**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Япон улсын H.I.S компанийн Ерөнхийлөгч



**Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

/Цалин урамшууллын хорооны гишүүн/

Таван Богд Группийн Маркетингийн газрын захирал



**Алтангэрэлийн ЖАРГАЛМАА**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

/Эрсдэл, аудитын хорооны гишүүн/

GAPE, ACCA ахлах багш, хөтөлбөрийн удирдагч



**Мягмарын БАЯР**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

/Нэр дэвшүүлэх хорооны дарга/

ШУТИС-ийн ҮТС-ийн Хөнгөн Үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбарын эрхлэгч

# ТУЗ-ИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2021 онд нийт 6 ээлжит хурал болон 20 ээлжит бус хурал зохион байгуулж, 39 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж анхаарч ажиллав. Мөн ТУЗ-ийн дэргэдэх хороод ажлын тайлангаа ТУЗ-ийн хурал дээр тогтмол танилцуулж ажилласан бөгөөд хороодын хурал товлосон хугацаандаа амжилттай зохион байгуулагдаж, гишүүд идэвх санаачилгатай ажиллалаа. Энэ онд ковид цар тахал үргэлжилсэн жил байсан тул ТУЗ-ийн хурал, хороодын хурлыг ихэвчлэн зайнаас зохион байгууллаа.

| Чиглэл | Баталсан тогтоол | Огноо |
|---|---|---|
| Үйл ажиллагаа өргөжүүлэх, хөрөнгө оруулалт | Австрали улсад салбар байгуулахыг зөвшөөрөх тухай | 2021.07.05 |
| Компанийн дотоод үйл ажиллагаа | ТУЗ-ийн нэрэмжит шагнал олгох тухай | 2021.01.21 |
| | ТУЗ-өөс зөвшөөрөл авах охин компаниудын санхүүжилтийн хэмжээг батлах | 2021.01.21 |
| | Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөө, зорилтыг батлах | 2021.01.28 |
| | Ногдол ашиг хуваарилахгүй тухай | 2021.02.09 |
| | 2021 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцэлд зөвшөөрөл олгох | 2021.02.09 |
| | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах | 2021.03.12 |
| | Тооллогын комисс томилох | 2021.03.12 |
| | Хамтран ажиллах зөвшөөрөл олгох | 2021.03.15 |
| | Хувьцаа эзэмшигчдийн хурлын журамд нэмэлт заалт оруулах | 2021.04.16 |
| | Хамтран ажиллах зөвшөөрөл олгох | 2021.04.28 |
| | Хамтран ажиллах зөвшөөрөл олгох | 2021.07.29 |
| | Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох | 2021.08.26 |
| | Данс нээх, данс дахь хөрөнгийг захиран зарцуулах эрх олгох | 2021.08.27 |
| | Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам батлах | 2021.09.27 |
| | Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлогын журам батлах | 2021.09.27 |
| | Хөндлөнгийн аудит томилох журам батлах | 2021.09.27 |
| | Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам батлах | 2021.09.27 |
| | Дотоод хяналтын бодлогын баримт бичиг батлах | 2021.10.26 |
| | ТУЗ-ийн нэрэмжит шагнал олгох журам батлах | 2021.10.26 |



Говь ХК | Жилийн тайлан 2021

| Чиглэл | Баталсан тогтоол | Огноо |
|---|---|---|
| Санхүүжилт | Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах | 2021.02.04 |
| | Худалдаа Хөгжлийн банкны зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хөрөнгө үргэлжлүүлэн барьцаалах | 2021.03.10 |
| | Зээлийн багц гэрээний хугацаа сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах, Хөрөнгө үргэлжлүүлэн барьцаалах | 2021.03.22 |
| | Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах | 2021.05.14 |
| | Худалдаа Хөгжлийн банкны зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай | 2021.06.17 |
| | Таван Богд ХХК-тай зээлийн шугамын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох | 2021.08.12 |
| | Бонд гаргахыг зөвшөөрөх | 2021.08.26 |
| | Худалдаа Хөгжлийн банкны зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах | 2021.10.20 |
| | Голомт банкны зээлийн багц гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хөрөнгө үргэлжлүүлэн барьцаалах | 2021.11.10 |
| | Европын Сэргээн Босголт Хөгжлийн банктай нэмэлт гэрээ байгуулахыг зөвшөөрөх | 2021.11.18 |
| | Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах | 2021.11.25 |
| | Хас банкны зээлийн шугамын гэрээ байгуулахыг зөвшөөрөх | 2021.12.03 |
| | Голомт банкны зээлийн багц гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хөрөнгө үргэлжлүүлэн барьцаалах | 2021.12.03 |
| | Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкны гэрээний нөхцөлийг өөрчлөх | 2021.12.15 |
| | Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банканд хөрөнгө нэмж барьцаалах | 2021.12.15 |
| | Бонд гаргахыг зөвшөөрөх | 2021.12.15 |
| Хүний нөөц | Гоёо ХХК-ийн Гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас чөлөөлөх | 2021.04.16 |
| | Гоёо ХХК-ийн Гүйцэтгэх захирлыг томилох | 2021.04.16 |
| | ТУЗ-ийн ажлын алба байгуулах, ажилд томилох | 2021.09.27 |

# ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ТАЙЛАН

## ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдалд хяналт тавих, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавин чиглүүлэх, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

### БҮРЭЛДЭХҮҮН

Эрсдэл, аудитын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн **Б.Нандин-Эрдэнэ**

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн **А.Жаргалмаа**

ТУЗ-ийн ердийн гишүүн **Д.Хулан**

### 2021 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Эрсдэл аудитын хороо нь 2021 онд 4 удаа ээлжит хурал, 1 ээлжит бус хурал зохион байгуулж, 17 асуудлыг хэлэлцсэн. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 7 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг холбогдох албан тушаалтан, албадуудад өгч, хяналт тавьж ажиллав.

Энэ онд тус хороо нь компанийн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд санхүүгийн тайлан, НББ-ийн талаар хараат бус аудиторын дүгнэлт зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Мөн дотоод хяналтын бодлогын баримт бичиг болон хөндлөнгийн аудит томилох тухай журмыг тус тус шинээр боловсруулан батлав. Эрсдэлийн удирдлагын баг болон дотоод аудитын хэлтсийн ажлын гүйцэтгэл, хагас жилийн болон жилийн ажлын тайлантай цаг тухай бүрд танилцаж удирдамжаар ханган ажилласан.

Хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулалтад хорооны гишүүдийн зүгээс хараат бус байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийж, санал өгч оролцсон бөгөөд ТУЗ-ийн хурлаар сонгон шалгаруулав. Мөн дотоод аудитын хэлтсийн 2022 оны үйл ажиллагаа болон цалингийн төсвийг батлав.

## НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

### БҮРЭЛДЭХҮҮН

Нэр дэвшүүлэх хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн **М.Баяр**

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн **Д.Гэрэлмаа**

ТУЗ-ийн ердийн гишүүн **Ц.Баатарсайхан**





### 2021 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Нэр дэвшүүлэх хороо нь 2021 онд 2 удаа ээлжит хурал зохион байгуулж, 8 асуудлыг хэлэлцэв. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 11 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч ажиллалаа.

Энэ онд тус хороо нь менежмент багийн жилийн болон хагас жилийн тайлантай танилцаж, тус тайланд гүйцэтгэх захирлаас өгсөн дүгнэлттэй танилцаж үйл ажиллагаа сайжруулах зөвлөмжийг өгөв. Менежмент багийн жилийн тайлан болон гүйцэтгэлд үндэслэн хамт олноо манлайлан удирдаж, амжилттай ажилласан хоёр удирдлагыг ТУЗ-ийн нэрэмжит шагналд нэр дэвшүүлэн, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шагнав. 2021 оны ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж, үр дүнд нь үндэслэн ТУЗ болон хороодын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд цаашид гүйцэтгэх ажлуудыг хэлэлцэв. Компанийн засаглалын өөрийн үнэлгээг гүйцэтгэж Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд тайлагнан ажиллалаа.

## ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томьёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

БҮРЭЛДЭХҮҮН

Цалин, урамшууллын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн **Д.Гэрэлмаа**

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн **Такэши Камбэ**

ТУЗ-ийн ердийн гишүүн **Ж.Оюунчимэг**

### 2021 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Цалин урамшууллын хороо нь 2021 онд 2 удаа ээлжит хурал зохион байгуулж, 8 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Мөн хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 10 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч чиглүүлэн ажиллав.

Энэ онд тус хороо нь компанийн хэмжээнд цалин урамшуулал, нийгмийн халамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан, компанийн байгууллагын соёлын судалгааны ажлын үр дүнтэй танилцан санал зөвлөмжийг өгч ажиллалаа.

Мөн хорооны чиг үүргийнхээ дагуу өнгөрсөн оны цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, 2022 оны цалин урамшууллын төсвийг баталлаа.

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

| № | Огноо | Ээлжит хурал | Ирц | Ээлжит бус хурал | Ирц | Нийт баталсан тогтоолын тоо |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2021.01.21 | * | 100% | | | 2 |
| 2 | 2021.01.28 | | | * | 100% | 1 |
| 3 | 2021.02.04 | | | * | 100% | 1 |
| 4 | 2021.02.09 | * | 100% | | | 2 |
| 5 | 2021.03.10 | | | * | 100% | 1 |
| 6 | 2021.03.12 | | | * | 100% | 2 |
| 7 | 2021.03.15 | | | * | 100% | 1 |
| 8 | 2021.03.22 | | | * | 100% | 1 |
| 9 | 2021.04.16 | * | 100% | | | 3 |
| 10 | 2021.04.28 | | | * | 100% | 1 |
| 11 | 2021.05.14 | | | * | 100% | 1 |
| 12 | 2021.06.17 | | | * | 100% | 1 |
| 13 | 2021.06.22 | * | 100% | | | - |
| 14 | 2021.07.05 | | | * | 100% | 1 |
| 15 | 2021.07.29 | | | * | 100% | 1 |
| 16 | 2021.08.12 | | | * | 100% | 1 |
| 17 | 2021.08.26 | * | 100% | | | 2 |
| 18 | 2021.08.27 | | | * | 100% | 1 |
| 19 | 2021.09.27 | | | * | 100% | 5 |
| 20 | 2021.10.20 | | | * | 100% | 1 |
| 21 | 2021.10.26 | * | 100% | | | 2 |
| 22 | 2021.11.10 | | | * | 100% | 1 |
| 23 | 2021.11.18 | | | * | 100% | 1 |
| 24 | 2021.11.25 | | | * | 100% | 1 |
| 25 | 2021.12.03 | | | * | 100% | 2 |
| 26 | 2021.12.15 | | | * | 100% | 3 |
| | Нийт | 6 | | 20 | | 39 |

Тайлбар: Япон улсад байдаг хоёр гишүүд ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлын мэдээллийг цаг тухай бүрд нь и-мэйлээр хүлээн авч, саналаа цахим шуудангаар илгээдэг. Тиймээс хурлын ирцийг оролцсоноор тооцдог.





# ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Манай компани нь дотоод хяналтдаа “Хамгаалалтын 3 шугам” загварын дагуу зохион байгуулалтыг хийж, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна. Энэ загвар нь шат шатны удирдлагууд өдөр тутмын төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, хянах, зохицуулах үндсэн чиг үүргүүдээ хэрэгжүүлэн ажиллахад ач холбогдолтой байдаг.




Хамгаалалтын I шугам: Компанийн үндсэн үйл ажиллагааг явуулж буй нэгжүүд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж, тайлагнадаг.

Хамгаалалтын II шугам: Компанийн үндсэн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг нэгжүүд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу өдөр тутмын хяналтыг давхар хэрэгжүүлж, тайлагнадаг.

Хамгаалалтын III шугам: Гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтын тогтолцоо нь хэрэгжиж байгаа эсэх, оновчтой байгаа эсэх дээр баталгаажуулалтыг хийж, үндсэн чиг үүргийн хувьд Эрсдэл, аудитын хороонд, захиргааны хувьд Гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг.

Ийнхүү чиг үүргийнхээ дагуу давхар тайлагнаснаар Дотоод аудитын хараат бус байдал хангагдаж, бодитой, зохисгүй нөлөөллөөс ангид ажиллаж байна.

# ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

Зорилго

Аудитын үйл ажиллагааг орчин үеийн чиг хандлага, шилдэг туршлага, мэргэжлийн стандартад нийцүүлэн, байнгын сайжруулалт хийж гүйцэтгэх, компанийн онцлогт тохирсон баталгаажуулах болон зөвлөх үйл ажиллагааны арга, аргачлал, бодлого, горимуудаа байнга шинэчлэг сайжруулж, аудитын сайн туршлагыг бий болгох, үүгээрээ дамжуулан компанийн үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой ажилладаг.



Тайлагнал

Говь ХК-ийн Дотоод аудитын хэлтэс нь компанийн бүхий л үйл ажиллагаанд Гүйцэтгэх удирдлагын багаас хараат бусаар, бие даасан хяналт тавьж, улирал бүр ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хороонд тайлагнадаг.

Үйл ажиллагаа

Олон улсын мэргэжлийн практикийн хүрээг (IPPF)-г баримтлан, засаглал, дотоод хяналт, эрсдэлийн тогтолцоог үнэлэх, баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээ, аудитын чанарын баталгаажуулалтын үйл ажиллгааг хэрэгжүүлэн, удирдлагыг бодит мэдээллээр ханган, хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг болж ажилладаг.

2021 онд төлөвлөгөөт ажлын хүрээнд хийгдсэн ажлууд

- Баталгаажуулах ажлаар нийт 63 анхаарах асуудлыг дэвшүүлэн үүсэж болох эрсдэл, шалтгааныг тодорхойлон, шийдвэрлэх санал, зөвлөмжөөр хангаж ажилласан. 2021 онд мэдээллийн технологийн аудит, мөнгөний үнэ цэний аудитыг анх удаа онцлон төлөвлөж гүйцэтгэсэн нь үйл ажиллагаанд цаашид баримтлах чухал чиг баримжаар бий болгосон гэж үзэж байна.
- Мониторингийн ажлаар 6 багц бүхий 57 зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн дүгнэсэн. Илэрсэн асуудлуудыг шийдвэрлэх, эрсдэлийг бууруулах, үр дүнг сайжруулах талаар хэрэгжилтийг нэгтгэн дүгнэхэд 84.2%-тай байна.
- Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх удирдлагаас санал авч хэлэлцэн гүйцэтгэдэг бөгөөд шаардлагатай санал зөвлөмжийг хүргүүлж, хамтран ажилласан.
- Компанийн засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд ДАМПОУС-ын дагуу үнэлж, компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, тасралтгүй сайжруулах талаар зөвлөмж, дэмжлэгийг өгч ажилласан.
- Дотоод аудитын чанарын баталгаажуулалтын дотоод үнэлгээг өөрсдөө хийж, хэлтсийн үйл ажиллагаа, дотоод аудитын үйл ажиллагаанд анхаарах асуудлуудыг тодорхойлж, эрэмбэлэн 2022 ондоо хийж гүйцэтгэхээр төлөвлөв.





# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь эрсдэл/өгөөжийн харьцаатай уялдуулан бизнесийн сегментүүдэд хөрөнгө хуваарилах, тодорхойлох, хэмжих, хянах үйл явцаар компанийн эрсдэлд тохируулсан хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх явдал юм. Эрсдэлийн удирдлагын энэхүү үйл явц нь тасралтгүй ашигт ажиллагаанд чухал ач холбогдолтой бөгөөд компанийн ерөнхий үзэл баримтлал, үнэ цэнд нийцтэй удирдлагын тогтолцоог хадгалах, амжилттай хэрэгжүүлэх, хэрэгжилтэд мониторинг хийж, тасралтгүй сайжруулахад оршино.

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх эрсдэлийн засаглалын бүтэц нь "Гурван давхар хамгаалалтын шугам"-аар зохицуулагдах ба дараах шатны хороо, нэгжээр эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.




Эрсдэлийн засаглалын үүрэг хариуцлага болон нэгдсэн хяналтыг хэрэгжүүлэх нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үндсэн зорилгуудын нэг юм. Эрсдэлийн удирдлагын 2-р шугамын хамгаалалтыг ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооноос томилогдсон Эрсдэлийн удирдлагын баг хариуцан ажилладаг. Эрсдэлийн удирдлагын багийг компанийн удирдах албан тушаалтнууд бүрдүүлж байгаа бөгөөд Тэргүүн дэд захирал ахлан ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын баг нь ТУЗ-өөс тогтоосон эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний дагуу улирал бүр хяналт тавин эрсдэлийг удирддаг.

# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД 2021 ОНД ХИЙГДСЭН АЖИЛ

Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хэрэгжилтийг байгууллагадаа бүрэн суулгах зорилтын хүрээнд:

**ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН СОЁЛЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ**

- “Эрсдэлийн соёл”-ын судалгааг анх удаа хийсэн бөгөөд Эрсдэлийн соёл сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.
- Ажилтнуудыг эрсдэлийн удирдлагын талаар мэдлэг ойлголтоор ханган, тогтмол хөгжүүлэх

**ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭ**

- Компанийн хэмжээнд эрсдэлийн нэгдсэн бүртгэл үүсгэн, эрсдэлийн нарийвчилсан анализ үнэлгээ хийх, эрсдэл удирдах төлөвлөгөө боловсруулан, удирдлагыг эрсдэлд суурилсан шаардлагатай мэдээллээр хангаж ажиллаж байна.
- Байгууллагын бүтэц зохион байгуулалтын дагуу эрсдэлийн удирдлагын багын томилгоог шинэчлэн батлав.

## КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Дэлхий нийтээр хүн амын эрүүл мэнд болон нийгэм, эдийн засаг, санхүүгийн тогтолцоо, бизнесийн орчин гээд бүхий л чиглэлд асар хүчтэй цохилт үзүүлж үндсээр нь өөрчилж буй өнөө үеийн хүндхэн сорилтын нэг бол Ковид-19 цар тахал юм. Энэхүү цар тахлын үеээр компанийн зүгээс онцгой байдал, давагдашгүй хүчин зүйлд хариу арга хэмжээ авах дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:

- Гамшгаас хамгаалах бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан болзошгүй тохиолдолд хэрэгжүүлэн ажилласан.
- Амёб менежмент буюу нэгжийн бүтээмж, үр ашигтай ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлж байна.

Мөн компанийн үйл ажиллагаанаас хамаараад дараах арга хэмжээг 2021 онд авч хэрэгжүүлэн ажиллав.





| Үйл ажиллагааны чиглэл | Санхүү удирдлага | Гадаад/онлайн борлуулалт | Дотоод борлуулалт | Үйлдвэрлэл/ Ханган нийлүүлэлт | Үйл ажиллагаа |
|---|---|---|---|---|---|
| Үүссэн эрсдэл | • Санхүүгийн харьцаа хангахгүй байх, борлуулалтын орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс болж,орлого зардлын харьцаа алдагдаж, мөнгөн урсгал хүрэхгүй болж, зээлийн үлдэгдэл төлөвлөсөн хэмжээнд буурахгүй байх эрсдэл үүссэн. | • Цар тахлын нөлөөгөөр агуулахын үйл ажиллагааг зогсоох, хэсэгчилсэн хөл хорионы улмаас хэрэглэгчид бараа бүтээгдэхүүн явуулах боломжгүй болох,<br>• БНХАУ руу төмөр замаар бараа бүтээгдэхүүн явуулах боломжгүйгээс онгоцоор бараа бүтээгдэхүүн явуулж зардал өсөх<br>• Нислэгийн хуваарь тогтворгүйгээс цаг хугацаандаа бараа бүтээгдэхүүнээ явуулж чадахгүй байх эрсдэл үүссэн. | • УОК, Засгийн газрын шийдвэрийн дагуу дотоодын дэлгүүрүүд ажиллахгүй байх<br>• Хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурах; цаашдын борлуулалтанд нөлөөлөх, дотоод хүүгийн зардал нэмэгдэх;<br>• Бүтээгдэхүүний загвар хуучрах зэрэг эрсдэл үүссэн. | • Улс орны нийгэм эдийн засгийн өөрчлөлт болон давтагдашгүй хүчин зүйл / Хөл хорио, хил хаах гэх мэт/ зүйлээс шалтгаалан түүхий эд материалын хомсдолд орох<br>• Худалдан авалт болон борлуулалтын уялдаа алдагдсанаас үүдэн бараа материалын нөөц ихсэх эрсдэл үүссэн.<br>• Үйлдвэрлэл, борлуулалтын харьцаа хангахгүй байх эрсдэл үүссэн. | • Цар тахлын нөлөөгөөр үүсэх ажиллах хүн хүчний хомсдолд орох,<br>• Компанийн үйл ажиллагаа тасалдах эрсдэл үүсэх болзошгүй тохиолдолтой байв. |
| Хариу арга хэмжээ | • Бараа материалыг эргэлтэд оруулах, нөөцийг бууруулж, зохистой удирдах, борлуулалт болон ашгийн түвшнийг сайжруулах;<br>• Бизнесийн үйл ажиллагааны зарцуулалтыг зохистой түвшинд барих, шаардлагагүй зардлыг тэвчих;<br>• Нэн чухал чиглэлд санхүүжилтийг дэмжих;<br>• Гадаад валютын суурьтай өр зээл болон орлого, авлагын зохистой түвшинг барьж ажиллах;<br>• СТОУС-ын дагуу тайлан бүртгэлийн үйл ажиллагаанд нийцүүлэн холбогдох журамд өөрчлөлт оруулан сайжруулахаар ажиллаж байна. | • Агуулахын үйл ажиллагааг мэргэшсэн гуравдагч байгууллагаар хийлгэх;<br>• Тээврийн компаниудын үнийг өрсөлдүүлэн хямд зардлаар тээврийг зохион байгуулж агуулахын нөөцийг зохистой түвшинд удирдах шаардлагатай жишээ нь: Борлуулалт сайтай үндсэн загвар, өнгийн бүтээгдэхүүнийг байнгын нөөцтэй байлгаж ажиллах;<br>• Хэрэглэгчид тээвэр хойшлох болзошгүй тохиолдлыг урьдчилан мэдэгдэх зэрэг хариу арга хэмжээ аван ажиллав. | • Онлайн борлуулалтын сувгийг илүү олон хүнд таниулах;<br>• Дотоодын дэлгүүрүүд ажиллахгүй тохиолдолд Онлайн сувгаар борлуулалтыг нөхөн ажиллах;<br>• Маркетингийн идэвхжүүлэлтийн оновчийг сайжруулах зэрэг арга хэмжээ аван ажиллав. | • Бараа материал болон түүхийн эдийн шаардлагатай нөөцийг зөв тодорхойлж, худалдан авалтуудыг урьдчилан тооцоолон, зохистой нөөцийг бүрдүүлэх;<br>• Бараа материал болон түүхийн эдийн үлдэгдэлийн насжилтыг тогтмол тодорхойлж бууруулах арга хэмжээ авах буюу түүний дагуу бараа материалын нөөц удирдах журам батлуулан, хэрэгжүүлэлтээр ханган ажиллаж байна;<br>• Үйлдвэр төлөвлөлтийг цаг үеийн байдалтай уялдуулан уян хатан байдлаар төлөвлөх зэрэг арга хэмжээг аван, сайжруулан ажиллаж байна. | • Цар тахлын үеийн нөхцөл байдалтай уялдуулан ажилтнуудыг зайнаас ажиллуулах горимд шилжүүлэх;<br>• Ажлын байран дээр халдвар хамгааллын дэглэмийг баримтлах;<br>• Нийт ажилтнуудын дархлааг дэмжих зорилгоор витаминжуулсан хүнсний нэмэлт тэжээлийг цайны цагаар хангах;<br>• Ковид 19 -ийн эсрэг вакцинжуулалтын аянд уриалан нийт ажилтнуудын 95% I-р тун, 94% II-р тун, 48% III-р тунд хамрагдсан зэргээр тасралтгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг авсаар байна. |

# ЧАНАРЫН УДИРДЛАГА

Говь ХК нь түүхий эдээ малчдын гараас хүлээн авахаас эхлэн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүхий л шат дамжлагад 230 үзүүлэлтээр чанарын шалгалтыг хийж, технологийн горимыг чанд мөрдөн, бүтээгдэхүүнээ олон улсын ISO 9001:2008/MNS ISO 9001:2010, ISO/IEC 17025:2005/ MNS ISO/IEC 17025:2007 стандартын шаардлагын дагуу үйлдвэрлэж, баталгаажуулан дотоод, гадаад, онлайн хэрэглэгчдэд хүргэдэг.

Бид хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр үйлдвэрлэлийн шат дамжлага бүрээр чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн, чанарын 102 MNS стандарт, компанийн 3 бодлого, 115 журам, стандарт, технологийн горим, ажлын зааварчилгааг мөрдөж, чанарын хяналт шалгалтыг 100% хийж, чанарын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулан ажиллаж байна.







2021 онд Говь ХК-ийн үйлдвэрлэсэн ээрмэл утас нь Швейцарь улсын Цюрих хотод төвтэй OEKO-TEKС байгуулагын "STANDARD 100 by OEKO-TEX" стандартын шаардлагыг хангаж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын гэрчилгээг 2 дахь жилдээ гардан авсан.

Энэхүү гэрчилгээ нь хэрэглэгчдэд Говь ХК-ийн үйлдвэрлэсэн ээрмэл утас ямар нэг химийн хортой бодис агуулаагүй бөгөөд хүний эрүүл мэндэд аюулгүй, найдвартай гэдгийг дахин нотлон харуулж байна.

Говь ХК-ийн Анхан шатны үйлдвэр нь 2021 оны 4-р улиралд нь Англи улсад төвтэй "Тогтвортой ноос ноолуурын эвсэл" буюу SFA байгууллагын "Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал"-ын тохирлын үнэлгээнд 2 дахь удаагаа амжилттай хамрагдаж "Алтан батламжлал" гардан авсан.

Энэ нь анхан шатны үйлдвэртээ түүхий эд ангилах, угаах, самнах явцдаа хүний нөөцийн менежмент, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчиндоо ээлтэйгээр тогтвортой арга зарчмыг баримтлан үйлдвэрлэж буйгаа хэрэглэгчид, харилцагчиддаа нотлон харуулж буй хэрэг юм.







Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийг яам, Монголын ноос, ноолуурын холбоо, Монголын бэлчээрийн нэгдсэн холбооны захиалгаар Монгол ямаан сүргийн ноолуурын чанар, тавлаг байдал ба үржүүлгийн стратегийг боловсруулах тайланг 2021 онд хийсэн.

Тус тайланг боловсруулах ажлыг Говь ХК-ийн Чанар Стандарт Баталгаажуулалтын хэлтэс хамтран гүйцэтгэсэн юм.

Энэхүү судалгааны ажлыг Швейцарын хөгжлийн агентлагын "Ногоон Алт-Малын эрүүл мэнд" төсөл, Европын холбооны Текстилийн тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг төсөл санхүүжүүлсэн бөгөөд Монгол орны байгаль, цаг уурын янз бүрийн бүс нутагт үржүүлж буй үүлдэр омгийн ямааны ноолуурын чанарын үзүүлэлтүүдийн (голч, жигдлэг чанар, атираа, урт) өөрчлөлтийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулан судалж, дүгнэлт зөвлөмж гаргаснаараа онцлог юм.




Говь ХК-ийн ямааны ноолууран "H-1, 02, 03, 57" кодтой утас нь химийн будаггүй, цайруулалтгүй байдгаараа онцлогтой.

Эдгээр утсаар хийгдсэн сүлжмэл, нэхмэл, оёмол бэлэн бүтээгдэхүүнүүд нь үйлдвэрлэлийн менежмент, чанарын үзүүлэлтүүд болон хөдөө аж ахуйн гаралтай органик бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг бүрэн хангаж "Органик бүтээгдэхүүн" гэрчилгээгээ дахин сунган ажиллаж байна.

# КОМПЛАЕНС

- Бид хууль эрх зүйн болон бусад шаардлагын нийцлийг ханган бизнесийн ёс зүйтэйгээр дотоодын болон олон улсын зах зээлд өрсөлдөхийг эрхэмлэдэг. Үүний хүрээнд 2021 онд компанийн бүтцийг шинэчлэн, комплаенсийн нэгжийг шинээр үүсгэн ажиллаж байна. Ингэснээр бид эрсдэлийг бууруулах, түүнээс урьдчилан зайлсхийж, удирдах үйл ажиллагаанд хүн бүрийн оролцоо, хамтын ажиллагааны үнэ цэнтэйгээр хамтдаа эерэг өөрчлөлтийг бүтээн ажиллаж байна.
- Мөн 2022 оны 1-р сард Гүйцэтгэх удирдлагын багийн нийт гишүүдэд "Комплаенсийн ерөнхий ойлголт" сургалтыг зохион байгуулсан бөгөөд комплеансийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж дараагийн түвшинд гаргахаар зорин ажиллаж байна. Түүний хүрээнд 2022 онд бизнесийн ёс зүй, ажилтны ёс зүй, шүгэл үлээх бодлого зэргийг шинэчлэн тусгасан комплеансийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр зорьж байна.

# АВИЛГАЛ БОЛОН ЁС ЗҮЙ

Говь ХК нь 2018 онд “Ёс зүйн дүрэм”-ээ тодорхойлон ТУЗ-өөр батлуулсан бөгөөд үйл ажиллагааныхаа шатлал бүрт ажилтан бүр авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхыг уриалан ажилладаг. 2022 оны 1-р сард Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдэд Монгол улсын Авлигатай тэмцэх газартай хамтран “Авилга, ашиг сонирхлоос ангид байх” тухай сургалтыг зохион байгуулсан.





# НЭГДМЭЛ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО ISO СТАНДАРТ

Говь ХК нь бизнесийнхээ хөгжлийн чиг хандлагыг ногооруулж, тогтвортой хөгжих үзэл санаанд тулгуурлан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компани болох зорилгоор 2019 оноос байгууллагын хэмжээнд Нэгдмэл Удирдлагын Тогтолцооны дараах 3 стандартыг нэвтрүүлэн ажиллаа. Үүнд:

1. Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015
2. Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2015
3. Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 45001:2018

Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандартын хэрэгжүүлэлт бүрэн хийгдсэн бөгөөд 2022 оны 3 болон 5-р сард баталгаажуулалтын 1,2-р шатны аудитад орохоор бэлтгэж байна. 2022 онд байгууллагын үйл ажиллагаанд процессын шинэчлэлт сайжруулалтын ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны стандартыг хэрэгжүүлэхээр зорьж байна.





# УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ДОТООД АУДИТ

Удирдлагын тогтолцооны дотоод аудитыг Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO14001:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны ISO45001:2018 стандартуудын нийцлийг үнэлэх, гүйцэтгэлийг сайжруулах боломжийг нээн илрүүлэх, нэгдмэл удирдлагын тогтолцооны хэрэгжилт ба гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор 2021 оны 7-р сарын 19-23-ны өдрүүдэд зохион байгуулсан.





# УДИРДЛАГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Удирдлагын дүн шинжилгээний хурлыг 2021 оны 10-р сарын 19-нд зохион байгуулж цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөлт гарган PDCA циклийг нэг бүтэн эргүүлсэн. Нэгдмэл удирдлагын тогтолцоонд баталгаажуулалт хийх байгууллагаар Щвейцарын Женев хотод төвтэй олон улсын SGS байгууллагыг сонгосон.





Говь ХК | Жилийн тайлан 2021

# КОМПАНИЙН БҮТЭЦ




МАНАЙ КОМПАНИ
2021 ОНД БИД
БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ГАРСАН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Дээд шатны удирдлага:

- Тэргүүн дэд захирлын удирдлага дор Онлайн хариуцсан дэд захирал, Борлуулалт, дизайн, үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, Санхүү хариуцсан дэд захирлын орон тоог шинээр бий болгосон.

Онлайн хариуцсан дэд захирлын удирдлага дор:

- Онлайн борлуулалт хариуцсан дэд захирлын орлогчийн орон тоог шинээр бий болгосон.
- Европын зах зээл болон Америкийн зах зээлийг нэгтгэж Онлайн борлуулалтын газар /Хойд Америк, Европ/ гэсэн бүтцийн дор нэг удирдлагатай болгосон.

Борлуулалт, дизайн, үйлдвэрлэл хариуцсан дэд захирлын удирдлага дор:

- Дотоод борлуулалт болон гадаад бөөний борлуулалтыг Борлуулалтын газар хариуцах болсон.

Санхүү хариуцсан дэд захирлын удирдлага дор:

- Стратеги төлөвлөлтийн газрын нэршлийг сольж Санхүү, удирдлагын газар болгосон бөгөөд менежмент удирдлага, санхүү төлөвлөлт, хөрөнгө удирдлагыг хариуцах болсон.
- Санхүүгийн газрын нэршлийг сольж Санхүү бүртгэлийн газар болгосон бөгөөд санхүүгийн бүртгэл, санхүү болон татварын тайлагналыг хариуцах болсон.

Тэргүүн дэд захирлын шууд удирдлага дор:

- Компанийн хэмжээнд тогтвортой хөгжил, удирдлагын тогтолцоо, нийцэл, эрсдэлийн удирдлагыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх зорилгоор Тогтвортой хөгжлийн газрыг шинээр бий болгосон.

**ОХИН КОМПАНИ, САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ**

| № | Охин компанийн нэр | Байршил | Үйл ажиллагааны чиглэл |
|---|---|---|---|
| 1 | Говь Кашмер Европ ХХК | Герман улс, Шонефелд хот | Худалдаа үйлчилгээ |
| 2 | Говь Кашмер Өвөр Монгол ХХК | Хятад улс, Эрээн хот | Худалдаа үйлчилгээ |
| 3 | Говь Кашмер Америк ХХК | АНУ, Лос Анжелес | Худалдаа үйлчилгээ |
| 4 | Гоёо Кашмер ХХК | Монгол улс, Улаанбаатар хот | Үйлдвэрлэл, Худалдаа үйлчилгээ |

| № | Салбарын нэр | Байршил | Үйл ажиллагааны чиглэл |
|---|---|---|---|
| 1 | Говь Австрали | Австрали улс, Сидней хот | Худалдаа, үйлчилгээ |







# КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД



**ЦАГААЧИЙН БААТАРСАЙХАН**

Гүйцэтгэх захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 15 жил



**ЧУЛУУНБАТЫН СОЛОНГО**

Тэргүүн дэд захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 8 жил



**ОТГОНТӨГСИЙН МИШЭЭЛ**

Онлайн хариуцсан дэд захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 5 жил



**БААТАРСАЙХАНЫ АМАРСАЙХАН**

Говь Кашмер Европ ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Онлайн борлуулалт хариуцсан дэд захирлын орлогч

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 2 жил



**ГАНБОЛДЫН СЭЛЭНГЭ**

Санхүү хариуцсан дэд захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 8 жил



**БАТСУУРИЙН БОЛОРМАА**

Борлуулалт, дизайн, үйлдвэрлэл хариуцсан дэд захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 15 жил



**БЯМБАСҮРЭНГИЙН БОЛОРМАА**

Хүний нөөц, захиргаа хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 4 сар



**ЭНХБАЯРЫН ТОД-ОД**

Санхүү удирдлага хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 1 жил



**БАТЧУЛУУНЫ АРИУНАА**

Борлуулалт хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 8 жил







**ЭРДЭНЭЦЭЦЭГИЙН ЗОЛЗАЯА**

Үйлдвэр удирдлага хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 3 жил



**ДҮЙХЭРЖАВЫН СОДГЭРЭЛ**

Санхүү бүртгэл хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 11 жил



**АМАРЫН УЧРАЛ**

Дизайн хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 7 жил



**ЧУЛУУНБАТЫН ҮНЭНБАТ**

Онлайн борлуулалт хариуцсан захирал / Хойд Америк, Европ/

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 1 жил



**ЦОГТЫН УУГАНДАРЬ**

Онлайн борлуулалт хариуцсан захирал /БНХАУ/

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 3 жил



**ЭРДЭНЭБИЛЭГИЙН УРТНАСАН**

Мэдээлэл технологи хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 1 жил



**АЛТАНГЭРЭЛИЙН ЦЭРЭНТОГТОХ**

Тогтвортой хөгжил хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 4 жил



**ЦОГТБАЯРЫН ЦАСЧИХЭР**

Хуулийн хэлтсийн дарга

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 8 жил



**МӨНХБАТЫН СЭЛЭНГЭ**

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 5 жил

# ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ

| ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ НЭР | ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ | |
|---|---|---|
| | ДАНГААРАА | НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮД |
| Д.ХУЛАН | 12,503,652 ширхэг (1.6%) | ТАВАН БОГД ТРЕЙД ХХК 50.25% |
| Ц.БААТАРСАЙХАН | 50,000 ширхэг (0.01%) | |
| Ч.СОЛОНГО | 1,000 ширхэг (0.0001%) | - |
| О.МИШЭЭЛ | 1,000 ширхэг (0.0001%) | - |
| Б.АМАРСАЙХАН | 1,000 ширхэг (0.0001%) | - |
| Г.СЭЛЭНГЭ | 1,000 ширхэг (0.0001%) | - |
| Б.БОЛОРМАА | 1,000 ширхэг (0.0001%) | - |
| Б.АРИУНАА | 1,000 ширхэг (0.0001%) | - |
| Э.ТОД-ОД | 1,000 ширхэг (0.0001%) | - |
| Э.УРТНАСАН | 1,000 ширхэг (0.0001%) | - |
| Э.ЗОЛЗАЯА | 1,000 ширхэг (0.0001%) | - |
| Ч.ҮНЭНБАТ | 1,000 ширхэг (0.0001%) | - |
| Ц.ЦАСЧИХЭР | 1,000 ширхэг (0.0001%) | - |
| А.ЦЭРЭНТОГТОХ | 800 ширхэг (0.0001%) | - |
| Д.СОДГЭРЭЛ | 800 ширхэг (0.0001%) | - |
| А.УЧРАЛ | 800 ширхэг (0.0001%) | - |
| НИЙТ | 51.86% | |





# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

Говь ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2021.12.31-ний хаалтын ханшаар 254,035,834,500 төгрөг байна. Жилийн арилжааны мэдээллийг графикаар үзүүлэв.




# 52 ДОЛОО ХОНОГИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ХАНШ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2021 он | 2020 он | 2019 он | Өсөлт, бууралт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 2021/2020 | 2020/2019 |
| ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО /шир/ | 780,112,500 | 780,112,500 | 780,112,500 | энгийн хувьцаа | |
| ХУВЬЦААНЫ ҮНЭ /төг/ | | | | | |
| Хаалтын үнэ | 325.64 | 192.50 | 270.00 | 69.2% | -28.7% |
| Хамгийн их үнэ | 393.62 | 291.86 | 354.11 | 34.9% | -17.6% |
| Хамгийн бага үнэ | 193.01 | 164.85 | 251.98 | 17.1% | -34.6% |
| Дундаж үнэ | 270.67 | 205.85 | 291.60 | 31.5% | -29.4% |
| АРИЛЖААЛАГДСАН ТОО /шир/ | | | | | |
| Хамгийн их /өдөрт/ | 4,338,588 | 272,232 | 261,527 | 1493.7% | 4.1% |
| Хамгийн бага /өдөрт/ | 2,768 | 83 | 1,068 | 3234.9% | -92.2% |
| Дундаж /өдөрт/ | 81,860 | 15,430 | 31,147 | 430.5% | -50.5% |
| Нийт | 20,464,962 | 3,811,314 | 7,848,937 | 437.0% | -51.4% |
| АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төг/ | | | | | |
| Хамгийн их /өдөрт/ | 1,106,339,940 | 54,440,510 | 87,630,809 | 1932.2% | -37.9% |
| Хамгийн бага /өдөрт/ | 539,822 | 16,009 | 284,711 | 3272.0% | -94.4% |
| Дундаж /өдөрт/ | 22,492,411 | 3,158,074 | 9,398,943 | 612.2% | -66.4% |
| Нийт | 5,623,102,771 | 780,044,366 | 2,368,533,635 | 620.9% | -67.1% |
| ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төг/ | 254,035,834,500 | 150,171,656,250 | 210,630,375,000 | 69.2% | -28.7% |

# НОГДОЛ АШИГ

Манай компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад болон онлайн худалдааны зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг тасралтгүй өсгөж, ногдол ашиг тогтмол тараах бодлогыг баримталдаг.

ТУЗ-өөс 2018 онд баталсан "Ногдол ашгийн журам"-ын 2-р бүлэгт ногдол ашгийн бодлогыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

## Хоёр. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

2.1. Компанийн ногдол ашгийн бодлого нь Компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байна.

2.2. Компани хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах бодлоготой ажиллана.

2.3. Компани нь Компанийн тухай хуулийн 47-р зүйл, Компанийн дүрмийн 8.12-д заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.

2.4. Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татварын дараах цэвэр ашгийн хэмжээ, Компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ тогтооно.

2.5. Тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх бодлого баримтална.

2.6. Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгоно.

2.7. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.





# НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

| Ногдол ашиг зарласан он | Хувьцааны тоо (ширхэг) | Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төгрөг) | Нийт зарласан ногдол ашгийн дүн (төгрөг) | Ногдол ашиг тараалт |
|---|---|---|---|---|
| 1996 | 7,801,125 | 61.00 | 475,868,625 | Говь ХК нь 2007 онд хувьчлагдсан бөгөөд түүнээс өмнөх жилүүдэд зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж байна. |
| 1997 | 7,801,125 | 153.80 | 1,199,813,025 | |
| 1998 | 7,801,125 | 150.00 | 1,170,168,750 | |
| 1999 | 7,801,125 | 166.00 | 1,294,986,750 | |
| 2000 | 7,801,125 | 100.00 | 780,112,500 | |
| 2001 | 7,801,125 | 20.16 | 157,270,680 | |
| 2005 | 7,801,125 | 60.00 | 468,067,500 | |
| 2006 | 7,801,125 | 60.00 | 468,067,500 | |
| 2010 | 7,801,125 | 100.00 | 780,112,500 | Компани дээрээ тараах болон ҮЦТХТ-өөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх аргыг хослуулан 100% тараасан. |
| 2011 | 7,801,125 | 100.00 | 780,112,500 | |
| 2012 | 7,801,125 | 125.00 | 975,140,625 | |
| 2013 | 7,801,125 | 130.00 | 1,014,146,250 | |
| 2014 | 7,801,125 | 140.00 | 1,092,157,500 | |
| 2015 | 7,801,125 | 140.00 | 1,092,157,500 | |
| 2016 | 7,801,125 | 200.00 | 1,560,225,000 | |
| 2017 | 7,801,125 | 220.00 | 1,716,247,500 | |
| 2018 | 780,112,500 | 6.80 | 5,304,765,000 | |
| 2019 | 780,112,500 | - | - | Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй. |
| 2020 | 780,112,500 | - | - | |
| 2021 | 780,112,500 | - | - | |

# 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮНГЭЭС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2-р сарын 14-ны өдрийн №3 тоот тогтоолын дагуу компанийн 2021 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

# БИДНИЙ ХАРИЛЦАГЧИД

## БАНК САНХҮҮ

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

## ОНЛАЙН ХУДАЛДАА



Говь ХК | Жилийн тайлан 2021

## БАРАА /ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ/

## БАРАА /БУСАД/

## ТЭЭВЭР ЛОГИСТИК

## СУДАЛГАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА





Говь ХК | Жилийн тайлан 2021

# ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# ХАРААТ БУС АУДИТОР

Говь ХК-ийн Эрсдэл аудитын хороо нь хараат бус аудиторт тавигдах хараат бус байдлын болон мэргэшил, ажлын туршлага, бусад шалгуур үзүүлэлтийг тогтоож, уг шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдалд дүгнэлт хийн хараат бус аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээ, бусад гэрээний нөхцөлийн талаар санал боловсруулан ТУЗ-өөр шийдвэрлүүлэн батлуулдаг. Мөн хараат бус аудитын үйл ажиллагаанд нь хяналт тавихаас гадна удирдлагад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавьж чиглүүлэн ажилладаг.

Говь ХК-ийн 2021 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн тайланд Кэй Пи Эм Жи Аудит ХХК хөндлөнгийн аудит хийсэн. Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь олон улсын 4 том аудитын компанийн нэг бөгөөд 2013 онд Санхүүгийн зохицуулах хороонд Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх Аудитын компаниар бүртгэгдсэн.





ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

# НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

2021 ОНЫ 12 САРЫН 31

# ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2021 ОНЫ 12 САРЫН 31

## АГУУЛГА

ХУУДАС


Удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Хараат бус Аудиторын тайлан


## ТАЙЛАН


| | |
|---|---|
| Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан | 01 |
| Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан | 02 |
| Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан | 03 |
| Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | 04 |
| Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд | 05 |






## Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

Группийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

Говь ХК болон түүний охин компаниуд (цаашид "Групп" гэх)-ын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн. Группийн удирдлага нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Группийн удирдлага нь Группийн санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь тодруулга 2, 3 ба 4-т дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Группийн удирдлага нь Группийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглан, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Группийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, тууштайгаар хэрэглэж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлэмж хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Группийн удирдлагын шийдвэрийн дагуу 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ

Ц. Баатарсайхан
*Гүйцэтгэх Захирал*

Г. Сэлэнгэ
*Санхүү Хариуцсан Дэд Захирал*

Монгол Улс,
Улаанбаатар хот
2022 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс : +976 7011 8102
www.kpmg.com/mn

## Хараат Бус Аудиторын Тайлан

Говь Хувьцаат Компанийн
Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдэд:

**Дүгнэлт**

Бид Говь ХК болон түүний охин компаниуд (цаашид "Групп" гэх)-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй тайлбар тодруулгуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлан нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт ("АОУС")-ын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НБЁЗОУСЗ")-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Группээс хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

**Аудитын гол онцлох зүйлс**

Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм. Эдгээр онцлох зүйлс нь бидний нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх болон дүгнэлт өгөх явцад шийдвэрлэгдсэн бөгөөд бид эдгээр асуудлуудад тусдаа дүгнэлт өгөхгүй юм.

© 2022 Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани бөгөөд баталгаагаар хязгаарлагдсан Англи Улсын хувийн компани болох KPMG International Limited-д харьяалагддаг бие даасан гишүүн байгууллагуудыг нэгтгэсэн KPMG олон улсын байгууллагын гишүүн юм. Бүх эрх хуулиар хамгаалагдсан.





**Бараа материалын үнэ цэнэ бууралтын хасагдуулга**

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 2-т дурдсан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй, Тодруулга 3-т дурдсан тооцооллын тодорхой бус байдлын эх сурвалж, мөн Тодруулга 8-д дурдсан бараа материалын тодруулгыг харна уу.

| Гол онцлох зүйлс | Тэдгээрийг шийдвэрлэсэн аудитын арга хэмжээ |
|---|---|
| Групп нь өнгөрсөн жил их хэмжээгээр түүхий эд материал худалдаж авсантай холбоотойгоор бараа материалын эргэцийн харьцаа удааширсан. Үүнтэй холбоотойгоор бид бараа материалын үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн гол онцлох зүйл гэж үзсэн.<br><br>Гадны жуулчдаас үүдэлтэй борлуулалт Группийн орлогын их хэсгийг бүрдүүлдэг байсан ба аялал жуулчлал багассанаар өмнөх онуудтай харьцуулахад энэ жилийн борлуулалт буурсан. Үүнээс үүдэлтэйгээр өмнөх жилийн худалдан авалтаас их хэмжээний бараа материалын үлдэгдэл үүссэн. | Гүйцэтгэсэн аудитын горимууд:<br><br>- Тайлант хугацааны эцэс дэх бараа материалын өртөг болон насжилтын мэдээллийн иж бүрэн болон үнэн зөв байдлыг шалгасан.<br>- Бараа материалын насжилтын тайланг ашиглан үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг дахин тооцоолсон.<br>- Бараа материалын үлдэгдлийг жигнэсэн дундаж өртгийн арга ашиглан тооцсон худалдан авалт, үйлдвэрлэлийн өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлсэн эсэхийг шалгасан.<br>- Аудитын явцад болон бараа материалын тооллогын ажиглалтын үед удаан эргэцтэй болон ашиглагдахгүй байгаа бараа материал байгаа эсэхийг шалгасан.<br>- Тайлант хугацаанд шинээр худалдан авсан бараа материалын өртгийг баталгаажуулах зорилгоор түлган баталгаажуулах захидлыг харилцагч байгууллагуудаас авах замаар баталгаажуулсан. |

**Бусад мэдээлэл**

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээх юм. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан үүнд хамаарахгүй болно. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлангийн өдрөөс хойш бидэнд танилцуулагдахаар хүлээгдэж байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээллийг уншиж танилцан, уг мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм.

Жилийн тайлантай танилцах үед бусад мэдээлэлд материаллаг алдаа байна гэж үзвэл энэ талаар бид засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдэх үүрэгтэй.

**Бусад асуудал**

Группийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитыг өөр аудитор гүйцэтгэж, аудитын зөрчилгүй дүгнэлтийг 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр гаргасан болно.

KPMG

**Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага**

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь Группийн удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг төлөвлөх болон хэрэгжүүлэх зэрэг нь энэхүү хариуцлагад хамаарна.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Группийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тодруулж, Группийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Группийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нэгдсэн дүнгээрээ уг нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж болон мэргэжлийн ул итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.

- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Группийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ хязгаарлах шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Группийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.



Говь ХК | Жилийн тайлан 2021

KPMG

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага, үргэлжлэл**

- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор Групп дэх компаниудын санхүүгийн мэдээлэл болон бизнесийн үйл ажиллагааны талаар аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Бид Группийн аудитыг гүйцэтгэх, хянах, удирдах үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтэнд хариуцлага хүлээнэ.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад илрүүлсэн томоохон асуудлууд, тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Мөн бид засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн тухай мэдэгдэл хийдэг бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудал, зарим тохиолдолд түүний эсрэг үзүүлсэн хариу үйлдлийн талаар мэдэгдэл хийдэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол онцлох зүйлс хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол онцлох зүйлсийг хууль тогтоомжоор нийтэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс уг онцлох зүйлсийг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

Энэхүү хараат бус аудиторын тайлангийн аудитын гэрээт ажлын партнер нь Жу Сан Ён болно.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК

Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
2022 оны 3 дугаар сарын 29-ний өдөр

KPMG AUDIT LLC
УЛААНБААТАР ХОТ

| Баталгаажуулсан: | Баталсан: |
| --- | --- |
| Г. Соёлмаа | Жу Сан Ён |
| *Ерөнхий Захирал* | *Партнер* |

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг нэгтгэсэн санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Группийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ**
**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

| | Тодруулга | 2021 | 2020 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| *Эргэлтийн хөрөнгө* | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 5 | 4,389,479 | 12,798,745 |
| Дансны болон бусад авлага | 6 | 2,258,129 | 5,996,260 |
| Урьдчилгаа төлбөр | 7 | 3,127,757 | 3,000,895 |
| Бараа материал | 8 | 138,030,372 | 193,207,689 |
| Орлогын албан татварын авлага | 24.2 | - | 265,286 |
| Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө | 9 | - | 646,063 |
| | | **147,805,737** | **215,914,938** |
| *Эргэлтийн бус хөрөнгө* | | | |
| Үндсэн хөрөнгө | 10 | 145,404,533 | 156,243,324 |
| Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө | 11 | 1,328,307 | 2,631,104 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 24.3 | 4,325,582 | 4,073,482 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгүүд | 13 | 994,308 | 950,980 |
| | | **152,052,730** | **163,898,890** |
| **Нийт хөрөнгө** | | **299,858,467** | **379,813,828** |
| **Өр төлбөр ба эздийн өмч** | | | |
| *Богино хугацаат өр төлбөр* | | | |
| Дансны болон бусад өглөг | 14 | 15,982,955 | 21,934,076 |
| Гэрээний өр төлбөр | 14.1 | 1,370,281 | 1,541,385 |
| Буцаах эрхтэй барааны өр төлбөр | 15 | - | 1,010,634 |
| Богино хугацаат түрээсийн өглөг | 16 | 914,850 | 1,001,198 |
| Орлогын албан татварын өглөг | 24.2 | 111,894 | 46,241 |
| Богино хугацаат зээл | 17 | 132,650,889 | 267,714,096 |
| | | **151,030,869** | **293,247,630** |
| *Урт хугацаат өр төлбөр* | | | |
| Урт хугацаат түрээсийн өглөг | 16 | 672,587 | 1,900,851 |
| Урт хугацаат зээл | 17 | 93,407,780 | 4,458,498 |
| Бусад урт хугацаат өглөг | 18 | 25,622,107 | 14,955,172 |
| | | **119,702,474** | **21,314,521** |
| **Нийт өр төлбөр** | | **270,733,343** | **314,562,151** |
| **Эздийн өмч** | | | |
| Хувьцаат капитал | 19 | 780,113 | 780,113 |
| Дахин үнэлгээний нөөц | 22 | 48,870,401 | 48,974,836 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | 23 | 561,878 | (1,362,032) |
| Хуримтлагдсан (алдагдал)/ашиг | | (21,087,268) | 16,858,760 |
| **Нийт эздийн өмч** | | **29,125,124** | **65,251,677** |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | | **299,858,467** | **379,813,828** |

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*







**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**
**НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

| | Тодруулга | 2021 | 2020 |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 25.1 | 144,344,329 | 117,092,505 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 25.2, 25.3 | (85,543,487) | (71,536,488) |
| **Нийт ашиг** | | **58,800,842** | **45,556,017** |
| Санхүүгийн ба бусад орлого | 26 | 963,425 | 2,615,647 |
| Бусад олз (гарз) | 27 | 2,913,718 | (8,480,653) |
| Санхүүгийн зардал | 28 | (25,474,286) | (29,542,260) |
| Борлуулалт ба маркетингийн зардал | 25.3, 25.4 | (60,568,067) | (44,384,939) |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 25.3, 25.5 | (14,636,714) | (13,076,638) |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт | 31.1 | (110,920) | (170,306) |
| **Татварын өмнөх алдагдал** | | **(38,112,002)** | **(47,483,132)** |
| Орлогын албан татварын өгөөж (зардал) | 24 | 165,974 | 1,327,791 |
| **Тайлант жилийн цэвэр алдагдал** | | **(37,946,028)** | **(46,155,341)** |
| **Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:** | | | |
| Fgh Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ | 10, 22 | (104,435) | 33,327,139 |
| **Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжгүй бусад дэлгэрэнгүй орлого:** | | | |
| Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү | 23 | 1,923,910 | (1,083,503) |
| **Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого** | | **1,819,475** | **32,243,636** |
| **Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал** | | **(36,126,553)** | **(13,911,705)** |
| **Нэгж хувьцаанд ногдох алдагдал (төгрөгөөр)** | 21 | **(48.64)** | **(59.16)** |

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**
**НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

| | Тодруулга | Хувьцаат капитал | Дахин үнэлгээний нөөц | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| **2020 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл** | | **780,113** | **15,647,697** | **(278,529)** | **63,014,101** | **79,163,382** |
| Тайлант жилийн цэвэр алдагдал | | - | - | - | (46,155,341) | **(46,155,341)** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 22, 23 | - | 33,327,139 | (1,083,503) | - | **32,243,636** |
| Зарласан ногдол ашиг | 20 | - | - | - | - | - |
| **2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | | **780,113** | **48,974,836** | **(1,362,032)** | **16,858,760** | **65,251,677** |
| Тайлант жилийн цэвэр алдагдал | | - | - | - | (37,946,028) | **(37,946,028)** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 22, 23 | - | (104,435) | 1,923,910 | - | **1,819,475** |
| Зарласан ногдол ашиг | 20 | - | - | - | - | - |
| **2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | | **780,113** | **48,870,401** | **561,878** | **(21,087,268)** | **29,125,124** |

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*







**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН**
**НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

| | Тодруулга | 2021 | 2020 |
|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| **Тайлант жилийн цэвэр алдагдал** | | (37,946,028) | (46,155,341) |
| Тохируулгууд: | | | |
| Эргэлтийн бус хөрөнгийн элэгдэл ба хорогдлын зардал | | 11,829,178 | 12,819,926 |
| Орлогын албан татварын өгөөж | 24 | (165,974) | (1,327,791) |
| Хүүгийн зардал | 28 | 25,034,081 | 28,829,206 |
| Хүүгийн орлого | 26 | (30,585) | (60,405) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний хэрэгжээгүй (олз) / гарз | | (4,254,445) | 9,661,222 |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз | 31.1 | 79,804 | 161,269 |
| Бараа материалын хасагдуулгын зардал | 8 | 24,689 | 581,464 |
| Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө данснаас хассаны (олз) / гарз | 27 | 78,409 | (10,096) |
| Ашиглах эрхтэй хөрөнгө данснаас хассаны олз | 27 | (48,066) | (20,769) |
| | | **(5,398,937)** | **4,478,685** |
| Өөрчлөлт: | | | |
| Дансны болон бусад авлага | | 1,432,560 | 10,670,508 |
| Урьдчилгаа төлбөр | | (231,297) | 1,214,502 |
| Бараа материал | | 55,292,968 | (15,536,051) |
| Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө | | 646,063 | (80,773) |
| Дансны болон бусад өглөг | | (4,888,790) | (4,262,314) |
| Буцаах эрхтэй барааны өр төлбөр | | (1,010,634) | 97,436 |
| Гэрээний өр төлбөр | | (171,104) | (611,969) |
| | | **45,670,829** | **(4,029,976)** |
| Төлсөн орлогын албан татвар | 24.2 | (280,600) | (6,999) |
| Төлсөн хүү | 17.2 | (25,402,704) | (29,586,069) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **19,987,525** | **(33,623,044)** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Хүлээн авсан хүү | | 30,585 | 60,405 |
| Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө борлуулснаас орж ирсэн мөнгө | | 452,393 | 32,125 |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалт | 10 | (418,373) | (813,808) |
| Биет бус хөрөнгийн худалдан авалт | 13.1 | (276,618) | (268,872) |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(212,013)** | **(990,150)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Авсан зээл | 17.2 | 414,253,570 | 315,492,535 |
| Шинээр гаргасан бонд | 17.2 | 9,877,213 | - |
| Төлсөн зээл | 17.2 | (453,299,174) | (276,929,997) |
| Төлсөн түрээсийн төлбөр | 17.2 | (940,160) | (708,588) |
| Төлсөн ногдол ашиг | 20 | (100) | (463) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(30,108,651)** | **37,853,487** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт) / өсөлт** | | **(10,333,139)** | **3,240,293** |
| Гадаад үйл ажиллагааг хөрвүүлсэн гадаад валютын ханшийн зөрүү | 23 | 1,923,910 | (1,083,503) |
| Мөнгөн хөрөнгө дэх гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөөлөл | | (37) | 211 |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 5 | **12,798,745** | **10,641,744** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 5 | **4,389,479** | **12,798,745** |

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**1. Үндсэн үйл ажиллагаа**

Говь ХК (цаашид “Компани” гэх) нь 1981 онд Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан. Компанийн 50.25%-ийг Монгол Улсад бүртгэлтэй Таван Богд Трейд ХХК, 34%-ийг Япон Улсад бүртгэлтэй Хидэ Интер ХХК эзэмшдэг бөгөөд үлдсэн 15.75%-ийг бусад жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Говь ХК нь нийт 21,616 хувьцаа эзэмшигчтэй байсан.

Компани болон охин компаниуд нь (цаашид “Групп” гэх) Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Говь ХК-ийн байранд байрлах бөгөөд үндсэн үйл ажиллагаагаа Монгол, БНХАУ, АНУ, ХБНГУ зэрэг улсад эрхлэн явуулдаг ба Австрали Улсад үйл ажиллагаа эхлүүлэхээр товлож байна.

Компани нь Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, улсын бүртгэлийн 2076357 тоот регистрийн дугаартай гэрчилгээ авсан болно.

Групп нь тайлант жилд сүлжмэл, оёмол, нэхмэл бэлэн бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүн борлуулах болон хими цэвэрлэгээний үйлчилгээ зэрэг холбоотой бусад үйлчилгээгээр хангах үндсэн үйл ажиллагааг эрхэлсэн. Группийн үйл ажиллагааны орлогын талаар Тодруулга 25.1-д тодруулсан болно.

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон бэлтгэхдээ Компани болон түүний охин компаниудын санхүүгийн тайлангуудыг нэгтгэн бэлтгэсэн. Компанийн охин компаниудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг Тодруулга 12-т тодруулсан.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөр Группийн удирдлага батлан гаргасан.

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй**

**2.1 Тайлагналын нийцэл**

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэж, тайлагнасан болно. Тайлант жилийн толилуулгатай нийцүүлэх зорилгоор тодорхой харьцуулагдах дүнг дахин ангилсан.

**2.2 Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэлийн суурь**

Нэгтгэсэн санхүүгийн тайланг зарим үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаснаар зарим үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн үнэ буюу бодит үнэ цэнээр бүртгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр заасныас бусад тохиолдолд мянгачилан, Группийн бүртгэлийн валют болох Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан.

**2.2.1 Тасралтгүй байх зарчим**

Дэлхий дахиныг хамарсан цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө 2021 онд ч үргэлжилсээр байв. Тэр дундаа олон улсын хилээ хаах, удаа дараагийн хөл хорио тогтоох зэрэг нь эдийн засгийг улам хүндрэлд оруулж, Монгол Улс улаан бүс хэмээн тодорхойлогдох болсноор жуулчид ирэхгүй хоёр жил болж байна. Эдгээрийг үл харгалзан, Говь ХК цахимаар дамжуулан дэлхийн томоохон зах зээлүүд болох Европ, АНУ, БНХАУ-д шинэ борлуулалтын сувгийг тэлэх зорилттойгоор маркетингийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Эдгээр хөрөнгө оруулалтын үр дүн нь Компанийн цахим хуудасны хандалт, худалдан авагчдын тоо, харилцагчийг татах зардал зэрэг маркетингийн түлхүүр үзүүлэлт сайжирсан байгаагаас харагдаж байна. Дээрх 3 зах зээлд үйл ажиллагаа явуулдаг Говь ХК-ийн гурван охин компанийн борлуулалт 40.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 29 хувиар, дотоодын борлуулалт 66.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 35 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Мөн, 2021 онд нэмэлтээр доор дурдсан санхүүжилтийн эх үүсвэрүүд шинээр бий болсон.





Говь ХК | Жилийн тайлан 2021

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.2 Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэлийн суурь (үргэлжлэл)**

**2.2.1 Тасралтгүй байх зарчим (үргэлжлэл)**

Хас Банктай шинээр байгуулсан жилийн 13.2%-ийн хүүтэй 25 тэрбум төгрөгийн зээлийн шугамын эрхийн гэрээнээс гадна, нэмэлтээр Таван Богд ХХК нь Говь ХК-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор эргэлтийн хөрөнгийн зориулалттай жилийн 6.7%-ийн хүүтэй 24 сарын хугацаатай 10 сая ам.долларын зээлийн шугамыг нээж өгсөн. Түүнчлэн, Групп нь эргэлтийн хөрөнгийн хэрэгцээг дэмжих зорилгоор жилийн 9%-ийн хүүтэй 12 сарын хугацаатай бонд гаргаж 10 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татсан.

2021 оны 7 дугаар сард Монгол Улсын Хөгжлийн Банк (МУХБ)-аас авсан 42.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй зээлийн нөхцөлийг өөрчилж зээлийн хүүг жилийн 12%, эргэн төлөлтийн хугацааг 2023 оны 6 дугаар сар, 40 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй зээлийн хүүг жилийн 11.5%, эргэн төлөлтийн хугацааг 2022 оны 5 дугаар сар хүртэл болгож тус тус сунгасан. Тухайн зээлүүдийг түүхий эд материал худалдан авах зориулалтын дагуу зарцуулсан ба зохих хууль, журмын дагуу шаардлагатай барьцаа хөрөнгийг байршуулан авсан.

Групп нь тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэсэн зарчим дээр тулгуурлан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэсэн бөгөөд удирдлагын зүгээс үүнийг зохистой гэж үнэлсэн.

**2.3 Нэгтгэлийн суурь**

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Компанийн болон түүний хяналтанд байдаг охин компаниудын санхүүгийн тайлангаас бүрддэг. Компани дараах тохиолдолд хяналтыг бий болгодог:

- Санхүүжигчийг удирдах чадвар;
- Санхүүжигчээс өөрийн оролцооны дагуу хувьсах өгөөж хүртэх эсвэл эрхээ шилжүүлэх; болон
- Санхүүжигчийн өгөөжид нөлөөлөх эрх мэдлийг ашиглах чадвар

Дээр дурдсан гурван шалгуурын аль нэгийг өөрчлөх нөхцөл болзол үүссэн тохиолдолд Групп нь санхүүжигчид тогтоосон хяналтаа алдсан эсэх талаар дахин үнэлнэ.

Санхүүжигчид нөлөө үзүүлэх саналын эрхийн олонхийг эзэмшдэггүй хэдий ч Компанийн эзэмшиж буй саналын эрх нь санхүүжигчийн холбогдох үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх бодит чадвартай байвал санхүүжигчид үзүүлэх нөлөө байна гэж үздэг. Компанийн эзэмшиж буй саналын эрх нь санхүүжигчийн холбогдох үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хүч байгаа эсэхийг дараах хүчин зүйлүүдээр үнэлдэг:

- Компанийн саналын эрхийн хэмжээ болон бусад хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тархалт болон сарнилт
- Компани болон бусад хувьцаа эзэмшигчдийн саналын эрхээ хэрэгжүүлэх чадвар
- Бусад гэрээгээр тохирсон саналын эрх
- Компанийн саналын эрх нь одоогийн холбогдох үйл ажиллагаанд нөлөөлж чадах бусад хүчин зүйлүүд

Компани охин компанийг хяналтандаа оруулсан өдрөөс эхлэн нэгтгэсэн санхүүгийн тайланд уг охин компанийг нэгтгэх ба охин компани дахь хяналтаа алдсан өдрөөс эхлэн нэгтгэхээ зогсоодог. Тусгайлан, охин компанийн тайлант жилийн орлого, зардлыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахдаа тухайн охин компани дахь хяналтыг олж авсан өдрөөс тухайн охин компани дахь хяналтаа алдсан өдөр хүртэл тасалбар болгон тайлант жилийн орлого, зардлыг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд нэгтгэдэг.

Охин компанийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогыг Группийн эзэд болон хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох хэсэг гэж ангилан харуулдаг. Охин компанийн нийт дэлгэрэнгүй орлогыг Группийн эзэд болон хяналтын эрхгүй хувь оролцоонд хуваарилах бөгөөд үүнийг хяналтын эрхгүй хувь оролцоо хасах үлдэгдэлтэй болох байсан ч хэрэгжүүлнэ.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.3 Нэгтгэлийн суурь (үргэлжлэл)

Хэрэв шаардлагатай бол, Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд охин компанийн санхүүгийн тайланд тохируулга хийдэг. Толгой болон охин компаниудын хооронд гарсан орлого, зардал, мөнгөн гүйлгээ болон хөрөнгө, өр төлбөр, өмчийн дансдын үлдэгдлийг нэгтгэсэн санхүүгийн тайланд бүрэн устгадаг.

#### 2.3.1. Группийн охин компани дахь эзэмшлийн хувийн өөрчлөлт

Охин компани дахь Группийн эзэмшлийн хувийн өөрчлөлтийг охин компани дахь хяналтын багцаа алдаагүй л бол эзэмшигчийн өмчийн ажил гүйлгээ байдлаар бүртгэнэ. Охин компани дахь Группийн хувь эзэмшил болон хяналтын эрхгүй хувь оролцооны дансны үнийг эзэмшлийн хувьд гарсан өөрчлөлтөөр залруулдаг. Хяналтын эрхгүй хувь оролцоон дахь өөрчлөлт ба төлсөн эсвэл хүлээн авсан зүйлийн бодит үнэ цэнийн хоорондох аливаа зөрүүг өмчид шууд хүлээн зөвшөөрч, Группийн эзэмшигчдэд хуваарилдаг.

Групп нь охин компани дахь хяналтын багцаа алдсан үед олз гарзыг (i) хүлээн авсан зүйлсийн бодит үнэ цэнэ ба үлдсэн эзэмшлийн хувийн бодит үнэ цэнийн нийлбэр (ii) охин компанийн хөрөнгө (гүүдвиллийг оролцуулаад) ба өр төлбөрийн дансны үнэ ба хяналтын эрхгүй хувь оролцооны зөрүүгээр тодорхойлно.

Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд охин компанитай холбоотой бүртгэсэн өмнөх бүх дүнг тэдгээр хөрөнгийн данснаас хасалт байдлаар бүртгэнэ (холбогдох СТОУС-д заасны дагуу ашиг, алдагдал руу ангилж тайлагнах эсвэл хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ). Өмнөх охин компанид үлдсэн аливаа хөрөнгө оруулалтын хяналтаа алдсан өдөрөх бодит үнэ цэнийг СТОУС 9 *Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*–ийн дагуу анхдагч хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнээр эсвэл хэрэв тохиромжтой бол хараат эсвэл хамтарсан хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалтын анхдагч хүлээн зөвшөөрөлтийн өртгөөр тооцно.

### 2.4 Бараа материал

Бараа материалыг жигнэсэн дундаж өртгийн аргаар хэмжсэн худалдан авалт ба/эсвэл үйлдвэрлэлийн өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар хэмжинэ. Худалдан авах зардал нь тайлант хугацаан дахь худалдан авалтын холбогдох нэмэлт зардлыг агуулдаг. Үйлдвэрлэлийн зардал нь шууд хамааралтай зардлууд ба бүтээгдэхүүнтэй холбоотойгоор гарсан шууд бус зардлын зарим хэсгийг багтаана. Цэвэр боломжит үнэ цэнэ нь тооцоолсон борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүнг хэлнэ. Бараа материалын хүлээгдэж буй хэрэглээ болон цэвэр боломжит үнэ цэнийг харгалзан бараа материал, бүтээгдэхүүний хувьд хасагдуулга нөөцийг шаардлагатай үед тодорхойлно.

### 2.5 Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь хараахан гараагүй төлбөр эсвэл хүлээн аваагүй бараа материалын төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд эсвэл хугацаа дуусах үед ашиг, алдагдал руу болон бараа материалыг хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгөд ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагадах бол урьдчилгаа төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст Групп урьдчилгаа төлбөрийн дансны үнэд хяналт тавьж, үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг тодорхойлдог.







**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.6 Үндсэн хөрөнгө

Группийн эзэмшиж буй газрын эрхийг анх хүлээн авсан өдрийн бодит үнэ цэнээр нь Группийн үндсэн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Групп нь газар эзэмших эрхийг олж эзэмшсэн өдрөөс эхлэн холбогдох газрын төлбөрийг улсад тушаадаг бөгөөд энэхүү төлбөрийн хэмжээ харьцангуй бага хэмжээтэй юм. Газрын эрхийг элэгдүүлдэггүй бөгөөд дахин үнэлсэн үнэ цэнээр хэмжинэ. Дуусаагүй барилгыг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайлагнана.

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг дараах зардлуудаас бүрдэнэ. Үүнд:

- Хөнгөлөлт, урамшууллын дараах худалдан авсан үнэ, гаалийн татвар болон худалдан авалттай холбоотой буцаан олгогдохгүй татвар;
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбоотой гарсан аливаа шууд зардлууд.

Худалдаж авсан программ хангамж нь холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой бол тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг байдлаар капиталжуулна.

Үндсэн хөрөнгийн өртөгт мэргэжлийн үйлчилгээний төлбөр, бэлтгэл шаардагдах хөрөнгийн хувьд Группийн 2.16-д тусгасан бодлогын дагуу капиталжуулсан зээлийн хүүгийн зардлыг багтаадаг. Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болгож суурилуулах үед тохирох үндсэн хөрөнгийн төрөлд нь ангилан бүртгэнэ.

Тайлант үеийн эцэст газар болон барилгаас бусад үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр хэмжинэ.

Дахин үнэлсэн дүнгээр илэрхийлэгдсэн газар болон барилгыг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд тэдгээрийн дахин үнэлсэн дүнгээр тайлагнах ба мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээчний зах зээлийн бодит нотолгоонд үндэслэн дахин үнэлсэн өдрийн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр тайлагнадаг. Дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрд хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлдог.

Дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн жилийн ашиг, алдагдлаар тусгадаг. Дахин үнэлсэн хөрөнгийг худалдах эсвэл ашиглалтаас хасах үед дахин үнэлгээний санд үлдсэн нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шууд шилжүүлнэ.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар Группд эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед өртгөөр үндсэн хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг.

Бусад бүх худалдан авалтын дараа гарсан зардлуудыг гарсан тайлант үед нь зардлаар бүртгэнэ.

Газар болон дуусаагүй барилгаас бусад үндсэн хөрөнгийн өртөг эсвэл дахин үнэлсэн дүнгээс тэдгээрийн үлдэгдэл өртгийг хассан дүнг шулуун шугамын аргаар, ашиглалтын жилд нь элэгдүүлдэг.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил:

| | |
|---|---|
| Барилга байгууламж | 10 - 40 жил |
| Тоног төхөөрөмж | 10 жил |
| Тавилга, эд хогшил | 2 - 10 жил |
| Тээврийн хэрэгсэл | 10 жил |
| Түрээсийн сайжруулалт | 2 - 5 жил |

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.6 Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг тооцох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг, алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг, алдагдалд тусгана.

### 2.7 Биет бус хөрөнгө

Ашиглагдах жил нь тодорхой, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжинэ. Биет бус хөрөнгийн хорогдлыг шулуун шугамын аргаар, биет бус хөрөнгийн ашиглалтын жилээр тооцоолон хүлээн зөвшөөрдөг. Тооцоолсон ашиглалтын жил болон хорогдол бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Ашиглагдах жил нь тодорхойгүй, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжинэ.

Биет бус хөрөнгийн ашиглалтын жил нь 2-оос 10 жил байна.

Биет бус хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл бүртгэлээс хасдаг. Биет бус хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг, алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг, алдагдалд тусгана.

### 2.8 Үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгө болон биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант үеийн эцэс бүрд Групп нь үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгө ба биет бус хөрөнгийн дансны үнэд үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрсэн эсэхийг тодорхойлох шалгуур хийдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол үнэ цэнэ бууралтын гарз (ийм гарз гарсан бол)-ыг тогтоохын тулд тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно. Хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тухайн хөрөнгийн хувьд тооцоолох боломжгүй бол Групп нь уг хөрөнгийн харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнийг тооцоолно. "Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах боломжийн бөгөөд туушгай суурь үзүүлэлтийг тодорхойлж чадвал аж ахуйн зориулалттай хөрөнгийг тодорхой "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах ба ийм боломжгүй бол хамгийн боломжийн бөгөөд туушгай ашиглах боломжтой суурь үзүүлэлтийг ашиглан хамгийн жижиг "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хамааруулан шалгадаг.

Хөрөнгийн эсвэл "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнэ гэдэг нь хөрөнгийг ашигласнаар олж болох өгөөж ба хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртөг зардлыг хассан цэвэр дүн хоёрын аль ихээр нь тогтоогдоно. Ашигласнаар олж болох өгөөжийг үнэлэхдээ одоогийн мөнгөний үнэ цэнийн зах зээлийн үнэлэмж болон хөрөнгийн тусгайлсан эрсдэлийг тусгасан татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан тооцсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг ашигладаг. Үнэ цэнэ бууралтын шалгуурын зорилгоор дангаар нь шалгах боломжгүй хөрөнгийг бусад хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгөөс ("мөнгөн орлого үүсгэгч нэгж") хамааралгүйгээр дангаараа мөнгөн орлого бий болгох чадвартай хамгийн жижиг хөрөнгийн бүлэгт хамааруулан шалгадаг.

Нэгж хөрөнгө эсвэл түүний харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн дансны үнэ нь нөхөгдөх боломжтой тооцоолсон үнээс их байвал үнэ цэнэ бууралтын гарзыг бүртгэж, ашиг, алдагдлаар тусгана. "Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн хувьд тодорхойлсон үнэ цэнэ бууралтын гарзыг бүртгэхдээ эхлээд тухайн нэгжид хуваарилагдсан гүүдвиллийн дансны үнийг бууруулах ба үлдсэн алдагдлын дүнгээр тухайн нэгж (бүлэг нэгж)-д багтсан бусад хөрөнгийн дансны үнийг хувь тэнцүүлэн бууруулна.







**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.8 Үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгө болон биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Өмнөх жилүүдэд бүртгэсэн үнэ цэнэ бууралтын алдагдал буурсан эсвэл алдагдал үгүй болсон эсэхийг илрүүлэхийн тулд үнэ цэнэ бууралтын алдагдлыг тайлангийн өдрөөр дахин хянана. Нөхөгдөх боломжтой дүнг тодорхойлоход ашигласан тооцоолол өөрчлөгдсөн бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана, үүнд гүүдвиллийн үнэ цэнийн бууралтын алдагдал хамаарахгүй. Үнэ цэнийн бууралт бүртгээгүй байсан бол байх байсан элэгдэл, хорогдлыг хассан хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй байхаар бодож үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

### 2.9 Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрүүдийг Групп тухайн хэрэглүүртэй холбоотой гэрээт тал болох үед нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэх ба үүнд гэрээт харилцагчдаас үүссэн дансны авлагыг СТОУС 9-ийн дагуу анх бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр (ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад)-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасаж бүртгэнэ.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг тухайн жилийн ашиг, алдагдлаар бүртгэнэ.

### 2.10 Санхүүгийн хөрөнгө

Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг.

Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцөлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийг ангиллаас нь хамааран анх бүртгэсний дараа хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр нь хэмждэг.

#### 2.10.1 Санхүүгийн хөрөнгийн ангилал

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүд нь дараа үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ:

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой бизнесийн загвараар эзэмшдэг; болон
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх.

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэглүүдийг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжинэ (БДОБҮЦ):

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд эсвэл арилжаалах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загвараар эзэмшдэг; болон
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх.

Бусад бүх санхүүгийн хөрөнгийг дараа үед ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнэ (ААБҮЦ)-ээр хэмжинэ.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

#### 2.10.1 Санхүүгийн хөрөнгийн ангилал (үргэлжлэл)

Дээр дурдсанаас үл хамааран, Групп санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед дараах ангиллыг сонгон бүртгэж болно:

- Групп тодорхой шалгууруудыг хангасан тохиолдолд буцаах сонголтгүйгээр өмчийн хэрэглүүр дэх хөрөнгө оруулалтыг дараа үеүдэд хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор тусгаж болно; болон
- Групп өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртөг эсвэл БДОБҮЦ-ээр бүртгэх зарчмыг сонгосон байсан нягтлан бодох бүртгэлийн нийцгүй байдлыг арилгана гэж үзэж байвал буцаах сонголтгүйгээр ААБҮЦ-ээр тусгаж болно.

Группийн санхүүгийн хөрөнгө нь хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгөөс бүрдэж байна.

*Хорогдуулсан өртөг болон үр ашигт хүүгийн арга*

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг тооцоолон, хүүгийн орлогыг хугацааны туршид хуваарилах арга юм.

Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгөөс бусад (анхлан хүлээн зөвшөөрөхдөө үнэ цэнэ нь буурсан хөрөнгө) санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан)-ийг санхүүгийн өрийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй тэнцүү байхаар үнэ цэнийн бууралтын нөөцийг хасахын өмнөх төлбөрийг өрийн хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

Санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, анхны дүн ба дуусгавар болох үеийн дүнгийн хооронд үүссэн аливаа зөрүүг үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон хорогдуулгыг нэмж аливаа алдагдлын нөөцийг тохируулсан дүнгээр тодорхойлогдоно.

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь аливаа алдагдлын нөөцөөр тохируулаагүй дүн байна.

Хүүгийн орлогыг анх үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр болон БДОБҮЦ-ээр хэмжигдэх бүх өрийн хэрэгслүүдийн хувьд бүртгэдэг. Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хүүгийн орлогыг тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэд үр ашигт хүүгийн түвшинг ашиглах замаар тооцоолно.

Дараа тайлант үед зээлийн үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийн хорогдуулсан өртөгт үр ашигт хүүгийн түвшин ашиглах замаар тодорхойлно. Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл дараа тайлант үед сайжирч санхүүгийн хөрөнгө нь зээлийн үнэ цэнийн бууралтгүй болсон ч гэсэн тооцооллыг нийт сууриар буцаахгүй.

Хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар тайлагнадаг ба "санхүүгийн ба бусад орлогын хүүгийн орлого" хэсэгт ангилна.

#### 2.10.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Групп хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгөд хүлээгдэж буй алдагдлыг хүлээн зөвшөөрөн бүртгэдэг. Тухайн санхүүгийн хэрэгслийг хүлээгдэж буй алдагдлын дүн анх хүлээн зөвшөөрч бүртгэснээс хойш эрсдэлийн өөрчлөлтийг үнэлж тайлант хугацаа болгонд шинэчилнэ.





Говь ХК | Жилийн тайлан 2021

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

#### 2.10.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Групп дансны авлагад нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдлыг тооцоолон бүртгэдэг. СТОУС 9-ийн дагуу үнэ цэнийн бууралттай авлагаас бусад дансны авлагын үлдэгдэл нь 400 сая төгрөгөөс давсан бөгөөд даатгагдаагүй авлагыг тусгайлан үнэлж, үлдсэн авлагын дүнг хугацаа хэтэрсэн хоногт үндэслэн багцын аргаар тооцсон.

Эдгээр санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо алдагдлын түүхэн мэдээллийг зээлдэгчдэд тусгайлан тодорхойлсон хүчин зүйлс, үндсэн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн нөхцөл байдал, одоогийн болон ирээдүйг таамаглаж буй мэдээллийг тайлагналын өдрөөр харгалзан тохируулсан матрицыг ашиглан тооцоолж болох бөгөөд уг тооцоололд тохиромжтой гэж үзвэл мөн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг харгалзан үзэж болно.

Нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдал нь санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид гарах бүхий л боломжит дефолт үйл явдлаас үүсэх алдагдлыг илэрхийлнэ.

*(i) Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт*

Санхүүгийн хэрэгслийн зээлийн эрсдэл нь анх бүртгэлд тусгаснаас хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ Групп анх бүртгэлд тусгасан өдрийн санхүүгийн хэрэгслээс үүссэн эрсдэлийг, тайлант өдрөөрх эрсдэлийн дүнтэй харьцуулдаг. Энэхүү үнэлгээг хийхдээ Групп үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц тоон болон чанарын мэдээллийн аль алиныг нь харгалзан үзэх ба эдгээр нь түүхэн туршлага болон өндөр хүчин чармайлт, өртөг шаардахааргүйгээр олж авах боломжтой ирээдүйг таамаглаж буй мэдээллүүд байна.

Ирээдүйг таамаглаж буй мэдээлэлд Группийн зээлдэгчийн үйл ажиллагаа эрхэлдэг салбарын ирээдүйн хэтийн төлөвийг агуулсан, эдийн засгийн шинжээчийн тайлангаас авсан мэдээлэл болон санхүүгийн шинжээч, засгийн газрын байгууллага, холбогдох судалгааны байгууллага, бусад ижил төстэй байгууллагаас гаргасан мэдээллүүд болон Группийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой эдийн засгийн бодит болон урьдчилан таамагласан янз бүрийн гадаад эх сурвалжийн мэдээллүүдийг авч үздэг.

Зээлийн эрсдэл нь анх хүлээн зөвшөөрснөөс хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ дараах мэдээллийг харгалзан үзнэ:

- Санхүүгийн хэрэгслийн гадаад (хэрэв байгаа бол) эсвэл дотоод зээлийн үнэлгээний бодит эсвэл хүлээгдэж буй мэдэгдэхүйц бууралт;
- Тухайн санхүүгийн хэрэгслийн гадаад зах зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүдийн бууралт. Үүнд: ижил төстэй хэрэглүүрийн өгөөжийн түвшин ихээхэн ялгаатай байх, зээлийн эрсдэлийг солилцох гэрээний үнэ эсвэл шаардагдах цаг хугацаа болон үргэлжлэх байдлын улмаас санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь хорогдуулсан өртгөөсөө бага байх;
- Одоо байгаа эсвэл урьдчилан таамагласан бизнест нөлөөлж болохуйц сөрөг өөрчлөлт, зээлдэгчийн өрийг эргэн төлөх чадварыг бууруулж болзошгүй нөлөөлөх санхүүгийн эсвэл эдийн засгийн нөхцөл байдлууд;
- Зээлдэгчийн үйл ажиллагааны бодит эсвэл хүлээгдэж буй үр дүнгийн мэдэгдэхүйц бууралт;
- Зээлдэгчийн бусад санхүүгийн хэрэгслүүдийн зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт;
- Зээлдэгчийн хууль эрх зүй, эдийн засаг, технологийн орчинд гарч буй бодит буюу хүлээгдэж буй томоохон сөрөг өөрчлөлтүүд нь төлбөрийн үүргээ биелүүлэх чадварыг мэдэгдэхүйцээр бууруулах.

Дээрх үнэлгээний үр дүнгээс үл хамааран Групп анх бүртгэлд тусгаснаас хойш гэрээний төлбөр 30 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн үед санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн гэж үзнэ. Хэрвээ зээлийн эрсдэл мэдэгдэхүйцээр нэмэгдээгүйг илтгэх үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц нотолгоо байгаа тохиолдолд эрсдэлийг мэдэгдэхүйцээр нэмэгдсэн гэж үзэхгүй байж болно.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

### 2.10.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

*(i) Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (үргэлжлэл)*

Хэрэв санхүүгийн хэрэгсэл нь тайлант өдрөөр эрсдэлийн түвшин бага гэж тодорхойлогдсон бол дээр дурдсанаас үл хамааран Групп санхүүгийн хэрэгслийн зээлийн эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц өсөлт гараагүй гэж үздэг. Санхүүгийн хэрэгсэл нь дараах нөхцөлд зээлийн эрсдэл бага гэж тодорхойлогдоно:

- Санхүүгийн хэрэгсэл нь эргэн төлөгдөхгүй байх эрсдэл багатай,
- Зээлдэгч ойрын хугацаанд гэрээний мөнгөн урсгалын үүргийг биелүүлэх бүрэн чадавхтай, мөн
- Урт хугацаанд эдийн засгийн болон бизнесийн нөхцөл байдалд гарах сөрөг өөрчлөлт нь зээлдэгч гэрээний мөнгөн урсгалын үүргээ биелүүлэх чадварыг бууруулж болзошгүй боловч энэ нь заавал бууруулна гэж тооцохгүй байж болно.

Хэрэв Группийн санхүүгийн хөрөнгө нь дэлхийн түвшинд танигдсан зээлийн үнэлгээний тодорхойлолттой нийцсэн эсвэл хөндлөнгийн үнэлгээний мэдээллийн олдоц хомс тохиолдолд, дотооддоо "хэвийн" гэж үнэлсэн санхүүгийн хөрөнгийг эрсдэл багатай гэж үзнэ. "Хэвийн" гэсэн үнэлгээ нь оролцогч тал санхүүгийн хувьд өндөр чадавхтай бөгөөд өнгөрсөн хугацаанд хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй үүрэг үүсээгүй байхыг хэлнэ.

Групп зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг тодорхойлоход ашигласан шалгуурууд нь зээл ба авлагын төлөгдөх хугацаа хэтрэхээс өмнө эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийг тодорхойлох үр ашигтай үзүүлэлтүүд гэдгийг тогтмол хянадаг ба шаардлагатай тохиолдолд өөрчилдөг.

*(ii) Дефолтын тодорхойлолт*

Групп дотоод удирдлагын зорилгоор түүхэн туршлагад үндэслэн зээлийн эрсдэлийн дараах шалгууруудын аль нэгийг нь хангасан санхүүгийн хөрөнгүүд нь нөхөгдөх боломжгүй болсон үед үүнийг дефолт үйл явдал гэж үздэг.

- Зээлдэгч гэрээнд заасан санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдийг зөрчсөн тохиолдолд; эсвэл
- Зээлдэгчийн талаар дотооддоо боловсруулсан эсвэл гадаад эх сурвалжаас авсан мэдээлэл нь зээлдэгч бусад зээлдүүлэгчдэд болон Группд зээл ба авлагаа бүрэн эргүүлэн төлөх магадлал багатайг илэрхийлж буй тохиолдолд (Группийн эзэмшиж буй барьцаа хөрөнгийг харгалзан үзэхгүй).

Дээрх шалгуураас үл хамааран Группийн санхүүгийн хөрөнгийн төлбөр төлөх хугацаа 90 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн бол дефолт үйл явдал гэж үзнэ. Хэрвээ гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд нэмэлт хугацаа хэрэгтэй болсныг батлах үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц мэдээлэл байгаа бол дээрх тодорхойлолтод хамаарахгүй байж болно.

*(iii) Үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүд*

Нэг болон түүнээс дээш үйл явдал тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээн авахаар тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралттай гэж үзнэ. Дараах тодорхойлолтууд нь санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан илэрхий нотолгоо болох юм:

- Үнэт цаас гаргагч эсвэл зээлдэгч талд томоохон хэмжээний санхүүгийн хүндрэл үүссэн;
- Гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, тухайлбал эргэн төлөлтийг төлбөрийн хугацааг хэтрүүлэх эсвэл төлөх чадамжгүй болох (дээр дурдсан (ii)-ийг харна уу);
- Зээлдэгчийн санхүүжүүлэгч нь зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдлаас үүссэн эдийн засгийн болон гэрээний шалтгааны улмаас зээлдэгчидтэй тохирсон үүрэг амлалтаа хэрэгжүүлэх боломжгүй болох;





Говь ХК | Жилийн тайлан 2021

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.10 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

### 2.10.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

*(iii) Үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүд (үргэлжлэл)*

- Зээлдэгч нь дампуурлаа зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин бүтцийн өөрчлөлт хийх магадлалтай болсон;
- Санхүүгийн хүндрэлээс болж тухайн санхүүгийн хөрөнгийн идэвхтэй зах зээл байхгүй болох.

*(iv) Бүртгэлээс хасах*

Групп санхүүгийн хөрөнгийг зээлдэгч нь томоохон санхүүгийн хүндрэлд орсон ба зээлдэгчийн татан буугдах эсвэл дампуурах үйл явц эхэлсэн, авлага төлөгдөх хугацаа 1 жилээс дээш хугацаагаар хэтэрсэн зэрэг үйл явдлын аль нэг нь бий болсон үед буюу авлагын эргэн төлөлт хийгдэх бодит боломж байхгүй болсон үед бүртгэлээс хасна.

Бүртгэлээс хасагдсан санхүүгийн хөрөнгөд Группийн бодлогын дагуу авлага цуглуулах үйл явц хийгдэж, хуулийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч болно. Бүртгэлээс хасагдсан авлага нь эргэн төлөгдсөн тохиолдолд тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд тусгана.

*(v) Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх, хэмжих*

Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь төлбөр төлөгдөхгүй байх магадлал (тухайлбал төлбөрийн чадваргүй болсон үе дэх алдагдлын далайц), алдагдал үүсэх магадлал болон эрсдэлд өртөх боломжтой зээл ба авлагын дүнгийн үржвэр юм. Төлбөр төлөгдөхгүй байх магадлал болон алдагдал үүсэх магадлалын үнэлгээ нь дээр өгүүлэгдсэн ирээдүйг таамаглаж буй мэдээллээр залруулагдсан түүхэн мэдээлэлд үндэслэдэг.

Тайлагналын өдрийн байдлаар дансны үнээрээ толилуулагдсан эрсдэлтэй санхүүгийн хөрөнгийг Группийн зээлдэгчийн ирээдүйд шаардагдах санхүүжилтийн хэмжээ болон ирээдүйг таамаглаж буй мэдээллүүд ашиглан тодорхойлно.

Тайлангийн өдрөөрх эрсдэлд өртөх магадлалтай зээл ба авлага нь тухайн санхүүгийн хөрөнгийн дансны үнээрээ илэрхийлэгдсэн.

Санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй зээлийн алдагдал нь гэрээний дагуу Группийн хүлээн авах эрх бүхий нийт мөнгөн урсгал болон Группийн хүлээн авахаар тооцоолсон бүх мөнгөн гүйлгээг үр ашигт хүүгийн аргаар дискаунтчилсан дүнгийн зөрүүгээр тооцоологддог.

Хэрэв өмнөх тайлант үед санхүүгийн хэрэгслийн алдагдлын нөөц сан нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлаар хэмжигдсэн хэдий ч тайлант жилийн эцэст нийт хугацаанд хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлын шалгуурыг хангаагүй бол Групп хялбарчилсан аргачлал ашигласан хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийн хувьд тайлант жилийн эцэсээрх 12 сарын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолдог.

Групп санхүүгийн бүх хэрэгслийн үнэ цэнийн олз гарзыг тухайн холбогдох дансны үнэ цэнийн хасагдуулга дансаар дамжуулан дансны үнэд залруулж бүртгэнэ.

### 2.10.3 Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах

Групп нь зөвхөн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон эсвэл санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг бусдад шилжүүлсэн үед санхүүгийн хөрөнгийг данснаас хасна.

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан дүн болон авлагын нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.11 Санхүүгийн өр төлбөр ба өмч**

**2.11.1 Өр төлбөр эсвэл өмчөөр ангилах**

Өрийн болон өмчийн хэрэгслийг тэдгээрийн гэрээгээр хүлээсэн нөхцөлийн бодит байдал ба санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслийн тодорхойлолтод үндэслэн өр эсвэл өмчийн хэрэгслээр ангилдаг.

**2.11.2 Өмчийн хэрэгсэл**

Группийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Группээс гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

**2.11.3 Санхүүгийн өр төлбөр**

Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Группийн санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг.

2.11.3.1 Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож, холбогдох хугацааны туршид хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан)-ийг санхүүгийн өр төлбөрийн хугацааны туршид эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хорогдуулахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

2.12.3.2 Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах

Групп нь санхүүгийн өр төлбөрийг зөвхөн гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд данснаас хасна. Данснаас хасч буй санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба төлсөн дүн болон өглөгийн нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

**2.12 Орлого хүлээн зөвшөөрөлт**

СТОУС 15-ын дагуу Групп нь гэрээнд заасан гүйцэтгэлийн үүрэг хангагдсан буюу бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналтыг худалдан авагч талд шилжүүлсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө.

Гүйцэтгэлийн үүрэг гэдэг нь өөр хоорондоо ялгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээ (бараа үйлчилгээний багц) нийлүүлэх үүргийг хэлнэ.

Дараах шалгууруудын аль нэг нь хангагдсан тохиолдолд Групп холбогдох гүйцэтгэлийн үүргийг тодорхой хугацааны туршид биелэгдэх гүйцэтгэлийн үүрэг гэж үзэж тэрхүү хугацааны туршид орлогоо хэсэгчлэн хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Групп гүйцэтгэлийн үүргээ биелүүлсэн цаг хугацаатай зэрэгцэн, уг ажлын гүйцэтгэлээр дамжуулан худалдан авагч үр өгөөж хүртэх;
- Группийн гүйцэтгэлийн үүргийн биелэлт нь ямар нэг хөрөнгийг бий болгодог эсвэл хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлдэг бөгөөд уг хөрөнгө бий болсон эсвэл үнэ цэнэ нь нэмэгдэх бүрд худалдан авагч хяналтыг өөртөө авах; эсвэл
- Группийн гүйцэтгэлийн үүргийн биелэлтээр дамжин бий болж буй хөрөнгийг Групп ашиглаж үр өгөөж хүртэх боломжгүй хэдий ч гүйцэтгэлийн үүрэг хангагдах бүрд төлбөр хүлээн авах эрхтэй байх.

Бусад тохиолдолд, худалдан авагч нь өөр хоорондоо ялгаатай бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний хяналтыг авах үед тодорхой нэг хугацаанд хангагдах гүйцэтгэлийн үүрэг гэж үзэж орлогыг хүлээн зөвшөөрнө.





Говь ХК | Жилийн тайлан 2021

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.12 Орлого хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)**

Орлогыг худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу Группийн хүлээн авах эрхтэй гэж үзэж буй төлбөрийн дүнд үндэслэн хэмжинэ. Групп нь гэрээнд заасан гүйцэтгэлийн үүрэг хангагдсан буюу тусгайлан бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналтыг худалдан авагч талд шилжүүлсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө.

Гэрээний хөрөнгө нь хөрөнгийг худалдан авагчид шилжүүлсэн боловч бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээтэй холбоотой төлбөрийг Групп хүлээн авах эрх үүсээгүй үед бий болох хөрөнгө юм. Уг гэрээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг СТОУС 9-ийн дагуу хэмжинэ. Эсрэгээрээ, авлага нь тодорхой хугацааны дотор төлөгдөх, цаг хугацаанаас өөр хүчин зүйлээс хамааралгүй, төлбөр хүлээн авах эрх юм.

Гэрээний өр төлбөр нь худалдан авагчаас төлбөр хүлээн авсан боловч худалдан авагчид барааг шилжүүлэх эсвэл үйлчилгээ үзүүлэх (төлөх ёстой төлбөрийн хэмжээ) Группийн үүргийг илэрхийлнэ.

Нэг гэрээтэй холбоотой гэрээний хөрөнгө ба гэрээний өр төлбөрийг цэвэр дүнгээр нь тайлагнана.

Группийн орлого нь дараах үндсэн эх үүсвэрээс бүрддэг:

a) Барааны борлуулалт;
b) Үйлчилгээний орлого;
c) Бусад орлого.

**2.12.1 Барааны борлуулалт**

Групп нэхмэл, оёмол болон сүлжмэл ноолууран бүтээгдэхүүнийг жижиглэнгийн болон бөөний худалдаагаар борлуулдаг.

Бөөний худалдан авагчид хийсэн борлуулалтыг тухайн бүтээгдэхүүний хяналтыг худалдан авагчид шилжүүлсэн үед бүртгэдэг. Хяналт шилжсэн гэдэг нь бүтээгдэхүүнийг бөөний худалдан авагчид хүргэсэн, бөөний худалдан авагч нь тухайн бүтээгдэхүүний борлуулалтын суваг болон бүтээгдэхүүний үнэтэй холбоотой шийдвэр гаргах эрх худалдан авагчид бүрэн шилжсэнийг хэлнэ. Бөөний худалдан авагчтай байгуулсан гэрээнд заасан тодорхой цэгт барааг хүргүүлсэн, бараатай холбоотой бүхий л эрсдэл бөөний худалдан авагчид шилжсэн, худалдан авагч гэрээнд заасан барааг хүлээн авснаа зөвшөөрсөн зэрэг барааны өмчлөл ба эрсдэлтэй холбоотой бүх нөхцөл биелсэн үед барааг худалдан авагчид хүргэсэн гэж үзнэ.

Барааг худалдан авагчид хүргэсэн тухайн цаг үед буюу төлбөрийг хүлээн авах нь тодорхой бөгөөд төлбөрийг хүлээн авах нь зөвхөн цаг хугацааны асуудал болсон үед авлагыг бүртгэнэ.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлогыг барааны хяналтыг шилжүүлсэн үед буюу худалдан авагч дэлгүүрт барааг худалдан авсан үед бүртгэнэ. Худалдан авагч барааг худалдан авмагц гүйлгээний төлбөрийг нэхэмжилдэг.

Группийн бодлогын дагуу жижиглэнгийн худалдан авагчид худалдан авсан бараагаа 7 хоногийн дотор, бөөний худалдан авагчид гэрээгээр тохирсон хязгаарт багтаан буцаах эрхтэй. Тиймээс гэрээний өр төлбөр (буцаагдах боломжит өр төлбөр) болон буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө (эргэлтийн хөрөнгөөр тайлагнагдсан)-ийг буцаагдах боломжит дүнд үндэслэн бүртгэнэ.

Хувьсах төлбөртэй холбогдсон тодорхойгүй хүчин зүйлс нь хожим тодорхой болоход хүлээн зөвшөөрөгдсөн орлогын дүнд өндөр нөлөөгүй бол хувьсах төлбөрийн тооцоолсон дүнг ажил гүйлгээний үнэд оруулан тооцно.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.12 Орлого хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

#### 2.12.2 Үйлчилгээний орлого

Үйлчилгээний орлого нь холбоотой талууд болон бусад харилцагчид үзүүлдэг хими цэвэрлэгээ болон хувь захиалгын үйлчилгээтэй холбоотой.

Групп гүйцэтгэлийн үүргээ биелүүлэх үед уг гүйцэтгэлээр дамжуулан харилцагч үр өгөөж хүртэлх болон хяналтыг нэгэн зэрэг шилжүүлэн авснаар борлуулалтын орлогыг үйлчилгээ үзүүлж буй хугацааны туршид хүлээн зөвшөөрнө.

Гүйцэтгэлийн үүргийн ахиц дэвшлийг гарцын аргаар хэмжих бөгөөд тодорхой өдөр хүртэл харилцагчид шилжүүлсэн бараа, үйлчилгээний бодит үнэ цэнийг Группийн гэрээний дагуу шилжүүлэхээр амласан үлдсэн бараа, үйлчилгээнд ногдох дүнгээр орлого хүлээн зөвшөөрнө.

#### 2.12.3 Бусад орлого

Бусад орлого нь түүхий эд материал болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг дотоодын харилцагчид борлуулдагтай холбоотой. Бүтээгдэхүүнийг Группийн агуулахаас илгээж, бүтээгдэхүүний хяналтыг харилцагч авах үед бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг. Тодорхой нэг хугацаанд борлуулалтын нэхэмжлэх үүсч орлого хүлээн зөвшөөрдөг. Орлогыг Группийн харилцагчтай байгуулсан гэрээгээр авах эрхтэй хүлээгдэж буй төлбөрийг үндэслэн хэмжинэ.

Групп нь гүйцэтгэлийн үүргээ биелүүлж, тухайлбал бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналтыг харилцагчид шилжүүлж, ялангуяа бараа харилцагчийн тодорхой байршилд (хүргэлт) хүргэгдсэн үед бусад орлогыг хүлээн зөвшөөрнө.

#### 2.12.4 Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө болон өр төлбөр

*Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө*

Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө нь харилцагчаас буцаагдаж ирэхээр хүлээгдэж буй барааг хүлээн авах Группийн эрхийг илэрхийлнэ. Хөрөнгийг барааны өмнөх дансны үнээс буцаагдаж ирэх барааны боломжит үнийн бууралтыг багтаасан барааг буцаах үед гарах хүлээгдэж буй зардлыг хасч хэмжинэ. Групп буцаагдахаар хүлээгдэж буй барааны хөрөнгийн хэмжилтэд орох аливаа өөрчлөлт болон үнэ цэнийн аливаа нэмэлт бууралт байгаа эсэхийг үнэлж шинэчилдэг. Өмнөх жилүүдэд тогтмол хэмжээний барааны буцаалт хийгдэж байсан тул мэдэгдэхүйц хэмжээний орлогын буцаалт бүртгэгдэх магадлал бага байна гэж үздэг.

*Буцаах эрхтэй барааны өр төлбөр*

Буцаах эрхтэй барааны өр төлбөр нь харилцагчаас хүлээн авсан нийт төлбөр (эсвэл авлага) эсвэл төлбөрийн зарим хэсгийг буцаан олгох үүрэг хариуцлага бөгөөд Групп харилцагчид буцаан олгоно гэж хүлээгдэж буй тооцоолсон дүнгээр хэмжигдэнэ. Групп тайлант үе бүрийн эцэст буцаах эрхтэй барааны өр төлбөр (ба гүйлгээний үнийн харгалзах өөрчлөлт)-ийн тооцооллыг шинэчилдэг.

### 2.13 Түрээс

#### 2.13.1 Түрээсийн тодорхойлолт

Хэрвээ тодорхой төлбөртэйгөөр тогтсон хугацааны туршид, тодорхой хөрөнгийг ашиглаж, хянах эрх үүссэн бол тухайн гэрээг түрээсийн гэрээ эсвэл уг гэрээнд түрээсийн зүйл агуулагдсан байна гэж үзнэ.





**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.13 Түрээс (үргэлжлэл)

#### 2.13.1 Түрээсийн тодорхойлолт (үргэлжлэл)

СТОУС 16-г анх хэрэгжүүлэх үед эсвэл дараа нь бизнесийн нэгдэлтэй холбоотойгоор үүссэн болон өөрчилсөн гэрээнүүдийг Групп СТОУС 16-д тодорхойлсны дагуу гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээсийн зүйл агуулагдсан эсэхийг гэрээг өөрчилсөн өдөр эсвэл худалдан авалтын өдрийн аль тохиромжтой өдрөөр үнэлнэ. Гэрээний нөхцөл дараа нь өөрчлөгдөөгүй бол дахин үнэлэх шаардлагагүй.

#### 2.13.2 Түрээслэгч - Групп

*Гэрээний зүйл тус бүрийн төлбөрийн хуваарилалт*

Групп нь түрээсийн зүйл ба нэмэлтээр нэг эсвэл түүнээс дээш түрээс эсвэл түрээсийн бус зүйл агуулсан гэрээний хувьд түрээсийн зүйлийн гэрээ нэг бүрийн төлбөрийг түрээсийн ба түрээсийн бус зүйлсийн нэг бүрийн үнийн нийлбэр дээр суурилан хуваарилна.

*Богино хугацаат түрээс ба бага үнэтэй хөрөнгийн түрээс*

Групп нь гэрээний хугацаа нь 12 сар ба түүнээс бага хугацаанд түрээслэх худалдан авах нөхцөлгүй дэлгүүр болон агуулахуудын түрээсийг богино хугацаат түрээсээр хүлээн зөвшөөрнө. Бага үнэтэй богино хугацаат түрээсийн төлбөр ба бага үнэтэй хөрөнгийн түрээсийг мөн адил хүлээн зөвшөөрнө. Богино хугацаат түрээс болон бага үнэтэй хөрөнгийн түрээсийг шулуун шугамын арга эсвэл бусад системчлэгдсэн аргууд дээр суурилан түрээсийн хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрнө.

*Ашиглах эрхтэй хөрөнгө*

Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөгт дараах зүйлс багтана:

- Түрээсийн өр төлбөрийн анх тооцсон дүн;
- Түрээс эхэлснээс эсвэл эхлэхээс өмнө төлсөн түрээсийн төлбөрөөс түрээснээс авсан урамшууллыг хассан дүн;
- Группийн зарцуулсан анхдагч шууд зардлууд; болон
- Түрээсийн шаардсан нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тодорхой хөрөнгийг буулгах, нүүлгэх, хөрөнгө байрлах газрыг сэргээх эсвэл тухайн хөрөнгийг сэргээхэд Группээс гарсан зардлын тооцоолсон дүн.

Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийг өртгөөс нь үнэ цэнийн бууралт болон хуримтлагдсан элэгдлийг хассан дүнгээр хэмждэг ба түрээсийн өр төлбөрт хийгдсэн аливаа өөрчлөлтөөр залруулдаг.

Групп нь түрээсийн гэрээ дуусгавар болох үед тодорхой түрээсийн хөрөнгийн өмчлөлийг шилжүүлэн авах бол ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийг түрээс эхэлсэн өдрөөс эхлэн ашиглагдах хугацаа дуусгавар болох хүртэл элэгдүүлнэ. Өөрөөр заагаагүй бол, ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийн тооцоолсон ашиглагдах хугацаа ба түрээсийн хугацааны аль багаар нь шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Групп нь хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө болон бараа материалын тодорхойлолтод нийцээгүй ашиглах эрхтэй хөрөнгийг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусдаа мөрөөр толилуулна.

*Буцаан авах түрээсийн барьцаа*

Төлөгдсөн буцаан авах түрээсийн барьцааг СТОУС 9 *Санхүүгийн хэрэглүүр*-ийн дагуу бодит үнэ цэнээр нь анх хүлээн зөвшөөрнө. Анх хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн залруулга нь нэмэлт түрээсийн төлбөр байх ба ашиглах эрхтэй хөрөнгийн өртөгт оруулан бүртгэнэ.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.13 Түрээс (үргэлжлэл)

### 2.13.2 Түрээслэгч - Групп (үргэлжлэл)

*Түрээсийн өр төлбөр*

Групп нь түрээс эхэлсэн өдрөөр төлөгдөөгүй байсан түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Түрээсийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоход Групп нь түрээсийн хүүгийн түвшин тодорхойлох боломжгүй үед түрээс эхлэх өдрөөр түрээсийн гэрээний нуугдмал хүү мэдэгдэхгүй бол зээлийн өсөн нэмэгдэх хүүг ашиглана.

Түрээсийн төлбөрт дараах зүйлс багтана:

- Тогтмол төлбөрүүдээс (бодит тогтмол төлбөрүүд) түрээсийн урамшууллыг хассан дүн;
- Гэрээ эхлэх өдрөөр үнийн индекс эсвэл ханшийг ашиглан тодорхойлогдсон үнийн индекс эсвэл ханшнаас хамааралтай хувьсах түрээсийн төлбөрүүд;
- Үлдэх өртгийн баталгаагаар Группээс төлөгдөх боломжтой төлбөрийн дүн;
- Группийн худалдан авах сонголтоо хэрэгжүүлэх нь үндэслэлтэйгээр тодорхой бол уг сонголтыг хэрэгжүүлэх үнэ; болон
- Түрээсийн гэрээнд Групп нь түрээсийн хугацааг цуцлах эрхтэй үед түрээсийн гэрээг цуцлахад үүсэх торгууль.

Хувьсах төлбөртэй түрээсийн төлбөрийг гэрээ хэрэгжиж эхэлсэн өдрөөрх түрээсийн зах зээлийн үнээр анх хүлээн зөвшөөрнө. Үнийн индекс эсвэл ханшнаас хамааралгүй хувьсах түрээсийн төлбөрийг түрээсийн өр төлбөр ба ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийн дүнд оруулахгүй ба түрээсийн төлбөр гарсан тохиолдолд эсвэл нөхцөл үүссэн үед зардлаар хүлээн зөвшөөрнө.

Гэрээ хэрэгжиж эхэлснээс хойш түрээсийн өр төлбөрийг хүүгийн өсөлт ба түрээсийн төлбөрийн дүнгээр тохируулна.

Дараах тохиолдолд Групп нь түрээсийн өр төлбөрийг (ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгөтэй холбоотой залруулгын хамт бүртгэж) дахин хэмжинэ:

- Түрээсийн хугацаа өөрчлөгдсөн эсвэл худалдан авах нөхцөлтэй гэрээтэй үед дахин үнэлгээ хийсэн өдрөөрх хорогдуулалтын түвшинг ашиглан хорогдуулсан түрээсийн төлбөрөөр хэмжигдэх түрээсийн өр төлбөрийг дахин үнэлж өөрчлөлт орсон;
- Анх ашигласан хорогдуулалтын түвшинг ашиглан хорогдуулсан түрээсийн төлбөрөөр хэмжигдэх түрээсийн өр төлбөрийг тодорхойлох үед гарсан түрээсийн зах зээлийн түвшин өөрчлөгдсөнөөр түрээсийн төлбөр өөрчлөгдсөн.

Түрээсийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд тусад нь толилуулж, холбогдох тодруулгыг мөн тусад нь харуулна.

*Түрээсийн гэрээний өөрчлөлт*

Групп нь дараах тохиолдолд түрээсийн өөрчлөлтийг тусдаа түрээсээр бүртгэнэ:

- өөрчлөлт нь нэмэлтээр нэг болон түүнээс дээш тодорхой хөрөнгө ашиглах эрх үүсгэж, түрээсийн зүйлийг нэмэгдүүлсэн; ба
- түрээсийн үзүүлэлтүүд нь түрээсийн гэрээ тус бүр дээр тусгайлан заасан нөхцөл үүссэн үед түрээсийн зүйлийг нэмэгдүүлэхэд хэмжигдэхүйц нэг бүрийн үнээр өссөн.

Групп нь тусдаа түрээсээр бүртгэгдэхгүй түрээсийн өөрчлөлтийн хувьд өөрчлөгдсөн түрээсийн гэрээний хугацааг харгалзан өөрчлөлт орсон өдрөөрх шинэчлэгдсэн хорогдуулалтын түвшинг ашиглан шинэчлэгдсэн түрээсийн төлбөрийг хорогдуулан тооцсон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.







**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.13 Түрээс (үргэлжлэл)

### 2.13.2 Түрээслэгч - Групп (үргэлжлэл)

*Түрээсийн гэрээний өөрчлөлт (үргэлжлэл)*

Групп нь түрээсийн өр төлбөр шинэчлэгдсэн тохиолдолд ашиглах эрхтэй хөрөнгийн дүнг тохируулж бүртгэнэ. Өөрчлөгдсөн түрээсийн гэрээнд түрээсийн зүйл ба нэмэлтээр нэг эсвэл түүнээс дээш түрээс эсвэл түрээсийн бус зүйл агуулсан гэрээний хувьд түрээсийн зүйлийн гэрээ нэг бүрийн төлбөрийг түрээсийн зүйлийн холбогдох нэг бүрийн үнэ ба түрээсийн бус зүйлийн нэг бүрийн үнийн нийлбэр дээр суурилан хуваарилна.

Үйл ажиллагааны түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан зардлаар бүртгэдэг. Үйл ажиллагааны түрээстэй холбоотой болзошгүй төлбөрийг тэдгээрийг гарсан жилд зардлаар бүртгэдэг. Үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу урамшуулал авсан бол түүнийг өр төлбөр гэж бүртгэдэг ба түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан түрээсийн өглөгийг бууруулж, зардлаар бүртгэдэг.

### 2.13.3 Түрээслүүлэгч - Групп

Түрээсийн гэрээгээр ихэнх эрсдэл ба өгөөжийг түрээслэгчид шилжүүлж байгаа бол түрээсийг санхүүгийн түрээсээр ангилна. Дээрхээс бусад бүх түрээс нь үйл ажиллагааны түрээсээр ангилагдана.

Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан бүртгэдэг. Түрээсийн гэрээ байгуулах үед гарсан нэмэлт зардлуудыг түрээсийн хөрөнгө оруулалт дээр нэмж бүртгэж, түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулдаг.

### 2.14 Гадаад валютын ажил гүйлгээ

Группийн бие даасан компани бүрийн хувьд санхүүгийн тайланг бэлтгэхдээ тухайн компанийн бүртгэлийн валютаас бусад валютыг (гадаад валют) ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэсэн.

Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүд нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөр нь тухайн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрүүдийн гүйлгээ хийгдсэн өдрөөс хойших ханшийн өөрчлөлтөөс үүсэн гарах өөрчлөлтийг гарсан цаг хугацаанд нь ашиг, алдагдлаар бүртгэнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө ба өр төлбөр нь тухайн гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлэгддэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотойгоор, Группийн гадаад үйл ажиллагааны хөрөнгө болон өр төлбөрийг тайлант хугацаа бүрийн эцсийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг. Тайлант хугацааны турш дахь орлого болон зардлын зүйлсийг хөрвүүлэхдээ тухайн тайлант хугацааны дундаж ханшийг ашиглан хөрвүүлдэг ба тухайн тайлант хугацаанд ханшийн хэлбэлзэл өндөр байх тохиолдолд ажил гүйлгээ үүссэн өдрийн ханшийг ашиглан хөрвүүлдэг.

Ханшийн зөрүүнээс үүссэн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусган эздийн өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэнэ.

### 2.15 Зардал хүлээн зөвшөөрөлт

Зардлыг нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.15 Зардал хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Группийн үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт ба маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

### 2.16 Зээлийн өртөг

Групп бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил, эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн зардлыг тухайн хөрөнгийн өртгийн хэсэг гэж капиталжуулдаг. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрдөг. Бэлтгэл шаардагдах хөрөнгө гэдэг нь зориулалтын дагуу ашиглах эсвэл борлуулахад зориулж бэлтгэхэд үлэмж хэмжээний цаг хугацаа зайлшгүй шаарддаг хөрөнгө юм.

Бэлтгэл шаардагдах хөрөнгийг олж бэлтгэх зориулалтаар тусгайлан авсан зээлийн санхүүжилттэй холбогдуулан Групп тухайн хөрөнгийн дүнд капиталжуулах боломжтой зээлийн өртгийн дүнг тайлант үеийн туршид гарсан зээлийн бодит зардлаас тухайн зээлийн түр зуурын хөрөнгө оруулалтаас олсон аливаа орлогыг хасч тодорхойлно. Групп бусад зээлийн өртгийг нэн даруй зардал гэж хүлээн зөвшөөрнө. Групп ерөнхий зориулалтаар авсан бөгөөд бэлтгэл ажил шаардагдах хөрөнгийг олж бэлтгэх зориулалтаар ашиглаж байгаа зээлийн санхүүжилтийн хүрээнд, капиталжуулах боломжтой зээлийн өртгийн дүнг тухайн хөрөнгийн зарлагын капиталжуулалтын түвшинг ашиглаж тодорхойлох ёстой. Капиталжуулалтын түвшин нь бэлтгэл шаардагдах хөрөнгөд зориулж Группийн тусгайлан авсан зээлээс бусад тайлант үеийн туршид төлөгдөөгүй зээлд тохирох зээлийн өртгийн жинлэсэн дундаж болно. Тайлант үед капиталжуулсан зээлийн өртгийн дүн нь тухайн тайлант үед гарсан зээлийн өртгийн дүнгээс хэтрэх ёсгүй.

### 2.17 Ажилчдын тэтгэмж

Групп нь тайлант хугацаанд ажилчдад олгох цалингийн зардлаас төлсөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр өрийг бүртгэдэг. Түүнчлэн, Групп нь ойрын хугацаанд мөнгөн шагнал олгох, ашиг хуваарилах хөтөлбөрийн хүрээнд төлөх дүнгээр өр бүртгэдэг. Ингэхдээ Групп нь ажилчдынхаа үзүүлсэн үйлчилгээний үр дүнд ийнхүү төлөхөөр хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хүлээсэн бөгөөд холбогдох өрийн дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой бол өрийн санг бүртгэдэг.

Богино хугацаат тэтгэвэр, тэтгэмжийг ажилчид үйлчилгээ үзүүлсэн үед дискаунтлаагүй сууриар хэмжиж, зардлаар хүлээн зөвшөөрдөг.

### 2.18 Нөөц

Групп өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон бөгөөд үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

Нөөцийн хамгийн бодит тооцооллыг хийхийн тулд үйл явдал, нөхцөл байдлын хүрээлэн байгаа эрсдэл, тодорхойгүй байдал зэргийг харгалзаж үзэх ёстой. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөөтэй бол нөөцийн дүн нь ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ байдаг.

Нөөцийн төлбөрийг барагдуулахад шаардагдах зарлагыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь өөр нэг талаас нөхөн авахаар хүлээгдэж байгаа үед, хэрэв Групп үүрэг хариуцлагынхаа дагуу төлбөрийг барагдуулсан үед нөхөн олговор хүлээн авах нь тодорхой байх нөхцөлд л зөвхөн нөхөн олговрыг хүлээн зөвшөөрөх ёстой. Нөхөн олговрыг тусад нь хөрөнгө гэж үздэг.

Нөөцийн дүнг тайлангийн хугацааны эцэст давтан шалгаж, тайлангийн үеийн хамгийн бодит тооцооллыг тусгахын тулд тохируулж байдаг. Хэрэв үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад шаардагдах эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн гадагшлах урсгал нь магадлал багатай бол нөөцийн дүнг буцаадаг.

Нөөцийг зөвхөн анх нөөц гэж хүлээн зөвшөөрсөн зарлагад ашиглана.





Говь ХК | Жилийн тайлан 2021

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.19 Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө

Аж ахуйн нэгжийн бүрэн хяналтаас гадуурх нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгийг бүртгэдэггүй. Эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийн гадагш урсгал гарах магадлал маш бага биш л бол бүх тохиолдолд болзошгүй өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн тайланд нэмж тодруулна.

### 2.20 Холбоотой тал

Групп болон Группийн толгой компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд эдийн засгийн нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд Групптэй холбоотой гэж үзнэ:

- Группийг хянадаг эсвэл хамтран хянадаг; эсвэл
- Группд мэдэгдэхүйц нөлөөлөлтэй; эсвэл
- Группийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Дараах нөхцөлүүдийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг Групптэй холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон компани нь нэг Группийн бүрэлдэхүүнд багтаж байвал;
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хяналттай компани бол (эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан Группийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтын хяналттай компани бол);
- Хоёр аж ахуйн нэгж хоёулаа гуравдагч талын хамтын хяналттай компани бол;
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч талын хамтын хяналттай компани ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч талын хараат компани бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь Групп эсвэл түүнтэй холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжинд зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө бол;
- (i)-д тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид хяналт тавьдаг эсвэл хамтран хянадаг бол;
- (i)-д тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй эсвэл уг аж ахуйн нэгж (эсвэл түүний толгой компани)-ийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.
- Групп болон Группийн толгой компанид үндсэн менежментийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага болон Группийн гишүүн аж ахуйн нэгж.

### 2.21 Татвар

Орлогын албан татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвар ба хойшлогдсон татварын нийлбэрээс бүрдэнэ.

#### 2.21.1 Тухайн жилийн орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тохируулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм. Татвар ногдох ашгийг тооцохдоо ирээдүйн тайлант үеийн татвар ногдох ашиг (татварын алдагдал)-ийг тодорхойлоход хэрэглэгдэх татвар ногдох орлого эсвэл татвараас хасагдах зардлаар тооцогдох түр зөрүү, мөн нягтлан бодох бүртгэлийн ашгийн татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардал зэргийг харгалзан үздэггүй учраас татвар ногдох ашиг нь нягтлан бодох бүртгэлийн ашгаас ялгаатай байдаг.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

### 2.21 Татвар (үргэлжлэл)

#### 2.21.2 Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүнд үндэслэн тооцдог. Бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүнд тооцдог боловч ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх өндөр магадлалтай эсэхийг харгалздаг. Эдгээр хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг гүүдвилл болон татвар ногдуулах орлого ба санхүүгийн ашигийн аль алинд нь нөлөөлдөггүй ажил гүйлгээ (бизнесийн нэгдлээс бусад)-ний үед бусад хөрөнгө ба өр төлбөрийг анх бүртгэхэд үүссэн түр зөрүүгээр бүртгэдэггүй.

Групп түр зөрүүг өөрчлөх хугацаанд хяналт тавих боломжтой байх, мөн түр зөрүү нь ойрын ирээдүйн тайлант үед өөрчлөгдөхгүй гэсэн магадлалтай байхаас бусад тохиолдолд охин, салбар болон хараат компани дахь хөрөнгө оруулалт болон хамтарсан компани дахь хувь оролцоотой холбоотой татвар ногдох бүх түр зөрүүний хувьд хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх ёстой. Түр зөрүүг ойрын ирээдүйн тайлант үед өөрчлөх магадлалтай бөгөөд татвар ногдох ашиг нь түр зөрүүгийн эсрэг ашиглагдахуйц үед охин эсвэл хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас үүсэх бүхий л татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүг Групп хойшлогдсон татварын хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөг.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст дахин хянаж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг хүргэх хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлал үгүй болох үед хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон, эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хэмждэг. Тайлант үеийн эцэст Групп нь хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах арга хэлбэрээс үүсэж байгаа татварын үр нөлөөг хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн хэмжилтэнд тусгадаг.

Тайлант үеийн татварын өр төлбөрийг тайлант үеийн татварын хөрөнгөөр суутган тооцох хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй, орлогын татвараар тооцоо хийдэг ижил татварын албатай харьцдаг ба тайлант үеийн татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр сууриар барагдуулахаар төлөвлөсөн тохиолдолд хойшлогдсон татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр дүнгээр тооцдог.

## 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн үнэлэмж ба тооцооллын тодорхой бус байдлын эх сурвалж

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд  хийсэн өөрчлөлтийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд тус тус тусгадаг.





Говь ХК | Жилийн тайлан 2021

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн үнэлэмж ба тооцооллын тодорхой бус байдлын эх сурвалж (үргэлжлэл)

### 3.1 Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж

#### 3.1.1 Газрын эзэмших эрхийн ашиглалтын жил ба элэгдэл

Групп нь Монгол Улсад орших газрыг 15-аас 60 жилээр түрээсэлдэг. Монгол Улсын Газрын тухай хууль нь Монгол Улсын аж ахуйн нэгжүүдэд газрын эрх эзэмших эрх зүйн үндсийг тогтоосон.

Групп газрыг гэрээний дагуу олж эзэмшсэн бодит үнэ цэнээр нь анх бүртгэлд тусгадаг. Групп өнгөрсөн жилүүдэд газар эзэмших эрхийн хугацааг маш бага хэмжээний жил тутмын төлбөр төлж амжилттай сунгуулсан. Группийн удирдлага газар эзэмших эрхийн хугацааг бага хэмжээний төлбөр төлж, цаашид тодорхойгүй хугацаагаар эзэмшинэ гэдэгт итгэлтэй байна. Тиймээс нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд 17,959,888 мянган төгрөгийн (2020 онд 17,959,888 мянган төгрөг) дансны үнэ бүхий газар нь үнэ цэнийн бууралтыг хассан, дахин үнэлсэн дүнгээр илэрхийлэгдсэн бөгөөд газрыг элэгдүүлдэггүй.

#### 3.1.2 Монгол Улсын татварын систем

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд, бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Групп татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Группд татварын эрсдэл байсаар байна.

#### 3.1.3 Хувьсах дүнг тооцоолох болон хязгаарлалтыг үнэлэх аргыг тодорхойлох нь

Бараа бүтээгдэхүүн борлуулах зарим гэрээнүүдэд буцаах нөхцөл бүхий хувьсах хүчин зүйлийг агуулсан байдаг. Групп нь буцаан олгоно гэж таамаглаж буй дүнг тооцоход хүлээгдэж буй үнэ цэнийн арга болон хамгийн боломжит дүнгийн аргын аль тохирох аргыг ашиглан тооцоолдог.

Групп нь адил төстэй олон тооны хэрэглэгчийн гэрээнүүдийн хувьд буцаагдах эрх бүхий бараануудын хувьсах төлбөрийг тооцоолоход хүлээгдэж буй үнэ цэнийн арга нь тохиромжтой арга гэж үзсэн.

Гүйлгээний үнэ дэх хувьсах хэмжигдэхүүнийг оруулахын өмнө Групп нь хувьсах төлбөрийн дүн хязгаарлагдаж байгаа эсэхийг авч үздэг. Групп нь хувьсах зардлын тооцооллыг Группийн түүхэн туршлага, бизнесийн таамаглал, одоогийн эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан хязгаарлагдаагүй гэж тодорхойлсон. Үүнээс гадна хувьсах төлбөрийн тодорхойгүй байдлыг богино хугацаанд шийдвэрлэдэг.

2021 онд борлуулалтын орлого нь 1,113,597 мянган төгрөгийн буцаалт, хөнгөлөлтийг хассаны дараа 144,344,329 мянган төгрөг (2020 онд борлуулалтын орлого нь 4,525,919 мянган төгрөгийн буцаалт, хөнгөлөлтийг хассаны дараа 117,092,505 мянган төгрөг) байсан.

### 3.2 Тооцооллын тодорхой бус байдлын эх сурвалж

Нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн нөлөөлөл бүхий дүн үзүүлэлтүүдэд дараах гол таамаглал төсөөллийг тайлант жилийн эцсийн тооцоололд ашигласан.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн үнэлэмж ба тооцооллын тодорхой бус байдлын эх сурвалж (үргэлжлэл)

### 3.2 Тооцооллын тодорхой бус байдлын эх сурвалж (үргэлжлэл)

#### 3.2.1 Алдагдлын нөөц сангийн тооцоолол

Групп дансны авлагын хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо тусгайлсан үнэлгээний аргаар ашигласнаас бусад авлагад нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдалд тулгуурласан матрицын аргыг ашигласан. Зээлдэгчдийг ижил төстэй алдагдлын хандлагаар бүлэглэсэн дотоод зээл ба авлагын зэрэглэлд суурилан хасагдуулгын хувийг тодорхойлдог. Нөөц сан тооцоолох матрицын арга нь Группийн түүхэн дефолтын түвшинд суурилдаг бөгөөд хэт их зардал болон өндөр хүчин чармайлт, өртөг шаардахааргүйгээр олж авах боломжтой ирээдүйг таамаглаж буй мэдээллүүдийг мөн харгалзан үздэг. Тайлант үе бүрийн эцэст ажиглагдах түүхэн дефолтын түвшинг дахин үнэлэх ба ингэхдээ ирээдүйг таамаглаж буй мэдээлэлд гарсан өөрчлөлтүүдийг авч үзнэ.

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Группийн дансны ба бусад авлагын дансны үнэ нь 2,258,129 мянган төгрөг, авлагын нөөц сангийн үлдэгдэл 1,843,519 мянган төгрөг (2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар: дансны ба бусад авлагын дансны үнэ нь 5,996,260 мянган төгрөг, авлагын нөөц сангийн үлдэгдэл 1,891,013 мянган төгрөг) байсан.

#### 3.2.2 Бараа материалын үнэ цэнийн бууралтын хасагдуулгын нөөц

Группийн удирдлага удаан гүйлгээтэй, зарагддаггүй болон эвдэрч гэмтсэн бараа материалыг тодорхой хугацаагаар хянадаг ба үнэлэмж болон тооцооллыг ашигладаг. Тооцоолол болон холбогдох төсөөллүүд нь түүхэн туршлага дээр үндэслэдэг ба бодит үр дүн нь тооцооллоос зөрүүтэй байж болно.

Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлого нь бараа материалыг үйлдвэрлэж дуусгаснаас хойш борлуулаагүй бол хугацаа, насжилт болон бараа материалын зэрэглэлээс хамаарч ангиллын дагуу хасагдуулга байгуулна.

Удирдлага дээрх бараа материалын үнэлгээг тодорхойлоход хэрэглэсэн төсөөлөл болон үнэлэмж зохистой буюу тохиромжтой гэдэгт итгэж байна.

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бараа материалын дансны үнэ нь 138,030,372 мянган төгрөг, бараа материалын хасагдуулгын нөөцийн үлдэгдэл нь 1,791,496 мянган төгрөг (2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бараа материалын дансны үнэ нь 193,207,689 мянган төгрөг (646,063 мянган төгрөгийн буцаах эрхтэй барааг оруулахгүйгээр), бараа материалын хасагдуулгын нөөцийн үлдэгдэл 1,766,807 мянган төгрөг) байсан.

#### 3.2.3 Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил

Тодруулга 2.6-д тайлбарласнаар, Групп үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцооллыг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдрөөр хянадаг ба ашиглалтын хэлбэр, хөрөнгийн насжилт болон технологийн дэвшлийг харгалзаж үзээд тооцооллыг өөрчлөх шаардлагатай бол залруулдаг. Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцоололд өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоолоход үнэлэмж ашигладаг ба уг тооцоолол нь тайлант жилийн цэвэр ашигт нөлөө үзүүлэх боломжтой.

Удирдлага дээрх тооцоолсон үндсэн хөрөнгийн ашиглалтын жил уг хөрөнгийн бодитой эдийн засгийн ашиглах жил гэдэгт итгэж байна.







**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн үнэлэмж ба тооцооллын тодорхой бус байдлын эх сурвалж (үргэлжлэл)

### 3.2 Тооцооллын тодорхой бус байдлын эх сурвалж (үргэлжлэл)

#### 3.2.4 Барилга ба газрын бодит үнэ цэнийн хэмжилт

Газар болон барилга нь санхүүгийн тайлагналын зорилгоор бодит үнэ цэнээр хэмжигддэг. Дахин үнэлгээг хөрөнгийн дансны үнэ нь тайлант жилийн эцэст бодит үнэ цэнийг ашиглан тодорхойлсноос нөлөөлөхүйц зөрүүгүй байхаар хангалттай давтамжтай хийдэг. Групп хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо ажиглаж болох зах зээлийн үнийн мэдээллийг ашигладаг. Идэвхтэй зах зээлийн үнэ цэнийн мэдээлэл (1-р түвшин) тодорхойгүй бол Групп хараат бус мэргэжлийн үнэлгээчнээр хөрөнгийн үнэлгээг тооцоолуулдаг. Эдгээр тооцооллоос хамаарч газар болон барилгын үнэлгээ өөрчлөгдөх боломжтой.

Барилга болон газрын бодит үнэ цэнийг тооцоолоход ашигласан мэдээлэл болон үнэлгээний аргачлалын талаар Тодруулга 10.2-оос харна уу.

## 4. Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)

### 4.1 Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэчлэгдсэн СТОУС болон шинэ тайлбарууд

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2021 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн СТОУС-ын өөрчлөлтүүдийг тайлант жилд хэрэгжүүлсэн.

| Хэрэгжиж эхэлсэн хугацаа | Шинэчлэгдсэн СТОУС болон өөрчлөлтүүд |
|---|---|
| 2021 оны 01 сарын 01 | • СТОУС 9, НББОУС 39, СТОУС 4, СТОУС 16, ба СТОУС 7 Жишиг зээлийн хүүгийн шинэчлэл - 2-р үе шат |
| 2021 оны 4 сарын 01 | • СТОУС 16 КОВИД-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт нэмэлт өөрчлөлтийн хугацааны сунгалт |

Дээр дурдсанаас бусад шинэчлэгдсэн СТОУС болон нэмэлт өөрчлөлтүүд нь Группийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгуудад материаллаг нөлөө үзүүлээгүй.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 4. Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС) (үргэлжлэл)

### 4.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй шинэчлэгдсэн СТОУС болон нэмэлт өөрчлөлтүүд

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг батлан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбаруудыг дор тодруулсан болно. Эдгээр стандартууд болон өөрчлөлтүүд нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхээр бол Групп эдгээрийг хэрэгжиж эхэлсэн үеэс дагаж мөрдөнө.

| Хэрэгжих хугацаа | Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд |
|---|---|
| 2022 оны 01 сарын 01 | • СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлт Үзэл баримтлалын тайлбар<br>• НББОУС 16-ын нэмэлт өөрчлөлт Үндсэн хөрөнгө: Ашиглахаас өмнө хөрөнгийн орлого<br>• НББОУС 37-ын нэмэлт өөрчлөлт Алдагдалтай гэрээ - Гэрээний биелэлтийн өртөг<br>• 2018-2020 оны СТОУС-ын жилийн сайжруулалтын өөрчлөлтүүд |
| 2023 оны 01 сарын 01 | • СТОУС 17 Даатгалын гэрээ<br>• НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт Эргэлтийн ба Эргэлтийн бус өр төлбөрийн ангилал (2024 оны 01 сарын 01 болгож хойшлуулах санал хэлэлцэгдэж байгаа)<br>• НББОУС 1 ба СТОУС-ийн практик мэдэгдлийн 2-т оруулсан нэмэлт өөрчлөлтүүд - Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулах нь<br>• НББОУС 12-ийн нэмэлт өөрчлөлт – Дан ганц ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөрт хамаарах хойшлогдсон татвар<br>• НББОУС 8-ийн нэмэлт өөрчлөлт - Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт |





**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Касс дахь бэлэн мөнгө | 12,258 | 11,863 |
| Банк дахь харилцах данс | 4,377,221 | 12,786,882 |
| | **4,389,479** | **12,798,745** |

## 6. Дансны ба бусад авлага

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Дансны авлага | 2,289,402 | 4,223,335 |
| Үнэ цэнийн бууралтын сан | (1,698,935) | (1,745,641) |
| | **590,467** | **2,477,694** |
| Холбоотой талаас авах авлага (Тодруулга 29.1-ийг үзнэ үү) | 30,222 | 215,053 |
| Бусад авлага | 1,782,024 | 3,448,885 |
| Үнэ цэнийн бууралтын сан | (144,584) | (145,372) |
| | **2,258,129** | **5,996,260** |

### 6.1 Дансны авлага

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын дансны үлдэгдэл дараах байдалтай байна:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Холбоотой талаас авах авлага (Тодруулга 6) | 30,222 | 215,053 |
| Холбоотой талд өгөх өглөг /Богино хугацаат/ (Тодруулга 14) | 185,933 | 12,477,541 |
| Холбоотой талд өгөх өглөг /Урт хугацаат/ (Тодруулга 18) | 25,622,107 | 14,230,453 |

Холбоотой талд өгөх урт хугацаат өглөг нь 2020 оны 8 дугаар сард Таван Богд Трейд ХХК-аас Гоёо ХХК-ийн хувьцааг зээлээр худалдан авсантай холбоотой. Худалдан авалтын гэрээнд 2020 оны 10 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд төлбөр төлж барагдуулах хугацааг 2024 оны 5 дугаар сар болгон өөрчилсөн. Тус гэрээнд аливаа хөрөнгийг барьцаалаагүй байна.

### 29.2 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Дараах ажил гүйлгээг Группийн толгой компани болох Таван Богд Трейд ХХК-тай хийсэн байна:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Толгой компаниас авсан санхүүжилт (Тодруулга 17.2) | - | 12,459,400 |
| Толгой компаниас авсан санхүүжилтээс төлсөн дүн (Тодруулга 17.2) | - | 12,459,400 |
| Толгой компаниас авсан худалдан авалт | 1,256,062 | 1,463,505 |
| Толгой компанид хийсэн борлуулалт | 39,134 | 4,392 |
| Толгой компанид төлсөн хүүгийн зардал | 2,032,887 | 2,418,383 |

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**29. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ (үргэлжлэл)**

Дараах ажил гүйлгээг Группийн нэгдсэн хяналтад байдаг бусад холбоотой талуудтай хийсэн байна:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Холбоотой талаас авсан санхүүжилт (Тодруулга 17.2) | 41,483,084 | - |
| Холбоотой талаас авсан санхүүжилтээс төлсөн дүн (Тодруулга 17.2) | 41,483,084 | - |
| Холбоотой талаас авсан худалдан авалт | 454,406 | 645,589 |
| Холбоотой талд хийсэн борлуулалт | 343,699 | 341,646 |
| Холбоотой талд төлсөн хүүгийн зардал | 272,418 | - |

Дараах ажил гүйлгээг толгой компанийн хараат компани болох Хаан Банктай хийсэн байна:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Хаан Банкнаас авсан санхүүжилт (Тодруулга 17.2) | 39,237,105 | 69,270,000 |
| Хаан Банкнаас авсан санхүүжилтээс төлсөн дүн (Тодруулга 17.2) | 47,237,105 | 89,000,000 |
| Хаан Банкинд хийсэн борлуулалт | 1,115,012 | 10,500 |
| Хаан Банкинд төлсөн хүүгийн зардал | 207,648 | 3,308,145 |

Бүх холбоотой талын гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцөлөөр хийгдсэн.

**29.3 Үндсэн удирдлагын цалин, урамшуулал**

Группийн удирдлага болон удирдлагын багийн гишүүдийн үндсэн болон нэмэгдэл цалин дараах байдалтай байна:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Үндсэн удирдлагын нийт цалин, урамшуулал | 1,546,153 | 1,323,099 |

**30. Болзошгүй өр төлбөр ба санхүүгийн үүрэг**

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд Групп нь аливаа санхүүгийн үүрэг болон болзошгүй өр төлбөр хүлээж болно. 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар (2020 онд байхгүй) Групп-д ямар нэг болзошгүй өр төлбөр, санхүүгийн үүрэг үүсээгүй бөгөөд үүсвэл дараах байдлаар үүснэ.

**30.1 Болзошгүй өр төлбөр**

Баталгаа нь тодорхой нөхцөлд холбоотой талын өмнөөс голдуу тендерийн үйл ажиллагаатай холбоотойгоор төлбөр хийх үүргийг Группд ногдуулж үүснэ. Баталгаа нь болзошгүй өр төлбөр боловч зээлийн эрсдэлтэй ижил эрсдэлийг агуулдаг. Эдгээр гүйлгээний улмаас нөлөө бүхий алдагдал гарахгүй гэсэн хүлээлттэй байна.

**30.2 Санхүүгийн үүрэг**

Санхүүгийн үүрэг гэдэг нь Группийн зүгээс зээл олгох, зээлийн шугам нээх гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм үүргүүд нь тогтсон дуусах хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл аваагүй байтал зээлийн гэрээний хугацаа дуусах магадлалтай тул гэрээнд заагдсан мөнгөн дүн нь ирээдүйн зээлийн мөнгөн урсгалыг илэрхийлэхгүй юм. Эдгээр гүйлгээний улмаас нөлөө бүхий алдагдал гарахгүй гэсэн хүлээлттэй байна.

**30.3 Шүүхийн нэхэмжлэл**

Группийн бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад хэрэг маргааныг шүүхээр шийдвэрлүүлдэг ба шүүхийн нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах талаар тогтсон дотоод журам, туршлагатай. Групп нь аливаа нэхэмжлэлийн өөрийн санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс хамгаалахдаа мэргэжлийн хууль зүйн туслалцаа авах нь эрсдэлийг бууруулдаг гэж үздэг. Тайлант жилийн эцэст Группд нөлөө бүхий үүрэг хүлээх шүүхийн нэхэмжлэл байхгүй байна.







**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**31. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдэлийн удирдлага**

(1) Оршил

Группийн үйл ажиллагааны уялдаатай гол эрсдэлүүд бол зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, зах зээлийн эрсдэл үүнд: хүүгийн түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл байдаг.

Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь эрсдэл/өгөөжийн профайлтай уялдуулан бизнесийн сегментүүдэд хөрөнгө хуваарилах, тодорхойлох, хэмжих, хянах үйл явцаар Группийн эрсдэлд тохируулсан хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх явдал юм. Эрсдэлийн удирдлагын энэхүү үйл явц нь Группийн тасралтгүй ашигт ажиллагаанд чухал ач холбогдолтой бөгөөд Групп доторх хүн бүр өөрийн үүрэг хариуцлагатай холбоотой эрсдэлийг удирддаг.

Группийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь эрсдэлийг арилгах зорилготой бус харин эрсдэл ба өгөөжийн харьцааг оновчтой байлгах зорилготой тодорхойлогдсон бөгөөд Группийн ерөнхий үзэл баримтлал, үнэ цэнэд нийцтэй удирдлагын тогтолцоог хадгалах, амжилттай хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, тасралтгүй сайжруулахад оршино. Энэхүү Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-өөс дэмжигдэж батлагдсан “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ын тогтолцоо нь дараах цар хүрээг багтаана. Үүнд:

- Эрсдэлд өртөх хэм хэмжээ;
- Эрсдэлийн арга хэмжээний хэмжүүр нь ТУЗ-өөс баталсан бизнесийн стратегид нийцсэн байх;
- Хөрөнгийн хуваарилалт нь эрсдэлд өртөх хэм хэмжээтэй нийцэх;
- Группийн гүйцэтгэлийн зорилтууд нь эрсдэл хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ болон тэсвэрт байдалтай уялдуулан нийцсэн байх;
- Эрсдэлийн удирдлагад стратегийн эрсдэл, нийцлийн эрсдэл, санхүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, давагдашгүй хүчин зүйлийн эрсдэл болон бусад цаг үеийн шинж чанартай тулгарах эрсдэлүүдийг багтаадаг.

**Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт**

ТУЗ-ийн зүгээс хамтын хяналт, эрсдэлийн засаглалын хариуцлагыг тодорхой хэрэгжүүлэх нь үндсэн зорилтуудын нэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. ТУЗ-өөс эрсдэлийн засаглалд “Гурван давхар хамгаалалтын шугам” загварыг баталж, гүйцэтгэх удирдлага нь хамгаалалтын нэгдүгээр эгнээнд, эрсдэлийн удирдлагын хороо, эрсдэлийн ахлах ажилтан нь хамгаалалтын хоёрдугаар эгнээнд, дотоод аудит нь гуравдугаар эгнээнд байна.

**ТУЗ-ийн Эрсдэл ба Аудитын хороо**

ТУЗ-ийн Эрсдэл ба Аудитын Хороо нь дотоод хяналт ба зохицуулалт болон хууль, эрх зүйн шаардлагыг хэрэгжүүлж байгаа эсэхийг ТУЗ-д танилцуулж ТУЗ-ийн дор ажиллах үүрэгтэй.

**Дотоод аудит**

Группийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Дотоод аудит нь Эрсдэл ба Аудитын хорооноос өгсөн үүрэг чиглэлийн дагуу ажилладаг. Группийн хэмжээнд нэвтрүүлэн хэрэгжүүлж буй бодлого дүрэм, журмуудын зохистой байдал хийгээд Групп эдгээрийг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавин үр дүнг ТУЗ-д тайлагнадаг.

**Эрсдэлийг бууруулах**

Групп нь ТУЗ-өөс тогтоосон эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэл хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний дагуу улирал бүр хянах байдлаар эрсдэлийг удирддаг. Эдгээр хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг Группийн бизнесийн стратеги, зах зээлийн нөхцөл байдал болон үйл ажиллагаандаа уялдуулан тогтоосон байдаг.

Хүүгийн түвшний эрсдэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй эрсдэлийн хэмжээг мэдрэмжийн шинжилгээ хийн хянаж ажилладаг. Эрсдэлийг бууруулах зорилгоор тодорхой арга хэмжээг авдаг бөгөөд доор дэлгэрэнгүй тодруулав.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**31. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

(1) Оршил (үргэлжлэл)

**Эрсдэлийн хэт төвлөрөл**

Төвлөрөл нь ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, эсвэл нэгэн ижил газар зүйн бүсэд болон эдийн засгийн ойролцоо шинж чанартай бизнес эрхэлдэг хэд хэдэн харилцагчид улс төр, эдийн засаг болон бусад аливаа өөрчлөлт гарахад тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэхэд ижил маягаар нөлөөлөхөөр байвал үүсдэг. Төвлөрөл нь тухайн нэгж салбарт болон газар зүйн байрлалд нөлөөлж буй нөхцөл байдалд Групп хэрхэн гүйцэтгэлээ хангах мэдрэмжийг илтгэнэ.

Эрсдэлийн хэт төвлөрлөөс зайлсхийх үүднээс Групп өөрийн бодлого, журамдаа олон төрлийн багцтай байх тодорхой удирдамжийг тусгасан байдаг. Тухайлбал, жижиглэнгийн борлуулалтыг цахим болон дэлгүүрийн, захиалгын гэх сувгаар салган хөгжүүлэх, олон улсын өөр бүс нутгуудад салбар дэлгүүр нээх эсвэл маркетингийн оновчтой бодлого боловсруулах зэргээр үйл ажиллагааны төвлөрлийг хянаж удирдаг.

**31.1 Зээлийн эрсдэлийн удирдлага**

Зээлийн эрсдэл гэдэг нь гэрээ байгуулагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс Группд санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл.

**Зээлийн эрсдэлд өртөх байдал**

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь зээлийн хамгийн их эрсдэлийг илэрхийлж байдаг. Группийн хамгийн их хүлээх зээлийн эрсдэлийг санхүүгийн хөрөнгө тус бүрийн дансны үнээр илэрхийлэв:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Банк дахь харилцах данс | 4,377,221 | 12,786,882 |
| Түрээсийн дэлгүүрт байршуулсан барьцаа | 557,284 | 523,829 |
| Дансны ба бусад авлага* | 1,324,752 | 3,081,189 |
| | **6,259,257** | **16,391,900** |

*2021 оны 933,377 мянган төгрөгийн, 2020 оны 2,915,071 мянган төгрөгийн татварын авлагын дүн дээрх дүнд ороогүй болно.

Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хасагдуулга дараах байдалтай байна:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын хасагдуулга | 110,920 | 170,306 |
| Банк дахь хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хасагдуулга | - | - |
| Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын хасагдуулгын буцаалт | (31,116) | (9,037) |
| | **79,804** | **161,269** |





Говь ХК | Жилийн тайлан 2021

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**31. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**31.1 Зээлийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**Зээлийн эрсдэлд өртөх байдал (үргэлжлэл)**

Тайлант өдрөөрх дансны болон бусад авлагын зээлийн эрсдэлд өртөх дээд хэмжээ (татвараас бусад) газар зүйн бүс нутгаар дараах байдалтай байна:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| Дотоод | 970,442 | 597,203 |
| Гадаад | 354,310 | 2,483,986 |
| | **1,324,752** | **3,081,189** |

Одоогийн байдлаар дотоодын зах зээл дээр зээлжих зэрэглэл тогтоох хараат бус үнэлгээний байгууллага байхгүй байна. Иймээс Группийн зүгээс удаан хугацаанд харилцсан, найдвартай харилцагчидтайгаа урьдчилан баталсан зээлийн дээд хэмжээний хүрээнд зээлээр борлуулалт хийх бодлогыг баримталдаг. Жил бүр борлуулалтын гэрээг харилцагчидтай байгуулж, шинэчлэн баталгаажуулж, гэрээний нөхцөлийн биелэлтэд байнгын хяналт тавьж ажилладаг.

Группийн дансны авлагыг даатгуулсан эсвэл аккредитив гэрээгээр баталгаажуулснаас бусдаар санхүүгийн хөрөнгөтэй холбоотой зээлийн эрсдэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй. 2021 онд даатгуулсан эсвэл аккредитив гэрээгээр баталгаажуулсан дансны авлага байхгүй (2020 онд 987,706 мянган төгрөг) байна. Группийн удирдлага нь өндөр зээлийн зэрэглэлтэй дотоодын банк болон санхүүгийн байгууллагуудад байршуулсан банкны харилцах дансанд харгалзах санхүүгийн зээлийн эрсдэлийн түвшинг бага гэж үзсэн. Группийн удирдлага дефолтын магадлал бага гэж үзсэн тул нөөц санг байгуулаагүй.

Группийн удирдлага дансны болон бусад авлагын эргэн төлөгдөх чадамжийн талаарх үнэлгээг авлага цуглуулалтын түүхэн мэдээлэл болон ирээдүйг таамаглаж буй мэдээллийг харгалзан багцалсан болон тусгайлсан шинжилгээ хийж үнэлдэг. Групп нь үнэ цэнэ буураагүй дансны болон бусад авлагын хүлээгдэж буй алдагдлыг авлагын хугацаа хэтэрсэн байдалд үндэслэн өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйн таамаглаж буй мэдээллийг харгалзан тохируулсан эрсдэлийн сангийн матрицыг ашиглан тодорхойлдог. Үүний дагуу эдгээр хөрөнгийн зээлийн эрсдэлийн профайлыг эрсдэлийн сангийн матрицын хувьд түүхэн төлөв байдалд үндэслэн гаргасан.

Зээлийн эрсдэлд өртөх байдал, дансны болон бусад авлагын хүлээгдэж буй зээлийн алдагдлын талаарх мэдээлэл дараах байдалтай байна:

| 2021 оны 12 сарын 31 | Нийт дансны үнэ | Хасагдуулгын нөөц | Зээлийн алдагдал |
|---|---|---|---|
| Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралт үүсээгүй | 1,293,857 | - | 0.00% |
| 0-30 хоног хугацаа хэтэрсэн | 22,245 | - | 0.00% |
| 31-60 хоног хугацаа хэтэрсэн | 2,712 | - | 0.00% |
| 61-90 хоног хугацаа хэтэрсэн | 76 | - | 0.00% |
| 91 хоногоос дээш хугацаа хэтэрсэн | 1,849,381 | (1,843,519) | 99.68% |
| | **3,168,271** | **(1,843,519)** | **58.19%** |

| 2020 оны 12 сарын 31 | Нийт дансны үнэ | Хасагдуулгын нөөц | Зээлийн алдагдал |
|---|---|---|---|
| Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралт үүсээгүй | 2,742,486 | - | 0.00% |
| 0-30 хоног хугацаа хэтэрсэн | - | - | 0.00% |
| 31-60 хоног хугацаа хэтэрсэн | 10,055 | - | 0.00% |
| 61-90 хоног хугацаа хэтэрсэн | 183,776 | - | 0.00% |
| 91 хоногоос дээш хугацаа хэтэрсэн | 2,035,885 | (1,891,013) | 92.88% |
| | **4,972,202** | **(1,891,013)** | **38.03%** |

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 31. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### 31.1 Зээлийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

*Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын нөөцийн хөдөлгөөн*

Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын нөөцийн хөдөлгөөн тайлант жилийн хугацаанд дараах байдалтай байна:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл | 1,891,013 | 1,730,355 |
| Авлагын алдагдлын хасагдуулга | 110,920 | 170,306 |
| Хасагдуулгын нөөцийн буцаалт | (31,116) | (9,037) |
| Данснаас хассан дүн | (127,298) | (611) |
| **12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **1,843,519** | **1,891,013** |

Дансны авлагын үнэ цэнийн бууралтын мэдээллийг Тодруулга 6-аас харна уу.

Группийн удирдлага нь бусад авлагын эргэн төлөгдөх магадлалыг үнэлэхдээ авлагын түүхэн мэдээлэл, хугацаа хэтэрсэн авлагын мэдээлэл, одоогийн болон ирээдүйг таамагласан мэдээллийг харгалзан тохируулах байдлаар багцалсан болон тусгайлсан үнэлгээг хийдэг. Группийн удирдлагын хийсэн үнэлгээгээр бусад авлагад анх бүртгэлд тусгаснаас хойш нөлөө бүхий зээлийн эрсдэл үүсээгүй гэж үнэлсэн ба эрсдэлийн түвшин нь өндөр бус учир үнэ цэнийн бууралт бүртгээгүй болно.

Дансны авлагын нөхцөл байдлыг үндэслэн зээлийн үнэлгээг тогтмол хийдэг ба шаардлагатай гэж үзвэл төлбөрийн эрсдэлийг даатгуулдаг. Мөн Групп худалдан авагчаас дараагийн захиалгыг гүйцэтгэхээс өмнө үлдэгдэл төлбөрөө төлсөн байхыг шаарддаг.

### 31.2 Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Групп өөрийн санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл юм. Групп нь хэвийн болон онцгой нөхцөлд их хэмжээний алдагдалд орохгүйгээр, Группийн нэр хүндэд хохирол учруулах эрсдэлийг бий болгохгүйгээр өр төлбөрөө гэрээний хугацаанд төлж барагдуулахад хүрэлцэхүйц хөрвөх чадварыг тогтмол хангаж байх ёстой гэдэг зарчмаар хөрвөх чадварыг удирдан зохицуулдаг.

Группийн ТУЗ хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хариуцдаг ба Группийн богино, дунд ба урт хугацааны санхүүжилт болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын шаардлагад нийцсэн хөрвөх чадварын бүтцийг бий болгох үүрэгтэй. Групп санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн төлөгдөх хугацаа, банкнаас зээл авах чадавх, зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, мөнгөн урсгалын таамаглал болон гүйцэтгэлд үндэслэн хөрвөх чадварын эрсдэлийг удирддаг.

Хүснэгтэд Группийн үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг гэрээгээр төлөх хугацаагаар нь ангилан тайлагнасан. Хүснэгтэн дэх мэдээлэл нь Группийн төлбөр төлөх шаардлагатай хамгийн эхний хугацаанд үндэслэсэн дисконтлоогүй мөнгөн гүйлгээг харуулж байна. Энэхүү хүснэгтийн дүнгүүд нь үндсэн төлбөр болон хүүг агуулсан болно.







**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 31. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### 31.2 Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

| 2021 оны 12 сарын 31 | Дуудахад эргэн төлөгдөх нөхцөлтэй болон 1 сараас бага | 1-3 сар | 3 сараас 1 жил хүртэл | 1-5 жил | Нийт | Дансны үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| Дансны болон бусад өглөг (урт хугацаат өглөг багтсан) * | 2,538,850 | 841,626 | 2,306,228 | 27,965,661 | 33,652,365 | 29,662,663 |
| Бондын өглөг | - | - | 10,900,000 | - | 10,900,000 | 9,877,213 |
| Богино болон урт хугацаат зээл | 12,962,824 | 15,594,978 | 93,156,100 | 127,348,350 | 249,062,252 | 226,058,669 |
| Богино болон урт хугацаат түрээсийн өглөг | 92,763 | 278,287 | 721,534 | 708,903 | 1,801,487 | 1,587,437 |
| | **15,594,437** | **16,714,891** | **107,083,862** | **156,022,914** | **295,416,104** | **267,185,982** |

| 2020 оны 12 сарын 31 | Дуудахад эргэн төлөгдөх нөхцөлтэй болон 1 сараас бага | 1-3 сар | 3 сараас 1 жил хүртэл | 1-5 жил | Нийт | Дансны үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| Дансны болон бусад өглөг (урт хугацаат өглөг багтсан) * | 2,070,357 | 3,734,856 | 15,918,331 | 15,415,328 | 37,138,872 | 34,830,878 |
| Бондын өглөг | - | - | - | - | - | - |
| Богино болон урт хугацаат зээл | 42,510,672 | 51,226,888 | 185,280,321 | 4,667,815 | 283,685,696 | 272,172,594 |
| Богино болон урт хугацаат түрээсийн өглөг | 116,757 | 350,274 | 919,390 | 2,157,727 | 3,544,148 | 2,902,049 |
| | **44,697,786** | **55,312,018** | **202,118,042** | **22,240,870** | **324,368,716** | **309,905,521** |

*2021 онд 2,065,186 мянган төгрөг, 2020 онд 2,058,370 мянган төгрөгийн татварын өглөг болон 2021 үлдэгдэлгүй, 2020 онд 1,010,634 маянган төгрөгийн буцаах эрхтэй барааны өр төлбөрийг оруулаагүй болно.

### 31.3 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт тухайлбал хүүгийн түвшин, гадаад валютын ханш өөрчлөгдсөнөөр Группийн ашиг эсвэл эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх эрсдэл юм. Групп нь зээлийн хүүгийн түвшний эрсдэл, гадаад валютын эрсдэл гэсэн хоёр зах зээлийн эрсдэлд анхаарлаа хандуулдаг. Эдгээр эрсдэлийн зорилго болон удирдлагыг доор авч үзнэ.

#### 31.3.1 Зээлийн хүүгийн түвшний эрсдэлийн удирдлага

Групп тогтмол болон хувьсах хүүтэй зээлүүдтэй учраас зээлийн хүүгийн эрсдэлтэй байна. Мөнгөн гүйлгээний хүүгийн түвшний эрсдэл нь хувьсах хүүтэй зээлээс үүссэн ба бодит үнэ цэнийн хүүгийн түвшний эрсдэл нь тогтмол хүүтэй зээлээс үүсдэг. Энэхүү эрсдэлийг Групп тогтмол болон хувьсах хүүтэй зээлийн зохистой байдлыг хангах замаар удирддаг. Зээлийн хүүгийн эрсдэлийг удирдахдаа хейджинг хэрэглүүрийг ашигладаггүй.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**31. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**31.3 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

**31.3.1 Зээлийн хүүгийн түвшний эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

Тайлант өдөр Группийн хүүтэй санхүүгийн хэрэглүүрийн хүүгийн профайл нь:

| | 2021 | 2020 |
|---|---|---|
| **Тогтмол хүүтэй хэрэглүүр** | | |
| Санхүүгийн хөрөнгө | - | - |
| Санхүүгийн өр төлбөр | (230,685,710) | (266,845,503) |
| **Хувьсах хүүтэй хэрэглүүр** | | |
| Санхүүгийн хөрөнгө | - | - |
| Санхүүгийн өр төлбөр | (31,284,393) | (36,886,369) |
| | **(261,970,103)** | **(303,731,872)** |

**Зээлийн хүүгийн мэдрэмжийн шинжилгээ**

Доор дурдсан мэдрэмжийн шинжилгээг тайлант хугацааны эцэст байгаа үүсмэл бус хэрэгслүүд дэх хүүгийн түвшний нөлөөллийг үндэслэн тодорхойлсон. Хувьсах хүүтэй өр төлбөрийн шинжилгээг бэлтгэхдээ тайлант хугацааны эцэс дэх төлөгдөөгүй өр төлбөрийг тайлант хугацааны жилийн турш төлөгдөөгүй гэж үзсэн. Гүйцэтгэх удирдлагын түвшинд хүүгийн түвшний эрсдэлийг үнэлэхдээ хүүгийн түвшний боломжит өөрчлөлтийг 50 пунктээр өсно/буурна гэж үзсэн.

Хэрэв бусад бүх хувьсах үзүүлэлт тогтмол байх үед хүүгийн түвшин 50 функтээр өсч/буурвал 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх татварын өмнөх ашиг 156,422 мянган төгрөг (2020 онд 169,422 мянган төгрөг)-өөр өснө/буурна. Энэ нь Группийн хувьсах хүүтэй өр төлбөрт хамааралтай.

Группийн удирдлага хүүгийн түвшингийн өөрчлөлт нь хадгаламжийн харилцах дансны хүүгийн орлогод өндөр нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзсэн учраас мэдрэмжийн шинжилгээ бэлтгээгүй болно.

**31.3.2 Гадаад валютын эрсдэлийн удирдлага**

Группд төгрөгөөс өөр гадаад валютаар үүссэн худалдан авалт болон өр төлбөртэй холбоотойгоор гадаад валютын ханшийн эрсдэл үүсдэг. Групп нь гадаад валютын эрсдэлийг гадаад валютын дериватив хэрэгслийг ашиглан хянадаггүй.

Группийн гадаад валютаар үүссэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг тайлангийн өдрийн байдлаар төгрөгөөр үзүүлбэл дараах байдалтай байна:

| 2021 оны 12 сарын 31 | Ам.доллар | Евро | Юань | Бусад |
|---|---|---|---|---|
| Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө | 758,401 | 2,477,973 | 629,992 | 121 |
| Дансны болон бусад авлага | 32,335 | 80,042 | 333,137 | 5,445 |
| Түрээсийн дэлгүүрт байршуулсан барьцаа | 56,976 | 305,748 | 53,622 | - |
| Дансны болон бусад өглөг | (1,023,891) | (732,018) | (66,505) | - |
| Бусад урт хугацаат өглөг | (25,622,107) | - | - | - |
| Богино болон урт хугацаат зээл | (41,093,152) | (97,285,103) | - | - |
| Түрээсийн өр төлбөр | (344,483) | (105,238) | - | - |
| | **(67,235,921)** | **(95,258,596)** | **950,246** | **5,566** |

53





**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**31. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**31.3 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

**31.3.2 Гадаад валютын эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

| 2020 оны 12 сарын 31 | Ам.доллар | Евро | Юань | Бусад |
|---|---|---|---|---|
| Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө | 2,728,560 | 9,000,364 | 950,694 | 80 |
| Дансны болон бусад авлага | 496,644 | 1,533,944 | 422,176 | - |
| Түрээсийн дэлгүүрт байршуулсан барьцаа | 56,990 | 326,899 | - | - |
| Дансны болон бусад өглөг | (16,006,808) | (684,343) | (130,203) | (3,105) |
| Бусад урт хугацаат өглөг | (14,955,172) | - | - | - |
| Богино болон урт хугацаат зээл | (35,769,005) | (105,505,456) | - | - |
| Түрээсийн өр төлбөр | (489,467) | (755,710) | - | - |
| | **(63,938,258)** | **(96,084,302)** | **1,242,667** | **(3,025)** |

Тайлант жилийн турщид хэрэглэсэн валютын ханш:

| | **Дундаж ханш** | | **Тайлангийн өдрөөрх ханш** | |
|---|---|---|---|---|
| (*төгрөгөөр*) | **2021** | **2020** | **2021** | **2020** |
| Ам.доллар | 2,849 | 2,813 | 2,849 | 2,850 |
| Евро | 3,372 | 3,212 | 3,223 | 3,496 |
| Юань | 442 | 408 | 447 | 436 |

**Гадаад валютын мэдрэмжийн шинжилгээ**

Группийн гадаад валютын ажил гүйлгээ нь ихэнхдээ америк доллар, евро болон юань (хамтад нь "Гадаад валют" гэх)-аар хийгддэг. Дээрх валютуудтай харьцах Монгол төгрөгийн ханш 10%-аар өсөх/буурах үеийн мэдрэмжийг доорх хүснэгтэд харуулав. Гүйцэтгэх удирдлагын түвшинд гадаад валютын эрсдэлийг үнэлэхдээ дээрх 10%-ийн мэдрэмжийг ашигладаг ба энэ нь гадаад валютын ханш дахь удирдлагын үнэлж буй боломжит өөрчлөлтийг илэрхийлнэ. Энэхүү мэдрэмжийн шинжилгээ нь зөвхөн гадаад валютаар илэрхийлэгдсэн тайлант хугацааны эцэс дэх мөнгөн зүйлсэд гадаад валютын ханшийн 10%-ийн өөрчлөлтийн нөлөөллийг үзүүлсэн.

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар төгрөгийн ханш 10%-аар чангарах нь татварын өмнөх ашгийг доор үзүүлсэн хэмжээгээр нэмэгдүүлнэ. Энэхүү шинжилгээнд бусад бүх хувьсах хүчин зүйлсийг тогтмол байна гэж үзсэн.

| | **2021 (татварын өмнөх ашиг, алдагдал)** | | **2020 (татварын өмнөх ашиг, алдагдал)** | |
|---|---|---|---|---|
| | **Чангарах (10% өсөлт)** | **Сулрах (10% бууралт )** | **Чангарах (10% өсөлт)** | **Сулрах (10% бууралт )** |
| Ам.доллар | 6,723,592 | (6,723,592) | 6,393,826 | (6,393,826) |
| Евро | 9,525,860 | (9,525,860) | 9,608,430 | (9,608,430) |
| Юань | (95,025) | 95,025 | (124,267) | 124,267 |
| Бусад | (557) | 557 | 303 | (303) |

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар Группийн эзэмшиж буй гадаад валюттай харьцах төгрөгийн ханш 10%-аар сулрах нь бусад бүх хувьсах хүчин зүйлсийг тогтмол байна гэж үзсэн тохиолдолд дээрх мөнгөн тэмдэгтүүдэд дээр дурдсан дүнтэй тэнцүү боловч эсрэгээр нөлөөлнө.

54

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 31. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### 31.4 Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ

Групп нь үнэлгээний техникүүдийг ашиглан санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах шатлалуудыг хэрэглэдэг. Үүнд:

Зэрэглэл 1: Ижил төрлийн хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн жишиг үнэ дээр суурилна;

Зэрэглэл 2: Бодит үнэ цэнийн хэмжилтэнд мэдэгдэхүйц нөлөөтэй зах зээлийн хамгийн бага өгөгдлийг шууд болон шууд бус мэдээлэлд жишиж болохуйц үнэлгээний арга;

Зэрэглэл 3: Бодит үнэ цэнийн хэмжилтэнд мэдэгдэхүйц нөлөөтэй зах зээлийн хамгийн бага өгөгдлийг шууд болон шууд бус мэдээлэлд жишиж харьцуулах боломжгүй үнэлгээний арга.

Групп нэгтгэсэн санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй тэдгээр санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг дараах байдлаар тодорхойлсон:

(i) Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүд

Нэг жилээс доош хугацаанд төлөгдөх болон нөхөгдөх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнэ нь тэдгээрийн дансны үнэтэйгээ ойролцоо гэж авч үздэг.

(ii) Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүр

Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг анх хүлээн зөвшөөрч бүртгэх үеийн зах зээлийн хүү болон ижил төстэй санхүүгийн хэрэглүүрийн одоогийн хүүг харьцуулж тодорхойлдог.

Группийн санхүүгийн хэрэглүүр нь бусад хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрөөс бүрдэнэ.

Удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо гэж үзэж байна.





**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 31. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

### 31.4 Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ (үргэлжлэл)

Нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь дараах байдалтай байна:

| | 2021 | | 2020 | |
|---|---|---|---|---|
| | **Дансны үнэ** | **Бодит үнэ цэнэ** | **Дансны үнэ** | **Бодит үнэ цэнэ** |
| **Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө** | | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 4,389,479 | 4,389,479 | 12,798,745 | 12,798,745 |
| Дансны болон бусад авлага | 1,324,752 | 1,324,752 | 3,081,189 | 3,081,189 |
| Түрээсийн дэлгүүрт байршуулсан барьцаа | 557,284 | 557,284 | 523,829 | 523,829 |
| | **6,271,515** | **6,271,515** | **16,403,763** | **16,403,763** |
| **Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн өр төлбөр** | | | | |
| Дансны болон бусад өглөг | (4,040,556) | (4,040,556) | (19,875,706) | (19,875,706) |
| Бондын өглөг | (9,877,213) | (9,877,213) | - | - |
| Богино болон урт хугацаат зээл | (226,058,669) | (226,058,669) | (272,172,594) | (272,172,594) |
| Богино болон урт хугацаат түрээсийн өглөг | (1,587,437) | (1,587,437) | (2,902,049) | (2,902,049) |
| Бусад урт хугацаат өглөг | (25,622,107) | (25,622,107) | (14,955,172) | (14,955,172) |
| | **(267,185,982)** | **(267,185,982)** | **(309,905,521)** | **(309,905,521)** |

## 32. Сегментийн мэдээлэл

Группийн удирдлага худалдан авагчдын төрөл, байршил, борлуулалт болон төрөлд үндэслэн борлуулалтын орлогыг “Дотоод борлуулалт”, “Гадаад борлуулалт/бөөний борлуулалт” болон “Гадаад борлуулалт/цахим” гэсэн үйл ажиллагааны гурван сегментээр бүтээгдэхүүний төрлөөр ангилж, удирдлагын шинжилгээ болон шийдвэр гаргалтандаа ашигладаг.

Дээрх сегментээр ангилсан борлуулалтын орлого болон борлуулсан бүтээгдэхүүний өртгөөс бусад орлого болон зардлыг сегментээр ангилж тайлагнадаггүй. Үүнтэй адилаар, Группийн гол удирдлагын зүгээс тогтмол хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч хөрөнгө болон өр төлбөрийг сегментээр ангилж тайлагнахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 32. Сегментийн мэдээлэл (үргэлжлэл)

### 32.1 Сегментийн орлого ба ашиг

| | | Сегментийн орлого | | Сегментийн ашиг | |
|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2020 | 2021 | 2020 |
| Дотоод борлуулалт | Сүлжмэл бүтээгдэхүүн | 33,409,990 | 22,175,121 | 11,767,768 | 5,610,207 |
| | Оёмол бүтээгдэхүүн | 21,939,273 | 20,014,119 | 5,858,368 | 6,256,131 |
| | Нэхмэл бүтээгдэхүүн | 7,938,312 | 6,151,370 | 3,018,996 | 1,508,852 |
| | Үйлчилгээний орлого | 1,168,015 | 862,561 | 310,012 | 13,918 |
| | Бусад | 2,203,938 | 267,989 | (1,345,005) | 212,466 |
| | | 66,659,528 | 49,471,160 | 19,610,139 | 13,601,574 |
| Гадаад/бөөний борлуулалт | Сүлжмэл бүтээгдэхүүн | 29,990,703 | 31,890,120 | 12,586,466 | 12,297,385 |
| | Оёмол бүтээгдэхүүн | 1,970,595 | 749,403 | 663,291 | 223,757 |
| | Нэхмэл бүтээгдэхүүн | 3,459,143 | 3,250,598 | 1,303,356 | 1,172,734 |
| | Бусад | 1,401,991 | 131,323 | 912,332 | 81,608 |
| | | 36,822,432 | 36,021,444 | 15,465,445 | 13,775,484 |
| Гадаад/цахим борлуулалт | Сүлжмэл бүтээгдэхүүн | 32,430,548 | 26,177,206 | 19,536,402 | 15,718,624 |
| | Оёмол бүтээгдэхүүн | 4,847,911 | 3,327,859 | 2,218,067 | 1,540,215 |
| | Нэхмэл бүтээгдэхүүн | 3,582,018 | 2,033,978 | 1,971,119 | 895,025 |
| | Бусад | 1,892 | 60,858 | (330) | 25,095 |
| | | 40,862,369 | 31,599,901 | 23,725,258 | 18,178,959 |
| | | **144,344,329** | **117,092,505** | **58,800,842** | **45,556,017** |
| Санхүүгийн ба бусад орлого | | | | 963,425 | 2,615,647 |
| Бусад олз (гарз) | | | | 2,913,718 | (8,480,653) |
| Санхүүгийн зардал | | | | (25,474,286) | (29,542,260) |
| Борлуулалт ба маркетингийн зардал | | | | (60,568,067) | (44,384,939) |
| Ерөнхий ба удирдлагын зардал | | | | (14,636,714) | (13,076,638) |
| Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт | | | | (110,920) | (170,306) |
| Татварын өмнөх алдагдал | | | | **(38,112,002)** | **(47,483,132)** |

2021 болон 2020 оны Группийн орлогын 10% ба түүнээс дээш хувийг дангаараа бүрдүүлсэн харилцагч байгаагүй.







**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

## 32. Сегментийн мэдээлэл (үргэлжлэл)

### 32.2 Газар зүйн мэдээлэл

Групп ноолууран бүтээгдэхүүнийг доорх газар зүйн байршил дахь худалдан авагчдад борлуулсан:

| | Харилцагчийн орлого | | Эргэлтийн бус хөрөнгө | |
|---|---|---|---|---|
| | 2021 | 2020 | 2021 | 2020 |
| Монгол Улс | 66,659,528 | 49,476,685 | 146,667,250 | 157,811,034 |
| Бүгд Найрамдах Солонгос Улс | 15,646,928 | 14,827,763 | - | - |
| Холбооны Бүгд Найрамдах Герман Улс | 15,559,787 | 12,659,093 | 623,467 | 1,471,748 |
| Франц Улс | 13,095,680 | 11,733,411 | - | - |
| Америкийн Нэгдсэн Улс | 10,349,694 | 6,631,629 | 382,809 | 542,626 |
| Бүгд Найрамдах Хятад Ард Улс | 4,879,404 | 3,762,446 | 53,622 | - |
| Япон Улс | 4,483,493 | 2,915,926 | - | - |
| Оросын Холбооны Улс | 2,703,211 | 1,845,834 | - | - |
| Нэгдсэн Вант Улс | 2,026,382 | 3,036,048 | - | - |
| Итали Улс | 1,491,004 | 2,849,886 | - | - |
| Бусад орнууд | 7,449,218 | 7,353,784 | - | - |
| | **144,344,329** | **117,092,505** | **147,727,148** | **159,825,408** |

Дээрх хүснэгт нь гадаад зах зээлд хийгдсэн борлуулалтыг борлуулалт хийгдсэн газар зүйн байршлаар үзүүлсэн бөгөөд мөн эргэлтийн бус хөрөнгийг хөрөнгийн байршин буй газар зүйн байршлаар харуулсан.

Эргэлтийн бус хөрөнгөнд хойшлогдсон татварын хөрөнгө багтаагүй болно.

## 33. Капиталын эрсдэлийн удирдлага

Групп тасралтгүй үйл ажиллагаа явуулах зорилгоор өөрийн капиталыг удирдахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчийн өгөөжийг өндөр түвшинд байлгахын тулд зээл болон өөрийн хөрөнгийн харьцааг оновчтой байлгахыг зорьдог.

Группийн капиталын бүтэц нь цэвэр зээл (зээлээс мөнгөн хөрөнгийг хассан) ба өөрийн хөрөнгөөс бүрдэх бөгөөд өөрийн хөрөнгө нь дүрмийн сан, нөөц ба хуримтлагдсан ашгаас тус тус бүрддэг.

## 34. Гэрээний үүрэг

Группд 2021 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гэрээгээр хүлээсэн томоохон гэрээний үүрэг байхгүй байна.

## 35. Тайлангийн дараах үйл явдал

2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Групп нь ЕСБХБ-ны зээлээс нийт 1.5 сая ам.долларын зээлийг буцаан төлсөн.

2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Таван Богд ХХК-аас авсан 24 сарын хугацаатай, жилийн 6.7%-ийн хүүтэй 10 сая ам.долларын зээлийн нөхцөлийг 12 сарын хугацаатай, жилийн 11%-ийн хүүтэй 30 тэрбум төгрөг болгон шинэчилсэн гэрээ байгуулсан.

2022 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банкнаас авсан 16 сая еврогийн богино хугацаат зээлийн тал хэсэг болох 8 сая еврог төлж барагдуулсан ба үлдэгдэл 8 сая еврог 2027 онд төлөгдөх урт хугацаат зээл болгон өөрчилсөн. Групп нь эргэн төлөгдөх 8 сая еврог гэрээ дуусах хугацаа хүртэл дахин зээлэх боломжтой.

**ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**35. Тайлангийн дараах үйл явдал (үргэлжлэл)**

Групп нь 2022 оны 3 дугаар сарын 21-ний байдлаар 10 тэрбум төгрөгийн бондын өглөгөөс 5.4 тэрбум төгрөгийг эргүүлэн худалдаж авсан байна.

2019 оны сүүлээр тархсан Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл 2022 онд үргэлжилсээр байгаа бөгөөд нийгэм, эдийн засгийн сэргэлтийг дэмжих зорилгоор 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн вакцинжуулалтын төслийн хүрээнд нийт хүн амын 69.8% нь эхний тунд, 66.7% нь хоёрдугаар тунд, 31% нь нэмэлт тунд хамрагдсан байна. Энэ нь ихэнх бизнесийн үйл ажиллагаанд учирч байсан цар тахалтай холбоотой хязгаарлалтыг сулруулах боломжийг олгосон.

**36. Тайлангийн орчуулга**

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хэл дээрх хувилбарыг баримтална.

# МОНГОЛ ДАХЬ ДЭЛГҮҮРҮҮДИЙН БАЙРШИЛ

**ҮЙЛДВЭРИЙН ДЭРГЭДЭХ ТӨВ ДЭЛГҮҮР**
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Үйлдвэрийн гудамж
Утас: 7004 8888

**ГАЛЛЕРИА УЛААНБААТАР САЛБАР**
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Засгийн газрын ордны зүүн талд
Утас: 7004 8888

**ДАРХАН ХОТ САЛБАР**
Дархан хот, Шинэ Дархан Олон Улсын Худалдааны Төв
Утас: 95056656, 99376775

# ГАДААД ДАХЬ ДЭЛГҮҮРҮҮДИЙН БАЙРШИЛ

## САЛБАР ДЭЛГҮҮРҮҮД

**BERLIN, GERMANY**
GOBI MONGOLIAN CASHMERE
Knesebeckstr.30, Berlin, Germany
www.gobicashmere.com
+49 (0)30 224 66510

## ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРҮҮД

### ASIA

**ANKARA, TURKEY**
GOBI CASHMERE
Armada 1, 1.kat No:136, Eskişehir Yolu No:6 06560 Söğütözü
Tel: +90 (312) 219 16 01-02,
Fax: +90 (312) 219 16 03
Email: info@gobi.com.tr,
Web: www.gobi.com.tr

**ISTANBUL, TURKEY**
MONGOLIAN CASHMERE GOBI
Harbİye Mahallesi Abdi İPEKÇİ Caddesi Bronz Sokak No: 7D Posta Kodu: 34367 ŞİŞLİ -Istanbul, Turkey

**ALMATY, KAZAKHSTAN**
YAMA BY GOBI
Г. Алматы, ул. Сатпаева 3, тц Colibri, 2 этаж, бутики Yama cashmere by Gobi, yama cashmere by gobi for man





**FUZHOU, CHINA**
GOBI MONGOLIAN CASHMERE
Fujian Province, Fujian Province, Taijiang District Industrial Road, Baolong Xinhua second floor Gobi store

**HAILAAR, CHINA**
GOBI MONGOLIAN CASHMERE
No.3-2, Dongda street, Hailar dictrict, Hulunbur city, Inner Mongolia, China

**HUHHOT, CHINA**
GOBI MONGOLIAN CASHMERE
Zhongshan West Road, Hohhot City, Inner Mongolia, National Shopping Center, West 3rd Floor, Cashmere District

**BEIJING, CHINA**
GOBI MONGOLIAN CASHMERE
12B03,Tower, Henghua International Business Center, NO.26, Yuetan North Street, Xicheng District, Beijing 100045

**HONG KONG, CHINA**
GOBI MONGOLIAN CASHMERE
RM 18-20, 17/F, Horizon Plaza, 2Lee Wing street, Ap Lei Chau, Hong Kong, China
+852 2730 3911

**HONG KONG, CHINA**
GOBI MONGOLIAN CASHMERE
Man Yee building, 68 Des Voeux road Central, 2nd floor, Shop 214, Central, Hong Kong

**HONG KONG, CHINA**
GOBI MONGOLIAN CASHMERE
Horizon Plaza Factory Outlet Stores 2 Lee Wing Street, Central Hong Kong (19 floor no.1902)

**ULANHOT, INNER MONGOLIA, CHINA**
GOBI MONGOLIAN CASHMERE
No.2-12 of Yukeduolan Park One-staged, Keerqin town, Keyouqianqi, Inner Mongolia, China

**MANZHOULI, CHINA**
GOBI MONGOLIAN CASHMERE
Hulunbuir province, Manzhouli city, China Russia Free Trade Zone, Aimin Store

**SI YANG, CHINA**
GOBI MONGOLIAN CASHMERE
3F, Shopping Center, Beijing Rd, Si yang city, Jiang Su province

**SI YANG, CHINA**
GOBI MONGOLIAN CASHMERE
№ 9 Wen Meng Rd, Si yang city, Jiang Su province

**SEOUL, KOREA**
GOBI KOREA
Room 201, Jinsung B/D, Abujungro 4 gil 13-9,
Gangnam-gu, Seoul, Korea
+02 518 0525

**PUSAN, KOREA**
GOBI CASHMERE
#2069, Punpo road 145, Nam-gu, Pusan, Korea

**TOKYO , JAPAN**
Haneda Airport , 1 Terminal, Market place 4F

### EUROPE

**SZCZECIN, POLAND**
Imperial Cashmere
Wyzwolenia str,44 71-500 Szczecin, Poland

**PRAGUE, CZECH**
GOBI KAŠMÍR
V Jame 3, 110 00 Praha 1, Czech
+42 (0) 702 065 696
www.kasmir.cz

**PRAGUE, CZECH**
GOBI KAŠMÍR
MAISELOVA 5, 110 00, Praha 1, Czech
+42 (0) 722 066 591
www.kasmir.cz

### RUSSIA

**ULAN-UDE, RUSSIA**
МАГАЗИНЫ КАШЕМИР ХАУС
Ул Ленина 44, Улан-Удэ, Респ, Бурятия, Россия, 670000
+7 964 414 78 88

**IRKUTSK, RUSSIA**
МАГАЗИНЫ КАШЕМИР ХАУС
Ул.Советская 3, Деловой Центр, остановка театр кукол, Иркутская обл., Россия, 670000
+7 952 629 29 84

**NOVOSIBIRSK, RUSSIA**
МАГАЗИН "GOBI"
Новосибирск, ул. Вокзальная тагисраль 10/1 Торговый центр " Бонанза"
+7 913 001 66 21

**OMSK, RUSSIA**
МАГАЗИН "GOBI"
Омск, ТВЦ"Каскад, ул.Карла Маркса 24, 1 этаж, бутик 11
+7 905 097 01 10

**KHABAROVSK, RUSSIA**
МАГАЗИН "GOBI"
Хабаровск, ул. Муравьева-Амурского, стр.7, 3 этаж
+8 914 158 77 06

**KYZYL, RUSSIA**
GOBI MONGOLIAN CASHMERE
Рес Тыва, г. Кызыл, ул. Чульдума 31, тд Алексеевский

**KIEV, UKRAINE**
GOBI PREMIUM CASHMERE
Ул.7А Леся Украинка

GOBI

MONGOLIAN CASHMERE

"ГОВЬ" ХК, ҮЙЛДВЭРИЙН ГУДАМЖ, 3-Р ХОРОО, ХАН-УУЛ ДҮҮРЭГ,
УЛААНБААТАР-17062, МОНГОЛ УЛС, Ш/Х 36/434
УТАС: +976 7013-9977, ФАКС: +976 7014-3081
И-МЭЙЛ: INFO@GOBI.MN